



1940-1960 онд гал түймэртэй тэмцэх ажилд эрх зүйн зохицуулалт хийж, нилээд олон тооны дүрэм журам, зааврыг боловсруулан мөрдөж эхэлсэн байна.

Ардын Засгийн газрын 1922 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 35 дугаар тогтоолоор Галын аюулаас хамгаалах байгууллагыг анх байгуулав.



1922 он

1930 он

1940 он

1960 он

1980 он



Гал түймэр эсэргүүцэх хэлтэс байгуулснаар Улаанбаатар хотын Төв гал командыг тус хэлтэст шилжүүлэн цэрэгжүүлсэн команд болгов.



Төв гал командыг Цагдан сэргийлэх байгууллагын 60 жилийн ойгоор БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар “Алтан гадас” одонгоор шагнасан байна.

1921 он

Ардын харилцан туслалцах хоршоог байгуулав.



1922 он

Улсын нөөцийн тусламжийн анхны гэр

Батлан хамгаалах, хөдөлмөр нийгэмлэгийн бүтцэд 1964 онд Улсын иргэний хамгаалалтын алба нь байнгын курс Улаанбаатар хотын иргэний хамгаалалтын штаб гэсэн хоёр хэлтэстэй байгуулагджээ.



БНМАУ-ын Иргэний хамгаалалтын тухай хууль батлагдаж гарснаар, Иргэний хамгаалалтын штаб нь шинэчилсэн зохион байгуулав.



Сайд нарын Зөвлөлийн 1967 оны гуравдугаар сарын 1-ний өдрийн “Иргэний хамгаалалтын албыг байгуулах тухай” 42 дугаар тогтоолоор иргэний хамгаалалтын албадыг аймаг, хотын АДХГЗ, тэдгээрийн харьяа газар байгуулахаар заав.

1964 он

1967 он

1970 он

1970 он



Германд болсон социалист орнуудын иргэний хамгаалалтын дарга нарын ээлжит уулзалтад манай БХЯ-ны орлогч сайд, УИХГ-ын дарга, хошууч генерал Г.Махбариад оролцсон байна.

1994 онд Монгол улсын Иргэний хамгаалалтын тухай хуулийг шинэчлэн батлав.



1970 онд Иргэний хамгаалалтын газрын даргаар генерал С.Равдан, 1972-1975 онд дэслэгч генерал Ж.Жамъян, 1975-1985 онд дэслэгч генерал Ч.Түмэндэмбэрэл, 1985-1990 онд хошууч генерал Г.Махбариад нар ажиллаж байв.



1989 он

1940 он

1945 он

1987 он

1994 он




Дайны хүнд жилүүдэд Монголын ард түмэн бүхий л талаар тусламжийн халуун гараа сунгасан юм.



Материал техникийн хангамжийн Улсын хорооны харьяа Улсын нөөцийн нэгдсэн агуулах “Объект-03” салбар анх ашиглалтанд орлоо.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ




*Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх газар, Улсын иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэж гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, хойшлуулиггүй сэргээн босгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг зорилго бүхий Онцгой байдлын албыг байгуулсан юм.*

## ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГА

Монголчуудерт дээр үеэс гал түймэртэй тэмцэх өвөрмөц аргатай, нүүдэлчдийн соёл иргэншилд тохирсон энгийн технологитой, гал түймрээс урьдчилан сэргийлэх тогтсон хэв заншилтай байсан нь Чингис хааны “Их засаг” хууль, “Халх журам” хуулийн зарим зүйлд тодорхой харагддаг. **Ардын Засгийн газрын 1922 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 35 дугаар тогтоолоор** Галын аюулаас хамгаалах байгууллагыг анх байгуулах тухай шийдвэр гарч 1925 он хүртэл Орос, Хятад худалдаачдын Усан хөөргийн газрыг түрээсээр ашиглаж байв. Энэ Усан хөөргийн газар нь одоогийн Нийслэл хотын Аврах гал унтраах 10 дугаар ангийн анхны эхлэл болсон бөгөөд Худалдаа хөгжлийн банкны барилгын баруун тал Дүрслэх урлагийн музейн зүүн талд байрлаж байжээ. 1925 онд Усан хөөргийн газрыг манай улс худалдан авч Улаанбаатар хотын захиргаанд харьяалуулж 1930-аад он хүртэл гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах ажлыг Цагдан сэргийлэх байгууллагатай хамтран гүйцэтгэж байв.

1935 онд гал түймэр эсэргүүцэх хэлтэс байгуулснаар Улаанбаатар хотын Төв гал командыг тус хэлтэст шилжүүлэн цэрэгжүүлсэн команд болгож, Тээх нэвтрүүлэх газар, Налайхын уурхай, Хэвлэлийн хороо, Бензин тосны газар зэрэг 11 байгууллагад 4-35 хүний бүрэлдэхүүнтэй галын салаа, пост, Алтанбулаг, Цагаан эрэг,



*100 литрийн багтаамжтай, мориор чирдэг, гар насос бүхий усан хөөргийг 1922-1925 хүртэл гал унтраахад ашиглаж байжээ.*

*Төр засгийг үүсгэн байгуулагчдын нэг жанжин Д.Сүхбаатарын санаачлагаар 1922 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Ардын засгийн 35 дугаар хуралдаанаар гал унтраах, урьдчилан сэргийлэх, гал түймрийн улсын хяналтыг орон даяар хэрэгжүүлэх, гал түймрийн туршилт шинжилгээ хийх үүрэг бүхий Гал түймэртэй тэмцэх байгууллагыг байгуулах шийдвэр анх гарчээ.*



*Гал унтраах анги, бүрэлдхүүнийг цуглуулах түргэн дохионы хонх 1924 он*

Хатгалын ноос угаах үйлдвэрт гэрээний дагуу ажиллах 18-25 хүний бүрэлдэхүүнтэй Гал командыг байгуулжээ. 1940-1960 онд гал түймэртэй тэмцэх ажилд эрх зүйн зохицуулалт хийж, нилээд олон тооны дүрэм журам, зааврыг боловсруулан мөрдөж эхэлсэн байна. 1957-1980 онд Цагдан сэргийлэх байгууллагын Онц сэргийлэгч, гал сөнөөгчдийн улсын зөвлөгөөнийг таван удаа зохион байгуулсан нь бие бүрэлдэхүүний урам зоригийг сэргээсэн ажил болжээ.



*Гал унтраах ангийн хичээллэлт, дадлага сургууль, өглөөний нэгдэлт 1935-1940 он*

1959 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 32 тоот зарлигаар гал түймэр, усны үер зэрэг гэнэтийн аюулаас ард иргэдийн амь нас, эд хөрөнгийг авран хамгаалж, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн иргэдийг “Шударга журам” медалиар шагнаж байхаар шийдвэрлэсэн бөгөөд анхны медалийг Галын аюулаас сэргийлэн хамгаалах хэлтсийн Улаанбаатар хотын Төв гал командын гал сөнөөгч Ж.Равдан хүртэж байжээ. 1956 оноос ЗХУ-д Галын дунд сургуульд, 1960 оноос ЗХУ-ын Галын инженер техникийн дээд сургуульд мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэдэг болов.

Гадаад харилцаа өргөжихийн хэрээр Галын аюулаас хамгаалах байгууллагын олон улсын бага хурал, галын техник спортын тэмцээнд төлөөлөгчид, тамирчид идэвхитэй оролцдог болжээ. Өргөсөн тангарагтаа үнэнч байж гал унтраах үйл ажиллагаанд оролцож байгаад 1968 онд алтан амиа алдсан Улаанбаатар хотын Толгойт дахь Бөөний худалдааны нэгдлийн гэрээт Гал командын гал сөнөөгч Д.Баатар, 1986 онд алтан амиа алдсан Улаанбаатар хотын “Алтан гадас” одонт Төв гал командын гал сөнөөгч Ж.Баярсайхан, Сэлэнгэ аймгийн Гал командын салааны дарга М.Батхаан нар Галын аюулаас хамгаалах байгууллагын түүхэнд мөнхөрчээ. Галын аюулаас хамгаалах байгууллагын ууган гал команд болох Төв гал командыг 1981 онд Цагдан сэргийлэх байгууллагын 60 жилийн ойгоор БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн зарлигаар “Алтан гадас”

одонгоор шагнасан байна.

1991 оноос эхлэн Цагдаагийн дээд сургуульд ЗХУ-ын Галын дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрийн дагуу галын техникч бэлтгэх хоёр жилийн ангийг нээн үндэсний боловсон хүчнээ бэлтгэж эхэлснээс хойш тус сургуулийг 2000 онд 240, 2005 оноос дипломын дээд, бакалаврын зэрэгтэй 200 гаруй мэргэжлийн боловсон хүчин төгсчээ.



*Төв гал команд 1960 он*



*Цагдаагийн байгууллагын 60 жил 1982 он*

Гал түймэртэй тэмцэх байгууллагад Төрийн шагналт, Ардын жүжигчин, хөдөлмөрийн баатар Г.Гомбосүрэн, Ардын жүжигчин С.Данзан, Гавьяат жүжигчин Ц.Нямсүрэн, Төрийн соёрхолт С.Удвал нарын урлаг соёлын томоохон төлөөлөгчид ажиллаж байсны дээр “Есөн эрдэнэ” хөгжимт драмын бага театр, Үлээвэр хөгжмийн хамтлаг, улс төрийн дууны “Дөл” хамтлаг зэрэг соёл урлагийн баг хамт олон ажиллаж байжээ.

Гал түймэртэй тэмцэхэд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, гал унтраах техникийн олон төрөлт спортыг хөгжүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянхошуун дахь Сургалт спортын цогцолборыг барьж байгуулан ашиглалтад оруулсан байна. 2000 онд Дэлхийн олон улсын гал унтраах техник спортын холбоонд гишүүнээр элсэж 2002 онд ОХУ-ын Москва хот, 2004 онд Беларусын Минск хотод зохион байгуулагдсан анхны болон хоёр дахь удаагийн гал унтраах техник спортын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдаа бэлтгэн оролцжээ.

1996 оноос эхлэн ОХУ, Герман, Унгар, Солонгос, Япон улсын галын хуулийг судалсны үндсэн дээр Галын аюулгүй байдлын хуулийн төслийг боловсруулан 1999 онд УИХ-аар батлуулсан байна. Хууль батлагдсанаар Гал түймэртэй тэмцэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчин бүрдэж, ой хээрийн болон объектын түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, шалтгаан нөхцөлийг тогтоох, гал түймрийн хэрэг бүртгэх ажлыг хариуцан Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гал түймэртэй

тэмцэх газар болгон зохион байгуулжээ. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны нэгдүгээр сарын 7-ны өдрийн анхдугаар хуралдаанаар тус газрыг Онцгой байдлын ерөнхий газрын бүтцэд нэгтгэснээр нэгэн шинэ түүх эхэлсэн байна.



*Анхны гал унтраах анги 1925 он*



*Гал унтраах дасгал сургууль 1935 он*



*9 давхарт гарсан галыг унтрааж байгаа нь 1986 он*

## УЛСЫН ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗАР

Батлан хамгаалах, хөдөлмөр нийгэмлэгийн бүтцэд 1964 онд Улсын иргэний хамгаалалтын алба нь байнгын курс, Улаанбаатар хотын иргэний хамгаалалтын штаб гэсэн хоёр хэлтэстэй байгуулагджээ. Жараад оны дунд үе болоход хоёр ертөнцийн сөргөлдөөн ширүүсч, олон улсын байдал хүндэрсэн учир манай улс хамтын нөхөрлөлийн орнуудтай гадаад бодлогоо уялдуулж, улс орны батлан хамгаалалыг бэхжүүлэх талаар олон чухал арга хэмжээ авахад хүрсний нэг чухал салбар нь Улсын иргэний хамгаалалтын тогтолцоог бий



*БХХН-ийн аймгийн зөвлөлийн штаб, тагнуулын бүлэг, хэв журам сахиулах хэсэг жагсаалын үзлэгт 1966 он*



*Цацраг идэвхитээр хордсон адуу, үхэрт шинжилгээ үзлэг хийж байгаа нь 1966 он*

*Монгол Улсад анх Батлан хамгаалах, Хөдөлмөр нийгэмлэгийн бүтцэд 1964 онд хүн амыг хамгаалах, улс, ардын аж ахуйн тогтвортой ажиллагааг хангах, дайсны цөмийн болон бусад цохилтод өртсөн хот, объектууд, цацраг идэвхит хордуулалт, үерийн аюул бүхий бүсэд аврах, сэргээн босгох ажил явуулах зорилгоор тайван цагт буюу дайны үед зохион байгуулж явуулдаг улс нийтийн чанартай батлан хамгаалах арга хэмжээ авч явуулах үүрэг бүхий иргэний хамгаалалтын алба үүсэн байгуулагджээ.*

болгож хөгжүүлсэн явдал билээ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1964 оны хоёрдугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар “Батлан хамгаалах, хөдөлмөр нийгэмлэгийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 8/94 дүгээр тогтоолд “Хүн ам, ардын аж ахуй, соёлын объектуудыг үй олноор хөнөөж, сүйтгэх зэвсгээс хамгаалах талаар зохион байгуулалтын арга хэмжээ боловсруулж, түүнийг биелүүлэх замаар улс орноо бэлтгэх ёстой” гэж заасан нь энэ талаар баримтлах төрийн бодлогыг үндсэнд нь тодорхойлсон. Энэ тогтоолоор СнЗ-ийн дэргэд Нүүлгэн шилжүүлэх байнгын комиссыг байгуулж, даргаар нь СнЗ-ийн ерөнхий асуудал эрхэлсэн орлогч, орлогч даргаар нь Тоо бүртгэлийн Улсын төв газрын дарга, гишүүдэд гол яамдын сайд нар байхаар тогтоож өгсөн нь өнөөгийн манай Онцгой комиссын бүтцийн хамгийн эхний хувилбар гэж үзэж болох юм.

Засгийн газраас иргэний хамгаалалтын талаар 1967-1969 онд хэд хэдэн чухал шийдвэр гаргасны нэг нь Сайд нарын Зөвлөлийн 1967 оны гуравдугаар сарын 1-ний өдрийн “Иргэний хамгаалалтын албыг байгуулах тухай” 42 дугаар тогтоолоор иргэний хамгаалалтын албадыг аймаг, хотын АДХГЗ, тэдгээрийн харьяа



**газар байгуулахаар зааж**, дүрмийг нь баталсан нь өнөөгийн гамшгаас хамгаалах албадын бүтцийн суурь болсон байна. СнЗ-ийн 208 дугаар тогтоолоор зарим хотод аюулгүйн зэрэг тогтоосон нь иргэний хамгаалалтын оператив төлөвлөгөөг боловсруулахад чухал ач холбогдолтой болсон бөгөөд онцгой үед Улаанбаатар хотын хүн амыг хамгаалах тогтоол гарч хүн амыг нүүлгэн шилжүүлэх, тараан байрлуулах, дадлага хийх ерөнхий төлөвлөгөөг баталсан байна. 1968 онд Иргэний хамгаалалтын механикжуулсан тусгай батальон байгуулагдаж даргаар нь хурандаа М.Чимэд ажиллаж байв. БНМАУ-ын Батлан хамгаалах яамны орлогч сайд, Батлан хамгаалах хөдөлмөр нийгэмлэгийн Төв зөвлөлийн дарга, генерал С.Равдан тэргүүтэй манай төлөөлөгчид ЗХУ-д Олон улсын түвшинд анх удаа Иргэний хамгаалалтын асуудлаар зөвлөлдөх уулзалтыг хийж онцгой үед холбоогоор



*Иргэний хамгаалалтын сургууль  
Төв аймаг 1986 он*



*Хөнөөлийн голомтод үүрэг  
гүйцэтгэж байгаа нь 1985 он*



*Аврах команд хөнөөлийн голомтод  
орхын өмнө 1987 он*



*Нүүлгэн шилжүүлэлтийн цуваа 1989 он*

хангах, зарлан мэдээлэх, төхөөрөмжүүдийн тоог тогтоох, хөнөөлийн голомт үүссэн тухай мэдээллийг харилцан солилцох, мэргэжилтнүүд ажиллуулах, сургах зэрэг олон асуудлаар хамтран ажиллах эхлэл суурийг тавьсан байдаг. 1969 онд ЗСБНХУ-ын Иргэний хамгаалалтын дарга, ЗХУ-ын маршал В.И.Чуйков манай улсад айлчилж байсан нь хойд хөрш ихээхэн анхаарал тавьж байсны илрэл юм. ЗХУ-д Иргэний хамгаалалтын дээд курсыг Монголоос анх Р.Луйжир, Д.Лувсан, М.Тэрбиш нар 1964 онд төгсжээ. Улмаар дээд курсыг арван сарын хугацаагаар суралцаж төгссөн офицерууд хүн амыг болзошгүй аюулаас хамгаалах, сургахад гол анхаарлаа хандуулан ажилласан байна.

Улаанбаатар орчимд хийсэн Иргэний хамгаалалтын анхны үзүүлэх сургуулийг хурандаа генерал С.Равдан

удирдаж байжээ. Тэр үеийн иргэний хамгаалалтын үзүүлэх сургууль нь дайны хөнөөлөөс ард иргэдийг хамгаалах, тэднийг сургахад үндсэндээ чиглэгдэж байв. 1969 онд иргэний хамгаалалтын механикжсан анги байгуулагдсан бөгөөд анхны даргаар нь морьт цэргийн нэрт дарга нарын нэг, ахмад дайчин, хурандаа М.Чимэд ажиллаж байжээ. Мөн энэ онд гарсан “Иргэний хамгаалалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” СнЗ-ийн тогтоолд Улсын иргэний хамгаалалтын штаб байгуулж, зохион байгуулалтыг нь баталжээ. 1970 онд БНМАУ-ын Иргэний хамгаалалтын тухай хууль батлагдаж гарснаар, Иргэний хамгаалалтын штаб нь шинэчилсэн зохион байгуулалтаар 5 хэлтэс, 2 албатай нийт 48 офицер албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулах болж, даргаар нь генерал С.Равданг томилсон байна. 1972-1975 онд дэслэгч генерал Ж.Жамъян, 1975-1985 онд дэслэгч



*Хөнөөлийн голомтоос нэрвэгсдийг гаргаж анхны тусламж үзүүлж байгаа нь*



*Улиастай, Тосонцэнгэл хотын гал команд сайн дурынхан жагсаалын үзлэгт 1967 он*



*Иргэний хамгаалалтын дадлага сургууль 1987 он*



генерал Ч.Түмэндэмбэрэл, 1985-1990 онд хошууч генерал Г.Махбариад нар ажиллаж байв. Энэ хугацаанд тус байгууллага нь нэлээд бэхжиж хөгжсөн бөгөөд хүн амыг дадлагажуулж сургах ажлаа тасралтгүй сайн зохион байгуулж ирсний үр дүнд Иргэний хамгаалалтын бүх шатны сургалт маш өндөр түвшинд хүрсэн байна. Мөн гадаад харилцаа ч тодорхой түвшинд хүрсний илрэл нь Баянхонгор аймагт болсон Иргэний хамгаалалтын иж бүрэн сургуульд ЗХУ-ын иргэний хамгаалалтын дарга, БХЯ-ны орлогч сайд, армийн генерал Л.В.Говоров тэргүүтэй төлөөлөгчид зочноор оролцож байснаас харагддаг. 1989 онд Германд болсон социалист орнуудын иргэний хамгаалалтын дарга нарын ээлжит уулзалтад манай БХЯ-ны орлогч сайд, УИХГ-ын дарга, хошууч генерал Г.Махбариад оролцсон байна.

Манай улс 1990 онтой золгоход иргэний хамгаалалтын байгууллага нь үзэл баримтлалаа шинэчлэх зайлшгүй шаардлагатай тулгарсан. Энэ нь нэгдүгээрт дэлхийн улс орнуудын хөгжлийн чиг хандлага, нөгөөтэйгүүр дотоодын нийгмийн өөрчлөлттэй холбоотой байв. Тус байгууллага нь дайны үеийн бус өөрчлөн байгуулалтын үеийн иргэний хамгаалалтын үйл ажиллагааг илүү чухалчлах болсон юм. Энэ үед гамшиг гэдэг нэр томьёо жинхэнэ утгаараа анх орж ирсэн бөгөөд Улсын байнгын онцгой комисс анх байгуулагдаж байв. УБОК-ын анхны даргаар Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Б.Шаравсамбуу, орлогч даргаар хошууч генерал Г.Махбариад нар ажиллаж байжээ. Улсын иргэний хамгаалалтын газраас 1991-1992 онд боловсруулсан “Иргэний хамгаалалтын тухай хууль”-ийн төслийг Засгийн газраас Бага хуралд өргөн барьсан боловч хэлэлцэж чадалгүй байсаар хойшилсон байна. 1994 онд Монгол улсын Иргэний хамгаалалтын тухай хуулийг шинэчлэн баталж, Засгийн газрын тогтоолоор Иргэний хамгаалалтын улсын албадыг шинэчлэн зохион байгуулсан бөгөөд 1996 онд Иргэний хамгаалалтын хяналтын дүрэм батлагдаж гарсан юм. Улсын иргэний хамгаалалтын газар Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /1996 оны/, Зэвсэгт хүчний шинэчлэлийн хүрээнд 1997-2000 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөр боловсруулан баталж мөрджээ. Улмаар бүтэц, зохион байгуулалт нь боловсронгуй болж, үүрэг нь өссөн бөгөөд тус байгууллагын даргаар 1990-1996 онд хошууч генерал Г.Дамдинсүрэн, 1996 оноос хошууч генерал П.Сүндэв ажиллажээ. УИХГ-ын дарга хошууч генерал Г.Дамдинсүрэн 1992 онд БНХАУ-д, 1995 онд ХБНГУ-д айлчилж хамтын ажиллагааг бэхжүүлж байв. 1996 онд ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах хэрэг эрхэлсэн сайд, дэслэгч генерал С.К.Шойгу айлчилж манай талаас УИХГ-ын дарга, хошууч генерал П.Сүндэв нар хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурсан байна. Монгол улс Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагад 1992 онд ажиглагч гишүүнээр элсэн орсноос хойш бүх бага хурлуудад оролцжээ. 1990 оны сүүлчээр Иргэний хамгаалалтын бүтэц, зохион байгуулалт шинэ нөхцөл байдалд очсон бөгөөд Булган аймагт болсон Иж бүрэн сургуулийн явцтай Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч П.Очирбат танилцаж байжээ.

1997 онд салбаруудын нэгдсэн цугларалтыг зохион байгуулж, шүхэрчдийн буултын дадлага болон “Аврагч” тэмцээнийг анх удаа зохион байгуулав. 1990-2003 он хүртэл улсын хэмжээний гамшгийн асуудлыг үндсэндээ иргэний хамгаалалтын байгууллага удирдан чиглүүлж байсан бөгөөд үүний нэг жишээ нь 1996 онд гарсан их түймрийг унтраах ажлыг Монгол улсын Шадар сайд, УБОК-ын дарга Ч.Пүрэвдорж, УИХГ-ын дарга, хошууч генерал Г.Дамдинсүрэн нар удирдан зохион байгуулж байсан түүхтэй. Тус байгууллагыг 2000 онд Д.Рэнцэнханд, 2001 оноос хошууч генерал О.Үржин удирдах болсон бөгөөд 2003 онд Гамшгаас хамгаалах тухай хууль УИХ-аас батлагдан гарснаар Иргэний хамгаалалтын байгууллагыг Онцгой байдлын байгууллагад нэгтгэн зохион байгуулжээ.



*Улаанбаатар хот, Иргэний хамгаалалтын үзлэг 1960-аад он*

## УЛСЫН НӨӨЦИЙН ГАЗАР

“Айлаас эрэхээр авдраа уудал” гэдэг эрхэм сургаал үгийг Монголчууд эртнээс мөрдөж ирсэн түүхэн уламжлал нь эзэн Чингисийн цэрэг дайчдын хоол хүнс, хуурай хэрэгслийг нөөцлөх, түүнийг боловсруулах арга зэргээс үндэстэй. 1921 онд Ардын харилцан туслалцах хоршоог байгуулснаар Монгол оронд үндэсний худалдааны суурь тавигдаж хоршоонд Богд хаант Улсын эх дагина Дондогдулам болон нам төрийн дээд удирдлагууд болох Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, С.Данзан нар анхны гишүүнээр элсч, улсаас санхүүгийн туслалцаа үзүүлж, урт хугацаатай зээл олгосон нь Улсын нөөц үүсч бий болох үндэс суурь болжээ.



1921 онд Ардын харилцан туслалцах хоршоог байгуулжээ



Улсын нөөцийн тусламжийн анхны гэр 1922 он

*Улс орны хэмжээнд болон аймаг, суманд хун, мал, амьсны гоц халдварш өвчин дэгдэх, үйлдвэрлэлийн томоохон осол, гал түймэр гарах, ган, зуд, үер, газар хөдлөлт зэрэг болзошгүй гэнэтийн аюул, байгалийн гамшиг, эдийн засгийн бэрхшээл, бусад ноцтой хүндрэл тохиолдсон нөхцөлд хэрэглэх зориулалттай барааны улсын нөөцийг тогтоосон нэр төрөл, чанарын түвшин, тоо, хэмжээнд нь хүрээж, бэлэн байлгах үүрэг бүхий Улсын нөөцийн газрыг 1965 онд Сайд нарын Зөвлөлийн 244 дүгээр тогтоолоор хуучнаар Худалдаа бэлтгэлийн яамны харьяа бөөний бараа баазыг түшиглүүлж буй болгожээ.*

Монгол Улсын нөөцийн анхны байгууллага нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 244 дүгээр тогтоолоор Худалдаа бэлтгэлийн яамны харьяа Төв бараа бааз буюу хожим нь 1985 оноос Бөөний худалдааны нэгдэл 13 нэр төрлийн хүнсний бараа, хөвөн бөс даавуу, березент, эсгий, эсгий гутал зэрэг өргөн хэрэглээний бараа материалыг хариуцан нөөцөлж байсан байна. Улсын болон дайчилгааны нөөцийн бараа, материалын санхүүжилтийг тухайн салбарт хүлээн авсан баримт, тооцоог үндэслэн Сангийн яам баталгаа гаргаж, Монгол банкнаас урт хугацааны хүүгүй зээлээр олгож байжээ. **Засгийн газрын 1991 оны 106 дугаар тогтоолоор Улсын нөөцийн байршил өөрчлөгдөж Хүнсний барааны бөөний худалдааны газар, Эрдэнэт хот, Багануур дүүрэг болон Ховд, Баянхонгор Дорнод аймгуудад төвлөрүүлэн нэгтгэсэн байна.**

Таримал ургамлын үрийн улсын нөөцийг газар тариалангийн САА-уудыг түшиглэн байгуулж, дээрхи САА-ууд Улсын нөөцийн таримал ургамлын үрийг хариуцаж байсан бөгөөд хожим нь Хөдөө аж ахуйн яамны

Гурил тэжээлийн үйлдвэр, Таримал ургамлын үрийн улсын хяналтын албанд харъяалагдаж, шинэ сорт сорих, нутагшуулах, сортын үндсэн болон үйлдвэрлэлийн сорилтын ажлыг удирдан, 1996 он хүртэл гамшгийн үед үрийн болон таваарын буудайн нөөцийг олгох ажлыг зохион байгуулсан байна.

Хүний эм, эмнэлэгийн багаж хэрэгсэл, ороох, боох материалын улсын нөөцийг Эрүүлийг хамгаалах яамны харьяа Эмийн сангуудыг удирдах контор, Эрүүлийг хамгаалах яамны харьяа Улсын эм хангамж, үйлдвэрлэлийн газар 1992 он хүртэл хариуцаж, түүнээс хойш “Монгол эм импекс” нэгдлийн эмийн сангуудыг удирдах контор хариуцаж байв.

Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн 12 нэр төрлийн материалыг 9 аймагт Тээврийн яам



*Дайны хүнд жилүүдэд Монголын ард түмэн бүхий л талаар тусламж үзүүлэв 1940-1945 он*



хариуцан дайчилгааны улсын нөөц болгон бүрдүүлэн хадгалж байсан бөгөөд 1990-2000 он хүртэл “НИК” ХК сэлгэн шинэчлэх үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж ирсэн. 2001 оноос Улсын нөөцийн газрын тосны бүтээгдэхүүнийг шаардлагатай түвшинд бүрдүүлэн хадгалах боломжгүй болсон тул Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 02 тоот тогтоол гарч, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын нөөцийн газарт “НИК” ХК-аас тогтоолд заасны дагуу 4 бүсэд нийт 9 агуулахад газрын тосны бүтээгдэхүүний Улсын нөөцийг бүрдүүлэн хадгалж, шаардлагатай цаг үед Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр гарган зарцуулж, нөхөн бүрдүүлэлтийг хийж байхаар болсон байна.

Өвс тэжээлийн Улсын нөөц нь СнЗ-ийн 1971 оны 229 дүгээр тогтоолоор 9 аймагт Аюулаас хамгаалах өвс тэжээлийн Улсын фонд нэртэйгээр байгуулагдан ажиллаж байгаад 1996 оноос Монгол Улсын

**хэрэгжүүлэгч агентлаг Улсын нөөцийн газарт шилжин иржээ.**

Малын биобэлдмэл, хуурай болон шингэн вакцинуудын улсын нөөцийг Хөдөө аж ахуйн яамны харьяа Биокомбинат хариуцаж ажилладаг байсан бөгөөд Улсын мал эмнэлэгийн албаны төсөвт багтаж улсын төсвөөс санхүүжиж байв.

1987 онд Материал техникийн хангамжийн Улсын хорооны харьяа Улсын нөөцийн нэгдсэн агуулах “Объект-03” салбар анх ашиглалтанд орсон бөгөөд салбарын даргаар Дорж, Тусгай хэлтсийн даргаар Баасанбадам нар ажиллаж байв. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990 оны эхнээс хүнсний гол нэрийн бараануудыг Улаанбаатар хот болон хөдөө, орон нутгуудад картаар олгодог болсноор Улсын нөөцөөс тусламж аваагүй иргэн, үйлдвэр, аж ахуйн нэгж, төрийн байгууллага ховор болсон байна.

Улсын нөөцийн чиглэлээр тасралтгүй олон жил ажилласан туршлагатай мэргэжилтнүүд болох



*Намрын ургац хураалт, Улсын нөөцийн хадлан, тусламжийн өвсний цуваа 1992 он*



П.Батаахүү, А.Чулуунбат, Ж.Амарсанаа нар 1996 онд барааны улсын нөөц хуримтлуулах, зарцуулах талаар хэрэгжүүлэх журмын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулан батлуулж байжээ. Ингэснээр Улсын нөөцийн салбаруудыг аж ахуйн тооцоонд оруулан санхүүгийн хувьд биеэ дааж, үйл ажиллагаа явуулах, ажилтан алба хаагчдын санаачлагыг өрнүүлсэн бодит ажил болж 2004 он хүртэл зохицуулалтын олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхэд бодит хувь нэмрээ оруулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 40 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 38 дугаар тэмдэглэлийг үндэслэн Монгол Улсын Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Л.Нямсамбуугийн тушаалаар Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Улсын нөөцийн газар /хэрэгжүүлэгч агентлаг/-ын дүрэм, бүтэц зохион байгуулалтыг баталж Улсын нөөцийн газрыг байгуулсан байна.

Улсын нөөцийн газрын анхны даргаар Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайдаар ажиллаж байсан Монгол Улсын Зөвлөх агрономч, хөдөө аж ахуйн ухааны доктор Ц.Өөлд томилогджээ. Улсын нөөцийн газар төв аппаратдаа 7 хүн, Объект-03 салбар болон 19 аймагт давхардсан тоогоор 158 орон тоотойгоор үйл ажиллагаагаа эхлүүлж байв. Монгол Улсын Засгийн газар 1990-1996 онд улсын болон дайчилгааны нөөцөөс хүнсний 9, үйлдвэр, техникийн бараа 100 гаруй, тоног төхөөрөмж 50 гаруй, химийн бараа 10 гаруй нэр төрлийг дараа тооцоогоор олгосон нь туйлын хүндрэлтэй, авсан байгууллагууд нь бүгд хувьчлагдсан тул энэ тооцоо нь 2005



Улсын нөөцийн анхны мэргэжилтнүүд 1990-ээд он

оныг хүртэл үргэлжилсэн байна.

Улсын нөөцийн газар нь 1996-2004 оныг хүртэлх хугацаанд Монгол Улсын Үндсэн хууль, Хүнсний тухай хууль, болон Монгол Улсын Засгийн газрын удаа дараа гаргасан тогтоолуудыг хэрэгжүүлэх зэрэг олон талт ажлыг аж ахуйн тооцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байв. Энэ үед мөрдлөг болгон баримтлан ажилласан эрх зүйн акт нь 1996 онд Монгол Улсын Засгийн газрын 57 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын нөөц хуримтлуулах, зарцуулах тухай” журам байжээ.

Улсын нөөцийн газрын даргаар 1996-1998 онд Ц.Өөлд, 1998-1999 онд М.Моёор, 1999-2001 онд Я.Санжмятав, 2001-2003 онд Ж.Бямбаноров, 2003-2004 он хүртэл Т.Ганболд ажиллаж байгаад тус газар нь 2004 оны Засгийн газрын нэгдүгээр тогтоолоор Онцгой байдлын байгууллагын бүтцэд нэгдэн орсон байна.

## МОНГОЛ УЛСЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА



*2003 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас Гамиггаас хамгаалах тухай хуулийг батлан гаргасан бөгөөд энэ хуулинд Гамиггаас хамгаалах ерөнхий газрыг байгуулахаар заасан байдаг. 2004 оны Засгийн газрын хуралдааны нэгдүгээр тогтоолоор тус газрыг байгуулж, 2005 онд Гамиггаас хамгаалах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсноор, Онцгой байдлын ерөнхий газар болж өөрчлөн зохион байгуулагдсан юм.*





*Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулах шийдвэр гарав.*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


### ГАМШГААС ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 1 дүгээр сарын 7-ны эдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

**"ҮШ.ХЭЛЭЛЦСЭН НЬ:** Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулах тухай

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:** 1. Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулах тухай асуудлыг хэлэлцээд Засгийн газрын тогтоол гаргахаар тогтов.

2. Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулагдсантай холбогдуулан Улсын нөөцийн газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын иргэний хамгаалалтын газрын эдийн засаг, санхүүгийн хяалтын балансыг гаргаж, шинээр байгуулагдсан Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг нээлтийн баланстай болгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгав" гэжээ.



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АНХНЫ БҮТЭЦ



*Тус байгууллага нь гамшгаас хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх, гамшигийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршигийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, гамшгаас хамгаалах бүх шатны байгууллагуудыг шинэчлэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанартай, үр өгөөжтэй, хурдан шуурхай хүргэх, үр нөлөө бүхий удирдлагын чадавхи бүрдсэн ажлын албыг бэхжүүлэхэд чиглэсэн байхуйцаар удирдлага зохион байгуулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгуулагдсан болно.*

- Улсын иргэний хамгаалалтын газар
- Гал түймэртэй тэмцэх газар
- Улсын нөөцийн газар

**Гамшгаас хамгаалах ерөнхий газар**  
(2004 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 01 дүгээр тогтоол)

**Онцгой байдлын ерөнхий газар**  
(2005 онд Монгол Улсын Их Хурлаас Гамшгаас хамгаалах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан)



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ БЭЛГЭДЭЛ, ТУГ ДАЛБАА



*Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журам, тодорхойлолт, тугны загварыг 2005 оны 3, 5 дугаар сард Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар баталж мөрджээ.*



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ДҮРЭМТ ХУВЦАСНЫ АНХНЫ ЗАГВАР

*2005 онд Онцгой байдлын албаны албан хаагчдад цол олгох журам, Онцгой байдлын албаны алба хаагчдын дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан юм.*



*Ёслол албаны дүрэмт хувцас /эрэгтэй, эмэгтэй/*



*Хээрийн хувцас*



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АНХНЫ СҮЛД ДУУ

Шүлгийг Ю.Болд

Хөгжмийг Г.Эрдэнэбаатар

### “АВРАГЧИЙН ДУУ”

Эрхэст тэнгэр хилэгнэн догширч  
Эх дэлхий донслон шилгээсэн ч  
Аянга цахилгаан маналзан ниргэлж  
Аадар бороо хуйлран оволзсон ч

#### Дахилт:

Аврах албаныхан бид явна  
Аюулыг зогсоож, голомтыг дарна  
Ачлал, энэрэл, нигүүлсэн хайрлаж  
Авралын гэгээ болон гийнэ

Гал дүрэлзэн, гол мөрөн давалгаалж  
Гамшиг, зовлон, хөнөөл учирсан ч  
Ган зудын аймшиг нүүрлэж  
Гай барцад дайрч сүйтгэсэн ч

#### Дахилт:

Өвчин тахлын хөнөөл тархаж  
Үхэл хагацал нэрвэсэн ч  
Онцгой үзэгдэл, далдын хүчинд автаж  
Осол, эндэл аюул тохиосон ч

#### Дахилт:

Халуун хүйтэн зэвсэг харшиж  
Харгис бурангуй дарамт гаарсан ч  
Хүйтэн сэтгэл өвөрлөн халдаж  
Хүйс тэмтрэн хөнөөсөн ч

#### Дахилт:

## МАНАЙ ГАВЬЯАТУУД

*2005 онд Нийслэлийн Гал унтраах 10 дугаар ангийн гал сөнөөгч, сурган хүмүүжүүлэгч дэд хурандаа Т.Отгон “Үйлчилгээний гавьяат ажилтан” цол тэмдгээр шагнагдаж салбарын нийт ажиллагсдын бахархал болж байлаа. Мөн 2007 онд Төв аймгийн Жаргалант сумын Улсын нөөцийн салбарын дарга Г.Нэргүй “Үйлчилгээний гавьяат ажилтан” цолоор шагнагджээ.*



Т.Отгон нь Төв аймгийн Баянчандмань суманд төрсөн. 1966 онд Нийслэлийн Аврах, гал унтраах 10 дугаар ангийн гал сөнөөгчөөс ажлын гараагаа эхэлж, тус газрын орлогч, сургалт хариуцсан ахлах байцаагчаар төрд тасралтгүй 50 орчим жил ажиллаж байгаад гавьяаны амралтдаа гарсан. Онцгой байдлын дэд хурандаа цолтой.

Тэрбээр Гал унтраах техникийн олон төрөлт техникийн спортын олон улсын хэмжээний мастер. Гал, үер усны аюулаас 50 гаруй хүний амийг аварсан. Мөн төр, аж ахуйн нэгж байгууллагын 260,5 гаруй сая төгрөгийн эд хөрөнгийг галын аюулаас авран хамгаалсан байна.

Гал унтраах техникийн олон төрөлт техникийн спортыг хөгжүүлэхэд өөрийн ухамсарт амьдралаа зориулж мэргэжлийн гал сөнөөгч, залуу дайчдыг бэлтгэх, биеийн тамир, спортыг хөгжүүлж албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх, сайн тамирчин бэлтгэхэд онцгой анхаарч ажилласны үр дүнд түүний шавь нараас спортын мастер, дэд мастерын болзол хангасан 28, улсын зэрэг цолтой 136 тамирчин төрөн гарсан юм. ЗХУ-ын /хуучнаар/ болон Монгол Улсын Галын байгууллагын “Онц гал сөнөөгч” тэмдгээр шагнагдаж байсан. Түүний байгуулсан гавьяа, хөдөлмөр зүтгэлийг төр засаг үнэлэн 2005 онд Монгол Улсын Үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээсэн юм.



Монгол Улсын Үйлчилгээний Гавьяат ажилтан Г.Нэргүй Баянхонгор аймагт төрсөн. Хөдөө аж ахуйн салбарт тасралтгүй 40 орчим жил ажиллаж, Атрын 1, 2-р аяныг эхлүүлэхэд гар бие оролцсон. Төв аймгийн Жаргалантын суманд аграномич, 1998 оноос тус аймгийн Улсын нөөцийн салбарын даргаар ажиллаж байгаад гавьяаныхаа амралтад гарсан юм. 2007 онд Монгол Улсын Үйлчилгээний Гавьяат ажилтан цолоор шагнагджээ.

## ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН БААТРУУД



Монгол Улс Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагад 1992 онд ажиглагч, 2002 онд жинхэнэ гишүүнээр элссэн ба ОУИХБ-аас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд идэвхтэйгээр оролцсоор ирсэн. Тус байгууллага нь байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн үед хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг хамгаалах, туслах үйл ажиллагааг баталгаажуулах бүтцийг улс орнуудад хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой Засгийн газар хоорондын байгууллага бөгөөд тус байгууллагын эх үүсвэр 1931 онд тавигдсан. Олон улсын Иргэний хамгаалалтын байгууллага (ОУИХБ)-ын Женев дэх Ерөнхий Ассамблейн IX тогтоолоор жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийг Дэлхийн иргэний хамгаалалтын өдөр болгон тэмдэглэж байхаар заажээ.

ОУИХБ нь гамшгаас хамгаалах чиглэлээр амжилт гаргасан хүмүүсийг “Баатар” одонгоор шагнадаг.

Монгол Улсаас энэхүү нэр хүндтэй шагналыг:

**2005 онд:** УИХГ-ын дэд дарга, УБОК-ын нарийн бичгийн дарга асан хурандаа П.Дамдин, УИХГ-ын дарга асан хошууч генерал О.Үржин,

Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга асан дээд ахмад Ч.Нэргүй,

**2008 онд:** НОБГ-ын дарга асан комиссар С.Цогтбаатар,

Ховд аймгийн ОБХ-ийн дарга дээд ахмад Я.Буянтөр,

Говь-Алтай аймгийн ОБХ-ийн Аврах, гал унтраах 59 дүгээр ангийн аврагч-жолооч дээд түрүүч Ж.Буян-Оргих,

**2010 онд:** Төв аймгийн ОБХ-ийн дарга асан дээд ахмад Л.Ганбат,

НОБГ-ын ЧД-ийн ОБХ-ийн дарга дээд ахмад А.Дамцагдорж,

АТА-ийн шүхэрчин гал сөнөөгч дээд түрүүч Д.Зууннаст,

**2011 онд:** ОБЕГ-ын Гал унтраах хэлтсийн дарга дээд ахмад Я.Ишжамц,

Дархан-Уул аймгийн ОБХ-ийн дарга асан дээд ахмад Ш.Лхагвасүрэн,

АТА-ийн химийн тагнуулын бүлгийн дарга шадар дэслэгч Х.Өлзийхутаг,

**2012 онд:** НОБГ-ын дэд дарга онцгой байдлын хурандаа Ч.Намсрайжав,

Хэнтий аймгийн ОБГ-ын дарга онцгой байдлын хурандаа Д.Батжаргал,

АТА-ийн ахлах мэргэжилтэн Б.Жаргалсайхан,

**2013 онд:** НОБГ-ын дарга онцгой байдлын хурандаа Н.Уламбаяр,

АТА-ийн захирагч онцгой байдлын хурандаа Д.Чинзориг,

НОБГ-ын Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга

онцгой байдлын хурандаа Б.Ганбат нар тус тус шагнагджээ.



## НҮБ-ЫН ОНЫ ТЭРГҮҮН ШАГНАЛ

НҮБ-аас жил бүр шалгаруулдаг оны тэргүүний шагналыг Онцгой байдлын албанаас анх удаа дээд ахмад Ч.Батчулуун 2005 онд хүртэж байсан юм. Монгол улсын Иргэний хамгаалалтын болон Гамшгаас хамгаалах байгууллагын төв, орон нутгийн нэгжүүдэд сүүлийн 10 гаруй жил үр дүнтэй ажилласан түүний идэвхи зүтгэл, хөдөлмөрийн амжилт бүтээлийг Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага үнэлж энэхүү нэр хүндтэй шагналд 2005 оны зургаадугаар сард тодорхойлсон юм. НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газраас гишүүн орнуудаас ирүүлсэн тодорхойлолтыг судалж сүүлийн 10 жилд гүйцэтгэсэн ажлын тайлан, үр дүн гэсэн хоёр шатны комиссоор шалгаруулжээ. Эдгээр комиссын үнэлгээгээр Монгол, Индонез, Филиппин улсаас гурван хүн шалгарч, “НИППОН” сангийн Сасакавагийн нэрэмжит 2005 оны тэргүүн буюу 18 дахь удаагийн шагналтнаар Ч.Батчулуун тодорсон байна. Уг шагналыг “НИППОН” сангийн ерөнхийлөгч Япон улсын иргэн Риойчи

Сасакава 1985 онд санаачлан бий болгож, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх хохирлыг бууруулах, үйл хэрэгт онцгой амжилт гаргасан байгууллага хувь хүмүүст олгодог болсон юм.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮЕ ҮЕИЙН УДИРДЛАГУУД

### Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, Шадар сайдууд:

У.Хүрэлсүх 2004-2006 он, С.Отгонбаяр 2006-2007 он, М.Энхболд 2007-2012 он, Д.Тэрбишдагва 2012 оноос

### Зөвлөхүүд:

Хошууч генерал Д.Базарсад 2004-2006 он, хошууч генерал О.Үржин, доктор Бямбаа, Зоригт 2006-2007 он, хурандаа Г.Төмөрбат 2007-2012, Н.Батсуурь, Анхныбаяр, Хүрэлсүх, хурандаа Д.Пүрэвдавуу 2012 оноос

### Онцгой байдлын ерөнхий газрын дарга нар:

Тэргүүн комиссар П.Даш 2004-2007 он, Тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр 2007-2012 он, Онцгой байдлын хурандаа Т.Дуламдорж 2012 оноос

### Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга нар:

Тэргүүн комиссар О.Үржин, тэргүүн комиссар Т.Ганболд, тэргүүн комиссар Б.Жаргалсайхан, комиссар Д.Хишигбаатар, комиссар А.Даваасүрэн, комиссар Т.Бадрал, комиссар Д.Намсрай, Онцгой байдлын хурандаа Д.Дарь.Сүхбаатар

### Онцгой байдлын ерөнхий газрын газрын дарга нар:

Комиссар П.Баттогтох, комиссар Д.Хишигбаатар, комиссар Д.Батбаатар, комиссар Т.Бадрал, комиссар Д.Намсрай, комиссар Л.Алтангэрэл, комиссар Х.Батбилэг, комиссар С.Цогтбаатар, комиссар С.Цэндбаатар, комиссар Г.Доржрагчаа, дээд ахмад Д.Сүхбат, дээд ахмад Р.Батмэнд, шадар ахмад А.Ганбаатар, дээд ахмад Д.Батсайхан, Онцгой байдлын хурандаа Д.Алтангэрэл, Онцгой байдлын хурандаа С.Залуухүү, Онцгой байдлын хурандаа Б.Мандахгэрэл, Онцгой байдлын хурандаа М.Энх-Амар



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ГАВЪЯА, ШАГНАЛУУД



*Тэргүүний ажилтан тэмдэг*



*Онц гал сөнөөгч тэмдэг*



*Албаны төлөө -1 одон*



*Албаны төлөө -2 одон*



*Албаны төлөө -3 одон*



*Жуух бичиг*




*Баярын бичиг*



*Сайшаалын үнэмлэх*

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ БААТРУУД

### МИ-8 НИСДЭГ ТЭРЭГНИЙ ОСОЛ /2007 ОН/



Сэлэнгэ аймгийн Мандал суманд гарсан ой, хээрийн түймрийг унтраахаар 2007 оны 06-р сарын 14-ний өглөө Хилийн цэргийн 8220 дугаартай Ми 8 нисдэг тэргээр ОБЕГ-ын удирдах бүрэлдэхүүний 4, Аврах тусгай ангийн 15 шүхэрчин гал сөнөөгч, онгоцны экипажийн 3 нийт 22 хүний бүрэлдхүүнтэй хөөрсөн нисдэг тэрэг Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг, Шар товгор уулын энгэрт осолдсон. Холбоо тасарсанаас хойш нэг хоногийн дараа эрэн хайх ажиллагаа эхэлж, 3 хоногийн дараа “Тэнгэрийн улаач” компанийн онгоц ослын газрыг олж тогтоосон.

Тус нисдэг тэргэнд албан үүргээ гүйцэтгэж явсан ОБЕГ-ын Онцгой үеийн шуурхай удирдлагын газрын дарга комиссар Д.Батбаатар, урьдчилан сэргийлэх хяналтын хэлтсийн дарга дээд ахмад Д.Цэрэнням, тэргүүн дэслэгч С.Дашбазар, тэргүүн түрүүч Э.Ариунсанаа, тэргүүн түрүүч Ө.Дүүбаатар, дээд түрүүч Г.Лхагвасүрэн, тэргүүн түрүүч Л.Баярмагнай, тэргүүн түрүүч Ё.Эрдэнэцогт, дээд түрүүч Ц.Ганболд, дээд түрүүч Ц.Болд, тэргүүн түрүүч Т.Оргилсайхан, тэргүүн түрүүч Л.Булган, нисэх багийн дарга хурандаа гавъяат нисэгч Т.Сугар, 2 дугаар нисгэгч дэд хурандаа А.Наранбат бортмеханик хошууч Ч.Гантөмөр гээд нийтдээ 15 хүн амь насаа алдсан юм.

Шадар дэслэгч Д.Пүрэвдорж, дээд түрүүч Ж.Бадамжунай, дээд түрүүч С.Батдалай, тэргүүн түрүүч Г.Ганжигүүр, тэргүүн түрүүч Х.Сүхбаатар, шадар түрүүч П.Цогжаргал, “Аврагч” студийн зураглаач Т.Мөнхтөр нар ослоос эсэн мэнд үлдсэн юм. Эх орондоо өргөсөн тангарагтаа үнэнч байж, гамшгийн өөдөөс сөрөн зогсож, баатарлагаар амь эрсэдсэн эрэлхэг хөвгүүдээ эх орон, Онцгой байдлын алба хэзээ ч мартахгүй.

Та бүхний халуун залуу нас, хатан зориг, баатарлаг үйлс хойч үеийнхэнд үлгэр дууриал болж, та бүхний гэгээн дүр, сайхан сэтгэл, шударга үнэнч, нөхөрсөг зан чанарыг Монголын ард түмэн зүрх сэтгэлдээ хадгалан, үүрд дурсаж байх болно.



**ДОРЖИЙН БАТБААТАР**  
/1960-2007/

Доржийн Батбаатар нь 2007 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Сэлэнгэ аймгийн нутагт гарсан түймрийг унтраах ажлын хэсгийг ахлан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн билээ. Комиссар Д.Батбаатар нь 1960 онд Улаанбаатар хотод төрсөн. 1987 онд ОХУ-ын Галын инженерийн дээд сургуулийг Галын аюулгүйн инженер мэргэжлээр, 2002 онд Удирдлагын академийг дүүргэн төрийн удирдлагын менежер мэргэжил эзэмшсэн. Тэрбээр 1980-1993 онд Галын аюулаас хамгаалах газар гал сөнөөгч, туслах байцаагч, хяналтын жинхэнэ байцаагч, 1993-2004 онд Гал түймэртэй тэмцэх газар дүн бүртгэлийн байцаагч, хяналтын тасгийн дарга, Тамгын хэлтсийн дарга, Газрын дэд дарга, 2004 оноос ОБЕГ-ын Мэргэжлийн удирдлагын газрын дарга, Онцгой үеийн удирдлагын газрын даргаар тус тус ажиллаж байлаа.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг үнэлж 2001 онд Ардын хувьсгалын 80 жилийн ойн медаль, 2002 онд Цэргийн хүндэт медаль, 2006 онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медалиар шагнасан байна. Д.Батбаатар нь Гал түймэртэй тэмцэх байгууллагад гал сөнөөгчөөс ажлын гараагаа эхлэн Гал түймэртэй

тэмцэх газрын дэд дарга хүртэл албыг нэр төртэй хашиж улмаар Онцгой байдлын байгууллагыг үүсгэн байгуулахад үнэлж баршгүй хувь нэмрээ оруулсан манай байгууллагын шилдэг удирдагчдын нэг байлаа.



### ГОЧООГИЙН ЦЭРЭННЯМ

/1960-2007/

Гочоогийн Цэрэнням нь 2007 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Сэлэнгэ аймгийн нутагт гарсан түймрийг унтраах ажлын хэсэгт үүрэг гүйцэтгэж яваад амь эрсэдсэн билээ. Дээд ахмад Г.Цэрэнням нь 1960 онд Дундговь аймгийн Дэлгэрхангай суманд төрсөн. 1987 онд ОХУ-ын Галын техникийн сургууль, 1999 онд Цагдаагийн дээд сургуулийг тус тус төгсч Галын техникч, эрхзүйч мэргэжил эзэмшсэн.

Тэрбээр 1980-1987 онд Төв гал команд, Баянголын галын постод гал сөнөөгч, 1987-1991 онд Булган аймгийн Цагдан сэргийлэх ангид байцаагч, Улаанбаатар хотын Гал унтраах 14 дүгээр ангид салааны захирагч, 1991-1998 онд Цагдаагийн дээд сургуульд дамжааны захирагч, албаны дарга, 1998-2004 онд Улаанбаатар хотын ГТТХ-т Гал унтраах ангийн дарга, хяналтын тасгийн дарга, 2004 оноос ОБЕГ-ын Мэргэжлийн удирдлагын газар, Онцгой үеийн

удирдлагын газарт Гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын хэлтэс, албаны даргаар ажиллаж байлаа.

Г.Цэрэнням нь өөрийн ухамсарт амьдралаа гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, улс, эх орон, ард иргэдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үйлсэд өөрийн хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээ харамгүй зориулсан манай шилдэг залуу удирдагч нарын нэг байсан юм.

### Онцгой байдлын ахмад С.Багдалай:

ҮХЭЛ АМЬДРАЛЫН ЗААГТ



*Тухайн үед ослоос эсэн мэнд гарсан эдүгээ Аврах тусгай ангийн сэтгэл зүйчээр ажиллаж байгаа Онцгой байдлын ахмад С.Багдалай ийн хүүрнэв.*

Тэр үед би Аврах тусгай ангийн Агаар десантын отрядын шүхрийн зааварлагч бүлгийн дарга, дээд түрүүч цолтой байв. Нисдэг тэрэг унахад би ухаан алдсан байсан, сэргээд онгоц унажээ гэдгийг мэдсэн. Онгоц гурван талаараа зад үсэрсэн байлаа. Хүмүүс орилж ёолж байв. Би ямар ч байсан онгоцноос гарах ёстой гэж бодоод босох гэтэл чадаагүй. Бараг 30 гаруй минут мөлхөж байж онгоцноос гарч ирсэн. Онгоцны нүүрэн хэсгээр гарч ирэхэд хоёр гурван хүн гарчихсан, талийгаач нараас ч зарим нь тэр үед амьд гарч ирсэн байсан. Тэнд маш хэцүү байдал, орчин үүссэн байлаа. Намайг гарахад шивэрч байсан бороо оройдоо цас болж хүйтрэн амнаас уур цан савсаж байв. Битүү норсон байсныг хэлэх үү маш их даарч, эрүү чичрээд ам эвлэхгүй ярьж чадахгүй болсон. Миний

баруун гар, зүүн хөл хөдөлж, харин зүүн гар, баруун хөл мэдээгүй болсон учир хөл дээрээ зогсож чадахгүй байв. Орой манай тэргүүн түрүүч Х.Сүхбаатарын баруун гар шуугаараа хугарсан хэдий ч өөртөө боолт хийсэн болоод бидэнд шүхэр дөхүүлж өгсөн тул тэрүүгээрээ хучаад хэвтэцгээсэн. Миний хувьд маш их өвдөлтийг мэдэрч байв. Нэг нэгэндээ туслах чадалтай хүн үлдээгүй байсан. Би тэр үед 28 настай байжээ. Үхэл амьдралын зааг дээр хүн их юм боддог юм билээ. Ам маш их цангаж байсан тул шингэнээ аль болохоор алдахгүй байхыг мэрийж байсан. Биднийг хурдан олоосой гэж бодож байлаа. Маргаашнаас нь эхлэн онгоцны дуу сонсогдоод эхэлсэн тул эрлийн ажиллагаа явж байгаа гэдгийг бүгд л мэдэж байсан. Харахгүй өнгөрөөд явчихаар сэтгэл их үймэрдэг юм билээ. Хүн үхэлтэй нүүр тулгараад ирэхээр амьд үлдэхийн тулд үнэхээр тэмцдэг. Өдөртөө маш

халуун нартай байснаа, нар жаргахаар маш хүйтэн болно. Ус байхгүй тул хатаж үхэх аюул тулгарсан. Шингэнээ яаж алдахгүй байх вэ, яаж жаахан ч гэсэн нөхөх вэ гэдэг бидний гол бэрхшээл. Ам цангаад уулын хөрснөөс хуруугаараа сэндийлж аваад хамартаа хүргэтэл нил онгоцны түлш үнэртэж байсан. Нэлээд доош гараараа ухаж байж гаргасан чийгтэй шороогоо цээжин дээрээ тавихад ус уусан мэт сэрүү оргино. Гэмтлийн эмнэлэгт ирэхэд миний хувьд зүүн дал, нуруу, хоёр гурван хавирга хугарсан, өвдөг, цээж бяцарсан гээд хамгийн олон гэмтэлтэй нь байсан. Тэгээд эмнэлэгт сар гаран хэвтэж эмчлүүлж байлаа. Амь эрсэдсэн аврагч нөхдөө байнга дурсан санаж тэднээрээ бахархаж явдаг даа.

### АВРАГЧДЫН ГЭРЭЛТ ХӨШӨӨ



Онцгой байдлын албаны албан хаагчид өөрсдийн хандив санаачилгаар албан үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн дайчин нөхдийнхөө гэгээн дурсгалд зориулан Гэрэлт хөшөө босгосон юм. Тус хөшөө нь одоо Орбит дахь ОБЕГ-ын Аврах тусгай ангийн байранд сүндэрлэн байдаг. Энэхүү хөшөөг Онцгой байдлын албаны дэслэгч Г.Норовсамбуу, хошууч П.Амарсайхан, ахмад Д.Пүрэвдорж, МУЭ-ийн шагналт зураач, уран барималч Г.Сэрээтэрийн удирдлаган дор хамт олны хүчээр барьж босгожээ. Буу мөрлөж, дарийн утаа үнэрлэн, дайсны эсрэг амь өрсөн тулалдаагүй ч энх цагт ард түмэн улс орныхоо өмнө тулгарсан гал, усны гашуун зовлонг сөрж, амар амгалан амьдралыг авчрахын тулд халуун амиа зориулсан дайчин нөхдийнхөө алдар гавьяаг мөнхөлнө гэдэг тангараг нэгтэй анд нөхөд, хамт олны халуун сэтгэлийн илрэл юм. Хөшөө, дээшээ нисч байгаа онгоцыг дүрсэлж, нүүр хэсэгт Монгол улсын төрийн алтан соёмбо, түүний дор “Албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн аврагч дайчдынхаа гэгээн дурсгалд зориулав. 2008.06.14” хэмээн бичсэн нь бий.

### Онцгой байдлын хошууч П.Амарсайхан: БИДНИЙ СЭТГЭЛ ШИНГЭСЭН ХӨШӨӨ БОССОН



Анх бид хөшөөгөө босгохдоо Ми-8 нисдэг тэрэгний ослоор амь үрэгдсэн албан хаагчдадаа зориулан босгох гэж байснаа ерөөсөө албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн Онцгой байдлын нийт албан хаагчдынхаа гэгээн дурсгалд зориулан босгоё гэж шийдсэн юм. Бид өөрсдөө арматурын төмрөө татаж авчиран, гар бие оролцон босгосон. Д.Пүрэвдорж маань Ми-8 нисдэг тэрэгний ослоос амьд үлдсэн цөөхөн албан хаагчдын нэг байсан. Хөшөөний эх загварыг манай ОБЕГ-ын дэд дарга байсан комиссар Т.Ганболд, хэвлэлийн албаны дарга тэргүүн ахмад Г.Нэргүй нар анх санаачилж гаргасан юм. Анхны загвар ёсоор соёмбогүй байсныг бид ярилцаж байгаад Төрийн алтан соёмбоо нэмсэн. Тэгээд барималч Г.Сэрээтэртэй уулзаж зөвлөөд түүнтэй хамт ажиллаж хөшөөгөө босгож байлаа. Бид дайчин нөхдөө мартахгүй дурсч, алдар гавьяаг нь үргэлж санаж явах ёстой гэдгийг энэхүү хөшөөгөөрөө харуулж өгсөн юм. Манай хамт олон өөрсдийн сэтгэлээр, бас байгууллагынхаа дотоод

нөөц бололцоогоор босгосон. Энэ хөшөөнд манай хамт олон, бидний сэтгэл зүрх шингэсэн. Аврагчдын гэрэлт хөшөө маань эдүгээ Нийслэл Улаанбаатарын хөшөө дурсгалын бүртгэлд албан ёсоор орсон байдаг.

### ДОРНОДЫН ТҮЙМЭР /2012 ОН/

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт их хэмжээний бэлчээр хамарсан хээрийн түймэр гарсан дуудлагын дагуу аймгийн Онцгой байдлын хэлтсийн эрэн хайх аврах албаны 10 аврагч гарсан юм. Аврах бүлгийн дарга Онцгой байдлын дэслэгч Ч.Намжилдаш, Онцгой байдлын ахлагч Ж.Одбаяр, С.Бат-Эрдэнэ нар энэхүү түймрийг унтрааж яваад эцсийн амьсгалаа хураатал эх орон, өргөсөн тангарагтаа үнэнч байж эрэлхэгээр амь насаа алдсан билээ. Тэд Дорнод аймгийн Баяндун, Матад зэрэг олон суманд ажиллаж арав гаруй хүний амийг аварч, олон мянган мал, айлын хашаа саравч, гэр оронг галын аюулаас авран хамгаалж байсан шилдэг




албан хаагчид байлаа. Тэдний төр, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж албаныхаа төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэж ирсэн бахархалтай олон үйлс нь бидний сэтгэл зүрхэнд үүрд хоногшин үлдэх нь гарцаагүй.

Тэд өдөр 13 цагийн үед аймгийн төвөөс гарч давхиад түймрийн голомт дээр 16 цаг өнгөрч байхад очжээ. Очсон даруйдаа түймрийг унтраахаар баруунаас зүүн тал руу чиглэсэн цурам тавьж эхэлсэн байна. Цурам тавьж бага зэрэг намжаагүй бол салхины эрчээр ирж яваа түймэр айл амьтан, бэлчээр шатаах аюултай байв. Хамгийн урд Онцгой байдлын ахлах ахлагч Г.Багабиш, түүний хажууханд аврагч дэд ахлагч А.Болорсүх цурмаа тавиад явж байжээ. Гэтэл яах ийхийн зуургүй нүргэлсэн гал ороод ирсэн бөгөөд гүйх ч бололцоо олдоогүй байна. Энэ үед Г.Багабиш хажуудаа байсан А.Болорсүхийг доороо оруулаад нөмрөөд хэвтсэн аж.

“...Тэрнээс цааш юу ч санадаггүй. Нэг мэдэхэд л эмнэлгийн орон дээр хэвтэж байсан. Манай жолооч ахын ярьдагаар бол Г.Багабиш ах “Би яах вэ өөрөө явчихна, Болорсүхийг эмнэлэгт хүргэж өг” гээд зумарсан арьсаа унжуулаад явсан гэх юм билээ. Зарим хүн “Яагаад А.Болорсүхийг аварсан юм бэ” гэхэд “Арай залуу нь амьдраг гэж бодсон” гэж хариулсан гэдэг. Ийм сайхан ах, дүү нараа түймэрт алдсандаа үнэхээр харамсаад барахгүй” хэмээн аюулт түймрээс маш их түлэгдэлтэй гарсан ч сайн эмч, хамт олныхоо буянаар хөл дээрээ боссон аврагч А.Болорсүх өгүүлсэн юм.

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Тус байгууллага анх байгуулагдахад дараах эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан батлан




гаргаж мөрдөж эхэлсэн байна. Үүнд: Онцгой байдлын албаны алба хаагчдад цол олгох журам, Онцгой байдлын албаны алба хаагчдын дүрэмт хувцасны загварыг **Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар**, Гамшигтай тэмцэх комиссын журам батлах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Гамшгаас хамгаалах байгууллагын албан хаагчийн сахилгын дүрэм батлах тухай, Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай, Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулах тухай, Малын гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай, Улсын нөөцөөс таримал ургамлын үр гаргах, нөхөн бүрдүүлэх тухай, Хөрөнгө гаргах тухай, Гамшгаас хамгаалах хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Онцгой нөхцлийн нэмэгдэл олгох тухай асуудлыг **Засгийн газрын тогтоолоор**, Онцгой байдлын байгууллагад Төрийн тусгай албаны мэргэшлийн шалгалт авах болзол журам, Төрийн албаны салбар зөвлөлийг байгуулах, түүний ажиллах журам зэрэг олон асуудлыг **Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор**, Байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, Онцгой байдлын албаны төрөлжсөн дүрмүүд, Шуурхай штабын бүрэлдхүүнийг томилох тухай, Улсын нөөцөөс дизелийн түлш гаргах, нөхөн

бүрдүүлэх тухай, Онцгой байдлын байгууллагын бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журам, Гамшгийн мэдээллийн сан байгуулах, ашиглах журам зэргийг **Монгол улсын Ерөнхий сайд болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын захирамж, тушаалаар баталгаажуулжээ.**

### ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ДҮРЭМ, ЖУРМУУД

Гамшгаас хамгаалах улсын албадын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэх үүргийг шинэчлэн батлах тухай, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба байгуулах чиглэл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах албаны штабын бүтэц, зохион байгуулалтын чиглэл, гүйцэтгэх үүрэг, удирдлагын бүрэлдхүүний гүйцэтгэх үүргийн үлгэрчилсэн хуваарь, Гамшгийн аюулгүй байдлын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам, Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журам, Гамшгаас хамгаалах бэлэн байдалд шилжих журам, Гамшгийн үед ажиллах журам, Гамшгаас хамгаалах байгууллагын бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журам, Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг шалгаж үнэлэх журам, Гамшгаас хамгаалах арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагыг оролцуулах журам, Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах штабын дүрэм, Онцгой байдлын албаны гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх хэтийн чиглэл, Олон нийттэй харилцах албаны ажиллах журам, Гамшгаас хамгаалах байгууллагын алба хаагчдад мэргэжлийн зэрэг олгох журам, Улсын байцаагчийн эрх олгох журам, Гамшгаас

хамгаалах байгууллагад төрийн тусгай албаны мэргэшлийн шалгалт авах болзол, журам, Гамшгаас хамгаалах байгууллагын төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх хөтөлбөр, Онцгой байдлын албаны нийгмийн хамгаалал дэд хөтөлбөр, Онцгой байдлын албаны харьяа анги, байгууллагын ажлыг дүгнэх журам, Гамшгийн болон байнгын радио холбоог зохион байгуулж ашиглах журам, Гал түймрийн хэрэг зөрчлийг шалгах журам,



Химийн онцгой хортой, тэсрэмтгий, исэлдүүлэгч, шатамхай, идэмхий, цочроомтгой бодисыг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, ашиглах зөвшөөрөл олгох талаар дүгнэлт гаргах түр заавар, дүгнэлт гаргах түр комиссын бүрэлдхүүнийг батлах тухай, Шингэрүүлсэн шатдаг хий тээвэрлэх зөвшөөрөл олгох журам, зөвшөөрлийн загвар, тээвэрлэлтийн маршрут, замын хуудас, жолоочийн хөдөлмөр амралтын дэглэмийг батлах тухай, Шатахууны нөөцийн салбаруудад мөрдөх шатахууны үнийг батлах тухай, Улсын нөөцөд өвс тэжээл хүлээн авах түүнийг хадгалах, зарцуулах журам, Өвс тэжээлийг ачих буулгах болон түүнтэй холбогдсон бусад ажлын үед мөрдөх үнэлгээний тариф, Ажлын байрны тодорхойлолт батлах тухай, Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дүрэм батлах тухай, Шинжлэх ухаан технологийн орон тооны бус зөвлөл байгуулах тухай, Онцгой байдлын албанд Шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг батлах тухай, Гамшгийн нөхцөл байдал үүсэн үед Онцгой байдлын алба нэгжүүдийн харилцан ажиллах журам, Онцгой байдлын албаны шуурхай удирдлага, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтний ажиллах заавар, Онцгой байдлын албанд төрийн нууцыг хамгаалах журам, Онцгой байдлын албанд албан хэрэг хөтлөлт, ил баримт бичгийн эргэлт, түүнд тавих дотоодын хяналт, архивын

ажиллагааг зохион байгуулах заавар, хугацаат мэдээ, тайлан гаргах журам, Онцгой байдлын албаны харьяа салбар, нэгжийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам зэргийг шинээр боловсруулан мөрдүүлсэн бөгөөд Онцгой байдлын албаны харьяа анги, Аймаг, Нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб, Улсын нөөцийн салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт, шалгалт хийх заавар, Онцгой байдлын албаны алба хаагчдад тэтгэмж олгох журам зэргийг холбогдох эрх зүйн актуудаар баталжээ.

Эдгээр эрх зүйн актууд нь Онцгой байдлын Ерөнхий газар, түүний харьяа анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын албадуудыг шинээр байгуулах буюу өөрчлөн зохион байгуулах, Монгол улсад гамшгаас хамгаалах удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагааг мэргэжлийн шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах ач холбогдол бүхий өргөн далайцтай арга хэмжээ болжээ.



Онцгой байдлын асуудал эрхэлсэн анхны сайд У.ХҮРЭЛСҮХ:

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ТУЛГЫН ЧУЛУУГ ТА БҮХЭНТЭЙГЭЭ ХАМТРАН ТАВИЛЦСАНДАА БАХАРХАЖ БАЙНА

Монгол Улсад Онцгой байдлын алба үүсэн байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан тус албаны төлөө оюун ухаан, хүч хөдөлмөр, авьяс билгээ харамгүй зориулж ирсэн үе үеийн офицер, ахлагч, ажилтан албан хаагчид та бүхэндээ Онцгой байдлын албаны анхны сайдын хувьд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Дэлхийн дулаарал, хүний шууд болон шууд бус нөлөөллийн улмаас байгаль цаг агаарын аюулт үзэгдэл, гамшиг осол нэмэгдэж хор хөнөөл ихсэж байгаа өнөө үед эх газрын эрс тэс уур амьсгалтай, өргөн уудам нутагтай, дэд бүтэц

харьцангуй сул хөгжсөн манай оронд Онцгой байдлын албаны үүрэг, ач холбогдол өдрөөс өдөрт нэмэгдэж олон улсын жишигт нийцүүлэх, бие бүрэлдэхүүнийг чадваржуулах шаардлага өнөөдөр ч чухал хэвээр байна.

Засгийн газрын гишүүн Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын анхны сайдаар томилогдон та бүхэнтэй гар сэтгэл нийлж ажилласан богинохон хугацаанд Монгол Улсын хувьд цоо шинэ энэ салбарын хууль эрх зүйн орчныг бүрдүүлж төгөлдөржүүлэх, чадавхийг богино хугацаанд бэхжүүлж, Олон улсын жишигт хүргэх, улмаар зөвхөн эх орондоо төдийгүй олон улсад танигдсан байгууллага болгох, хамт олныг бэхжүүлэн төлөвшүүлэх, ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх талаар багагүй амжилтанд хүрсэнээ эргэн санахад таатай байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэн төгөлдөржүүлэх чиглэлд онцгой анхаарч ажилласны үр дүнд Засгийн газрын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай, Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай зэрэг дөрвөн хуулинд нэмэлт өөрчлөлт, мөн Төрийн байгууллагуудын бүтцийн тухай УИХ-ын хоёр тогтоолд нэмэлт өөрчлөлтийг оруулсанаар гамшиг осолтой тэмцдэг мэргэшсэн тус байгууллагыг Онцгой байдлын алба буюу Онцгой байдлын Ерөнхий газар болгон өөрчлөн зохион байгуулж чадсан юм. Хууль, эрх зүйн орчныг ийнхүү шинэчлэх явцад миний баримталсан нэг гол зарчим бол Онцгой байдлын албаны үйл ажиллагааны үндсийг эхнээс нь зөв голдрилоор хөгжүүлэн бүрдүүлэхийг чармайсан бөгөөд олон улсын гэрээ, конвенц бусад орны хууль тогтоомжийг судалж харьцуулах, өөрийн орны онцлог, бодит нөхцлийг олж харах, хууль, эрх зүйн актуудтай нийцүүлэх гэх мэт амаргүй даваа олныг гэтэлсэн.

Онцгой байдлын албаны талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг бий болгосноор гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршгийг түргэн шуурхай арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанартай, үр өгөөжтэй хүргэх эхлэл тавигдсан юм. Онцгой байдлын албаны алба хаагчдад цол олгох журам, Онцгой байдлын албаны алба хаагчдын дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар, Гамшгаас хамгаалах хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, Онцгой нөхцлийн нэмэгдэл олгох тухай зэрэг олон асуудлыг Засгийн газрын тогтоолоор, Байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, Онцгой байдлын албаны төрөлжсөн дүрмүүд, Онцгой байдлын байгууллагын бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журам, Гамшгийн мэдээллийн сан байгуулах, ашиглах журам зэргийг Монгол Улсын Ерөнхий сайд болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын захирамж, тушаалаар баталгаажуулсан.

Онцгой байдлын Ерөнхий газар, түүний харьяа анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын албадуудыг шинээр байгуулах буюу өөрчлөн зохион байгуулах, Монгол Улсад гамшгаас хамгаалах удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагааг мэргэжлийн шуурхай удирдлага, зохицуулалтаар



хангах арга хэмжээ авсны үр дүнд Онцгой байдлын алба орон нутаг, хүн амд хүртээмжтэй ажиллаж эхэлснээр ард иргэдийн дундах тус албаны нэр хүнд богино хугацаанд өссөн.

Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд Нэгдсэн Үндэсний Байгууллага, Байгалийн гамшгийн аюулыг бууруулах Азийн бүсийн төв(ADRC), Азийн гамшгийн бэлэн байдлын төв(ADPC), Олон улсын иргэний хамгаалалтын байгууллага болон бусад улс орнуудын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай идэвхитэй хамтран ажиллаж харилцан техник технологи, туршлага солилцож ирснийг тэмдэглэхэд таатай байна.

Гар нийлсэн сайхан хамт олон, тал бүрийн ажлын арга туршлага, нэр хүнд, удирдан зохион байгуулах авъяас чадвар бүхий удирдлага, ажлын алба, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын Зөвлөлийн гишүүд зэрэг олон нөхдийн дэмжлэгтэйгээр бид чамгүй их ажил амжуулсаны нэг жишээ бол



### *Шүхрийн буултын дадлага сургуулийн үеэр 2005 он*

Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын анхны сайдаар томилогдон ажилласан богинохон хугацаанд зөвхөн Засгийн газрын хуралдаанаар жар гаруй асуудлыг хэлэлцүүлж, тодорхой шийдвэрүүдийг гаргуулан ажилласан нь одоо ч гэсэн эргээд ярих, дүгнэх тод ул мөр үлдээж чадсан.

Энэ албыг хаших явцад, түүний дараа ч миний сэтгэлийг байнга зовоож байдаг гол зүйл бол өөрсдөөсөө ахадсан алба үүрч эрүүл мэнд, амь насаа дэнсэн дээр тавьж байдаг Онцгой байдлын албаны офицер, ахлагч, ажилтан, албан хаагчдын маань ахуй амьдрал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдэх асуудал юм.

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, учирсан хор уршгийг түргэн шуурхай арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх шинэ техник технологи нэвтрүүлэх, гамшгаас хамгаалах сургалтыг бага сургуулиас эхлэн явуулах, анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг олгох, дадлагажуулах шаардлага тулгарсаар байна.

Онцгой байдлын албаны хамт олны Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах ард иргэдийнхээ аюулгүй

орчинд амьдрах ариун үйлсэд хоёргүй сэтгэлээр хүчин зүтгэж Эх орондоо өргөсөн тангаргаа нэр төртэй биелүүлсэн эрэлхэг охид хөвгүүдээ бахархан дурсаж, нийт бие бүрэлдэхүүн, ажилтан албан хаагч та бүхэндээ



*Сайд У.Хүрэлсүх даргын зөвлөлийн гишүүдийн хамт 2006 он*

болон гэр бүлд тань Монгол Улсын Онцгой байдлын алба үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, ажил үйлс тань улам өөдрөг бүтэмжтэй байхын ерөөлийг минь хүлээн авна уу.

**Олон түмэндээ авралын гараа сунгасан  
Онцгой байдлын алба улам өөдөө бадрах болтугай.**



ОБЕГ-ын дарга асан тэргүүн комиссар П.ДАШ:

## ЖИНХЭНЭ БААТРУУД БАЙСАН ЮМ ШҮҮ

*Та Онцгой байдлын ерөнхий газрыг анх байгуулагдахад Засгийн газрын шийдвэрээр томилогдон ирж ажиллаж байсан. Байгууллагыг анх хүлээж авахад нөхцөл байдал ямар байв?*

2003 оны 6 дугаар сарын 20-нд Гамшгаас хамгаалах тухай хууль батлагдаад Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн байгуулага байгуулахаар энэхүү хуулинд тусгасан байсан. Намайг Энэтхэгт гурван сарын дамжаанд суралцаж байхад араас утасдаж, яаралтай хүрч ир Засгийн газрын хуралдаанаар асуудал орох гэж байна гэсэн. Ингээд 2003 оны 12 дугаар сарын 29-нд эх орондоо ирээд 2004 оны Засгийн газрын анхдугаар хуралдаан нэгдүгээр сарын 7-ны өдөр болдог юм. Тэр хуралдаанаар Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулах тухай нэгдүгээр тогтоол гарч, намайг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргаар томилсон. Гурван өөр яамны харьяанд байсан газрын суурин дээр ГХЕГ-ыг байгуулах шийдвэр гарч энд байсан гурван байгууллагын дарга нар бүгд Засгийн газрын тогтоолоор ажлаас чөлөөлөгдсөн байсан. Тэр өдрөө төвд байгаа анги байгууллагуудтайгаа танилцаж ажлаа эхэлсэн. Хамгийн чухал нь байгууллагаа байгуулж авах байсан учраас чөлөөлөгдсөн хүмүүсийг өөрийнхөө тушаалаар орлогчоороо томилж бүтэц, орон тоогоо хийсэн. ГХЕГ нь 108 хүний бүтэц орон тоотой байхаар тогтож Ерөнхий сайдаар бүтэц бүрэлдэхүүнээ батлуулаад ажилдаа орсон доо.

*Ажлаа юунаас эхэлж байв?*

Гарт барьчих эрх зүйн баримт бичиг Гамшгаас хамгаалах тухай хуулиас өөр зүйл байгаагүй. Маш олон дүрэм журмыг шинээр боловсруулах шаардлага гарч ирсэн. Нэгэнтээ л ГХЕГ гээд байгуулагдсан юм чинь тэр өдрөөсөө эхлээд л гамшиг осолтой нүүр тулан тэмцэж ажиллах учиртай, гамшгийн асуудлаа мэддэг, энэ чиглэлээр судалсан хүмүүс хэрэгтэй. Мөн гурван агентлагийн хүмүүсээ цуглуулаад хуучин Иргэний хамгаалалтын байранд байрлуулах шийдвэр гарсан байсан. Хүмүүсээ тохь тухтай орчинд ажиллах өрөө тасалгаагаар нь хангаж өгөхгүй бол хүмүүс яаж ажиллах билээ. Эдгээр асуудлыг зэрэг барьж авахаас өөр арга байгаагүй. Тэгээд холбогдох эрх зүйн актуудыг батлууллаа. Байр саваа тохижуулах гэхээр төсөв хөрөнгө оруулалт байхгүй. Гурван байгууллагын урсгал зардал нийлээд 200 сая хүрэхтэй үгүйтэй. Эхэндээ манай байгууллагын албан хаагчид хувцас формгүй байсан. Харин гал түймэртэй тэмцэх газарт хувцасны мөнгө гэж жаахан мөнгө байсныг зориулалтыг нь өөрчилж байр саваа засч сайжруулах чиглэлийг Засгийн газар, Сангийн яамнаас гаргуулж авсан. Албан хаагчдынхаа тохь тухтай орчинд ажиллах нөхцөлийг хангахын тулд бие засах газраас эхэлсэн дээ. Зориулалтыг нь өөрчилсөн мөнгө, төсвийн хэмнэлт, янз бүрийн юмнаас цуглуулж 400 гаруй сая төгрөг босгож, Онцгой байдлын ерөнхий газрын байрыг засч янзалсан. Зөвхөн төв байрыг янзалсан юм биш, урд талд нь дөрвөн давхар сургалтын төв байсан өргөтгөлийг, одоо Сүхбаатар дүүргийн прокурор байна уу даа, тэгээд арын талбай, авто граж гээд бүгд орж байгаа юм. Төсөвт ямар ч ачаалал өгөлгүй хийчихсэн юмыг мөнгө хөрөнгө идчихлээ гэж хичнээн олон жил хэл ам болж, шалгаж уржнан хэрэгсэхгүй болгосон юм шүү дээ. Уул нь бол таван жил болоод урсгал засвар, 10 жил болоод их засварт орох ёстой. Одоо 10 жил болж байна. Их засвар байтугай, урсгал засварт ч ороогүй явааг бодоход ямархуу хэмжээний засвар хийгдсэний чанар байдал нь харагдаж байгаа болов уу гэж бодогдох юм.

*Таныг дарга байх үед хийгдсэн томоохон ажлуудаасаа дурдана уу?*

2004 оны сонгуулийн дараа шинэ Засгийн газар байгуулагдаж, Гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн сайдын бүтцийг шинээр баталсан. Сайдаар нь Хүрэлсүх томилогдож ирсэн. Хүрэлсүх сайд бол УИХ-ын гишүүн шиг, Засгийн газрын гишүүн шиг ажилладаг байсан учраас эрх зүйн орчныг бүрдүүлэхэд маш хялбар байсан. Засгийн газар, УИХ-д танайх л асуудал оруулдаг юмуу гэж хэлтэл залхтал асуудал оруулж байсан даа.

Хүрэлсүх сайд богино хугацаанд байгууллага сайн ойлгож, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд өөрөөс шалтгаалах бүх зүйлийг хийсэн. Үүний хүчинд 2005 оны дунд үе гэхэд Гамшгаас хамгаалах байгууллага улс орондоо төдийгүй Олон улсын хэмжээнд мэдрэгдэх хүртэл байгууллага болж чадсан юм. 2005 оны нэгдүгээр сарын 18-нд Гамшгаас хамгаалах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж ГХЕГ гэдэг нэрийг Онцгой байдлын ерөнхий газар болгон өөрчилж албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан тодорхой заалтуудыг оруулж өгсөн. Эрхэлсэн сайдын эрх үүрэг, Онцгой комиссын эрх үүрэг, Онцгой байдал гэж юу юм бэ гэдгийг нэлээн тодорхой оруулж өгсөн өөрчлөлт болсон. Албаны нэр хүнд маш богино хугацаанд өссөн дөө. Байгууллагын



*ОБЕГ-ын удирдлагууд гавьяат тамирчин Г.Өсөхбаярын хамт 2006 он*

төсөв 200 сая хүрэхгүй байхад Хүрэлсүх сайд албаны онцлогийг УИХ, Засгийн газрын түвшинд сайн ойлгуулж чадсаны хүчинд тэрбум болгож байлаа. Азийн гамшгийн бэлэн байдлын төв, Гамшгийн аюулыг бууруулах төв, Олон Улсын Иргэний хамгаалалтын байгууллагууд гээд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадны байгууллагуудтай хамтарч ажиллаж олон асуудлыг шийдсэн. Гадаадын зээл тусламжаар 7,8 сая долларын төсөл хөтөлбөр хэрэгжсэн. Олон улсын хэмжээнд ажиллах экспертүүдийг хүртэл бэлтгэж өгсөн. Монголд Олон улсын сургалт хүртэл зохион байгуулсан. Манай байгууллага аль ч талдаа тун аятайхан төлөвшиж ирсэн. Онцгой байдлын байгууллагыг мэдэхгүй хүнгүй болж нэр хүнд нь өссөн. Сүүлд засаг төр өөрчлөгдөхийн хэрээр Онцгой байдлын байгууллагыг харах хандлага Хүрэлсүх сайдынх шиг биш ерөөсөө нөөц рүү л гол анхаарлаа тавиад дөнгөж мэргэшиж байгаа боловсон хүчнийг будилуулсан бутраасан байдлууд их гарсан учраас 2006 оны сүүлч 2007 оны эхэн үе гэхэд нэлээн их бужигнаан болсон. Улсын нөөцийн мэргэшсэн 40 төрийн албан хаагчийг хүртэл нэг дор ажлаас халчихаад байсан юм шүү дээ. Тийм сөрөг юм их гарч ирсэн. Шинэ байгууллагыг байгуулна гэдэг нэгдүгээрт их ажил байдаг, хоёрдугаарт асар их эсэргүүцэлтэй тулгардаг. Онцгой байдлын байгууллага ямар байгууллага байх, яаж ажиллах ёстой юм гэдэг үлгэр жишээг 2006 оны 6 дугаар сарын сүүл хүртэл хүмүүст мэдрүүлж ажиллаж чадсан гэж боддог юм.

***Хилийн цэргийн хүн яаж яваад Онцгой байдлын хүн болчихов оо. Таныг ямар шалгуураар томилсон юм бол?***

Намайг анх томилохдоо гүйцэтгэж байсан ажил үүрэг, ажлын туршлага гээд олон талаас харсан байх л даа. Монгол Улсын хилийн цэрэг гэдэг бол хил орчмын нутаг дэвсгэрт гарч байдаг бүхий л гамшиг осолтой тэмцэж байдаг. Ой хээрийн түймэр гарлаа гэхэд хэний ч командгүйгээр өөрсдөө ордог хүмүүс бол хилийн цэрэг. Ер нь олныг хамарсан бүх л гамшгийн үед хил хамгаалахын удирдлагууд Онцгой комисст орж ажилладаг гэдэг утгаараа түүнтэй холбогдсон шийдвэрийг гаргалцаж хамтарч ажилладаг байлаа шүү дээ. 1995 онд Буйр



нууранд фургон машинтай хүмүүс осолдоход мөсөн дээр нь өдөр шөнөгүй зогсож байгаад аврах ажиллагаа явуулж байсан хүн бол тэр үед Халх голын отрядын даргаар ажиллаж байсан манай Баттогтох хурандаа. 1993-1997 он хүртэл Онцгой комисст орж ажиллаж шийдвэр гаргалцаж явлаа. Тийм болохоор надад гамшгаас хамгаалах ажил цоо шинэ зүйл байгаагүй. Хамгийн гол нь Гамшгаас хамгаалах тухай хуулиа судлаад түүнийг хэрэгжүүлэх л асуудал байсан. Хил хамгаалах байгууллагад 32 жил ажиллахдаа 28 жилд нь тодорхой хэмжээнд заставын даргаас хилийн цэргийн штабын дарга хүртэл удирдах ажил хийж байсан учраас хүн удирдах бол асуудал байгаагүй. Байгууллагаа хөл дээр нь зогсоогоод ирэхэд надад ч сайхан байсан, манай хамт олон ч маш их сэтгэл өндөр, ард түмэн ч хүрээлсэн.

***Та байлдагчаас генерал, заставын даргаас Хил хамгаалах газрын штабын дарга, Онцгой байдлын дарга хүртэл өндөр албан тушаал хашиж Монгол төрд зүтгэсэн. Таныг шүүхээс ялласан, бас өршөөсөн. Харин та болохоор би хэрэг хийгээгүй учраас өршөөгдөхгүй, цагаатгагдана гээд ял нэмүүлсэн. Үүндээ харамсдаг уу, эсвэл ямар нэгэн өөр ноцтой шалтгаан байна уу?***

Угийн эцэг эхээс авсан хүмүүжил, үнэнч шударга зан чанар, хуулийн дагуу л ажиллах ёстой гэсэн итгэл үнэмшил, ажлаа сайн хийж байх юм бол хэзээ ч буруутах ёсгүй гэсэн бодолтой явдаг учраас элдэв хүмүүсийн бохир гарыг улсын хөрөнгө рүү оруулахгүй байх бололцоотой бүх арга хэмжээг авч хааж ажиллаж байсан. Энэ маань сүүлийн үед гарч ирсэн улс төрчдийн сэтгэлд огтхон ч нийцээгүй л дээ. Миний талаар элдэв янзын гүтгэлэг гарч эхэлсэн. Үүнд нь манай ардчилсан нийгмийн үнэт зүйлийг хамгаалж, цэх шулуун байх ёстой хууль хяналтынхан үүргээ биелүүлж чадаагүй. Улсад их хэмжээний хохирол учруулсан гэсэн зохиомол хэрэг үүсгэсэн.

***Өршөөлд хамрагдчихаж болдоггүй юм уу?***

Би өөрийгөө зовоохгүй гэвэл өршөөлд хамрагдаж болох байсан. Өршөөлийн хууль гарсан анхны өдрөөс л өршөөлд хамрагдчих гээд намайг шахаад байсан байхгүй юу, АТГ-ын мөрдөн байцаагч нар. Би үгүй ээ л гэсэн. Яагаад гэвэл би үнэний төлөө явсан. Биеийн амрыг харсан бол ашгүй өршөөгдлөө гээд алга болж болно. Юманд үнэн гэж байх ёстой. Шударга ёс гэдэг бол ардчилсан нийгмийн хэмжүүр гэж би боддог. Ийм нийгэм байж болохгүй, өөрийгөө золиослоод ч хамаагүй үнэний төлөө явна. Харсаар байж нүдэн балай чихэн дүлий явж болохгүй биз дээ.

***МИ-8 нисдэг тэрэгний осолд таныг буруутгадаг. Гэтэл тэр үед та АНУ-д томилолтоор ажиллаж байсан гэдэг. Ер нь яг юу болсон юм бэ. Одоо та сэтгэлээ онгойтол үнэнийг ярих цаг болсон юм шиг ээ...***

Үнэндээ тийм олон хүний амь насыг бүрэлгэх шаардлага байгаагүй юм билээ. Би тэр үед АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагийн шугамаар нэг хэлтсийн даргатайгаа хамт АНУ-д сургалтад явж байсан юм. Монгол руугаа нэг холбоо барьсан чинь онгоц алга болчихлоо, сүйрсэн байна гэсэн мэдээ авсан. Тэр даруйдаа сургалтаа зогсоогоод Монголдоо ирсэн. Шөнө Улаанбаатарт буугаад ажилдаа иртэл “АНУ-д зугаалж байна, дуудаад байхад ирэхгүй байна” гэсэн утгатай зүйл хэвлэлд бичсэн байсан. Харин АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлагаас албан ёсны арга хэмжээ явуулж байхад гуйвуулсан байна, үүнийгээ залруул гэж сонинд нэг хувь, надад нэг хувь бичиг өгсөн. Намайг эзгүй хойгуур энэ хэрэг гарсан. Би хаячихаад л зугаалж явсан бололтой мэдээлэл их тараасан байгаа юм. Ер нь бол намайг Онцгой байдлын албанаас холдуулах гэж янз бүрээр оролдсон. Би ирээд л аврагчдынхаа ар гэрээр шөнөжингөө явсан. Үнэхээр харамсалтай байсан. Намайг ирсэн даруй Засгийн газраас түймэр хэзээ унтарсан, юу болсон бэ гэж асууж байна гэхээр Сэлэнгийн Онцгой байдлын хэлтсийн даргаас асуухад нисдэг тэрэг нисдэгийн урд шөнө түймэр унтарсан гэсэн мэдээ өгсөн. Би энэ мэдээг Засгийн газарт бичиж өгөөд явуулсан. Тэр бичиг одоо хүртэл надад байгаа. Цаг агаар муу байхад, бороотой байхад нисдэг тэрэг нисгээд, хөдөө ажиллаад ирсэн хүүхдүүдийг амраахгүй явуулаад их л тоогүй юм хийсэн юм билээ дээ. Үүнд би маш их харамсаж байдаг. Бүхэл бүтэн нэг албыг сөнөөсөн юм шүү дээ. Гал түймэртэй тэмцдэг шүхрийн алба маань олон жилийн туршлагатай шүхэрчид гал сөнөөгчидтэй байсан юм. Үндсэндээ тэднийг бөөнөөр нь аваачаад «устгачихсан» байхгүй юу. Шилдэг шүхэрчид маань амь үрэгдлээ, манай гал түймэртэй тэмцэх байгууллагыг удирдалцаж явсан гол хоёр дарга маань, Монголын номер нэг гэгддэг байсан нисгэгч маань амь насаа алдлаа. Мэргэжлийн талаасаа ч, тэр олон хүний амь нас гэдэг талаасаа ч Онцгой байдлын албанд, манай улсад маш том хохирол болсон. Манай албанд жинхэнэ баатрууд байсан

гэвэл тэднийг л хэлнэ. Зүгээр тэмдэгт талбайд биш хэрэгцээтэй цэгт хад чулуу, ой модонд ч өлгөгдөөд бууж байдаг амь дүйсэн ажил мэргэжилтэй, түүндээ үнэнч, олон жил ажилласан туршлагатай албан хаагчдыг нөхнө гэдэг маш их цаг хугацаа орно.

**Онцгой байдлын албаны 10 жилийн ой тохиож байна. Энэ байгууллагыг удирдаж явсан хүний хувьд та хамт олондоо хандаж юу хэлэх вэ?**

Онцгой байдлын алба Монгол Улсын хувьд цоо шинэ бүтэц, байгууллага. Энэ байгууллагын тулгын чулууг би ганцаараа тавиагүй. Надтай хамт Онцгой байдлын албаны гурван мянга гаруй бие бүрэлдэхүүн



*Сайд С.Отгонбаяр ОБЕГ-ын удирдагуудын хамт жагсаал хүлээн авч байгаа нь 2006 он*

тавилцсан. Эдгээр хүмүүс энэ албанд яагаад ажиллаж байгаа юм бэ гэвэл ард түмнийхээ амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, хүрээлэн байгаа орчин, мал, амьтан бүгдийг гамшгийн аюулаас хамгаалахын тулд өөрийн амь биеийг үл хайрлан хүнд хэцүү хэрнээ бас бахархам албанд зүтгэж яваа хүмүүс. Тангараг өргөсөн эрэлхэг зоригтой охид хөвгүүд энд ажиллаж байгаа юм. Эдгээр хүмүүс маань тулгын чулууг тавилцаж, энэ цоо шинэ байгууллагыг байгуулсан. Эрэлхэг зоригтой баатрууд маань энэ хүнд хэцүү албандаа улам их амжилт гаргаж, аз жаргалтай сайн сайхан амьдраасай гэж хүсч байна. Ийм албанд ажилладаг хүмүүстээ би баярлаж бас бахархаж явдаг даа. Эр зориг шалгасан лут алба шүү гэдгийг бие сэтгэлээрээ мэдэрсэн хүн бол манай анхны сайд Хүрэлсүх сайд байдаг юм. Тэгж хүмүүсээ мэдэрч, өөрөө тэр гал түймрийг цохилцож, гамшиг осолд нь хамт явж байсан хүний хувьд бид нарт түшиг болж, энэ байгууллагын нэр хүндийг өсгөх, байгууллага шиг байгууллага болоход их чухал хувь нэмэр оруулсан гэж аврагчдаасаа дутуугүй талархаж явдаг даа. Ийм хүмүүс олон байгаасай, байгаа ч байх гэж бодож байна. Онцгой байдлын байгууллагыг хөл дээр нь босгоё, хөгжүүлье, дэмжье туслая гэж бодож явдаг бүх хүмүүстээ талархал илэрхийлье.



Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд асан С.ОТГОНБАЯР:

## САЙДААР АЖИЛЛАЖ БАЙХДАА ШУУРХАЙ БҮЛЭГ 105-ЫГ БАЙГУУЛСАН

*Таны Онцгой байдлын сайдаар ажиллаж байх үеийн улс орны нөхцөл байдал ямар байсан, ямар ямар бэрхиээлүүд тулгарч байсан бэ ?*

Юуны өмнө Онцгой байдлын албаны 10 жилийн ойн баярын мэндийг энэ салбарт ажиллаж байгаа болон ажиллаж байсан нийт албан хаагчид, тэдний гэр бүл, үр хүүхэд болон нийт аврагчид та бүхэндээ хүргэн мэндчилье. Намайг 2006 оны 5 сарын 14-нд Их хурлын тогтоолоор Онцгой байдал эрхэлсэн сайдаар томилж байлаа. Миний өмнөх сайд У.Хүрэлсүх тус албыг бэхжүүлэх тал дээр нэлээд анхаарч ажиллаж байсан. Мэдээж хэрэг төрийн залгамж ёсоор өмнөх сайдын явуулж байсан бодлого үйл ажиллагааг үргэлжлүүлэхээс гадна өөрийн зүгээс нэн яаралтай хийж явуулвал зохилтой зүйл байсан нь Монгол

улсын Онцгой байдлын албыг Олон улсын жишигт хүргэх зорилго байсан. Гамшгийн үед улс орон, ард иргэдэд тохиолдсон үер ус, ой хээрийн түймэр, гал усны гашуун зовлонгийн хажуугаар уул уурхайн хөгжлөө дагаад осол аваарууд их гардаг.

Намайг ажиллаж байхад хувиараа алт олборлогчид болон бичил уурхай эрхлэгчид 180, 200 метрийн гүнд ажиллаж байгаад наймуулаа, арвуулаа шороо нуранганд дарагдчихаад амьд эсэх нь мэдэгдэхгүй нөхцөлд хүртэл ажиллаж байлаа. Тийм үед хүний амь нас эрүүл мэндийг хамгаалахад бидэнд техник технологийн дутагдал асар их байсан. Ажил аваад удаагүй байхад Баруун Хараагийн Мухарын аманд алт ухдаг зургаан залуу 180 метрийн гүнд дарагдчихсан. Бид тав дахь хоног дээрээ өдөр шөнөгүй ажиллаж байж амьд мэнд гаргаж байв. Хамгийн наад захын техник тоног төхөөрөмжөөс гадна ийм нөхцөлд ажилладаг багаж хэрэгсэл олддоггүйгээс хүний алтан амийг аврах баталгаа байхгүй байлаа. Налайхын уурхайд 2007 оны долоон сард найман уурхайчин нуранганд дарагдчихсан. Аврагчид 180 метрийн гүн рүү орж хаана дарагдсаныг олж тогтоох боломж тааруу байсан. Ийм нөхцөлд бид 4 хоног зогсоо зайгүй ажиллаж наадмын өмнө эсэн мэнд гаргаж авч байлаа. Яагаад энэ зүйлийг онцолж байна гэхээр тэр үед төсөв хөрөнгө хүндрэлтэй, хэдэн бор аврагчид маань улаан гараараа ноцолдож байж хүмүүсийн алтан амийг аварч байлаа. Энэ бүхнээс харахад энэ албыг бэхжүүлэхэд ямар техник тоног төхөөрөмж хэрэгтэй вэ гэдэг дээр онцгойлон анхаарсан. Засгийн газарт ч асуудлуудыг тавьж байлаа.

***Засгийн газарт тавьсан асуудлыг тухайн үеийн төр засаг хэрхэн шийдэж байв?***

Ерөөсөө бид орчин үеийн техник хэрэслээр хангагдахгүй бол болохгүй юм байна гэж Засгийн Газарт асуудал тавьж нэмэлт хөрөнгө оруулалтын хэлбэрээр тухайн үеийн ерөнхий сайд М.Энхболдын шийдвэрийг гаргуулж байж, Шуурхай аврах бүлэг 105-ыг байгуулсан. Манайд ийм шуурхай алба байгаагүй. Олон улсын стандарт түвшинд хүргэхээр олон улсын аврах ажиллагааны талаар нэлээд судалгаа хийсэн. АНУ-д 911, Солонгост 111 гээд байх жишээтэй. Ийм тусгай аврах бүлгийг байгуулах шийдвэрийг гаргаж тэдэнд зориулсан сургалтуудыг явуулж, техник технологийн хангалтуудыг хийж өгсөн. Хамгийн сүүлийн үеийн техник технологитой улсуудаас ОХУ дэлхийд нэлээд дээгүүрт ордог. Монгол улс гамшгийн үед хэрэглэхээр технологийн хувьд бүрэн хангагдсан иж бүрэн тоног төхөөрөмжийг ОХУ-ын Онцгой байдлын сайд С.К.Шойгутай ярьж түүний дэмжлэгтэйгээр анх удаа авчирч хүмүүсээ хүртэл тэдний тусламжтайгаар сургаж авсан. Автомашинь ослоос болж хүн хавчуулагдахад хайчилж салгадаг багажтай болж Шуурхай бүлэг 105 маш амжилттай ажилласан. Хийсэн ажлууд маань энэ мэтчилэн үр дүнгээ өгч байна, үүнээс ч илүү үр дүнтэй ажиллах ёстой.

***Аврах техник тоног төхөөрөмж гээд шийдэхэд хүндрэлтэй асуудлууд их байсан байх. Энэ тал дээр шийдэж өгсөн томоохон асуудал байгаа юу. Олон мянган аврагчтай энэ байгууллагын аврагчдын нийгмийн асуудал хамгаас чухалд тооцогдох асуудлын нэг яах аргагүй мөн байх шүү.***

Миний анхаарлыг хамгийн их татсан асуудал бол туулах чадвар бүхий автомашинаар хангах зайлшгүй

шаардлага тулгарсан. Аврах ажиллагаанд шаардлагатай багаж тоног төхөөрөмж техник хэрэгсэл дутагдалтай байхад би үнэтэй машин унах ёсгүй гээд өмнөх сайдын хөдөө ажлын хаммер машинаас татгалзсан.Техник



*Сайд У.Хүрэлсүх, С.Отгонбаяр нар ажил хүлээлцэж байгаа нь 2006 он*

тоног төхөөрөмжөөр хангахад хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хэмжээнд зайлшгүй шийдвэл зохилтой хэд хэдэн асуудал байсан. Тэр хаммер машинаа БХЯ руу блансаар шилжүүлж 39 ширхэг Газ 66 машин авч бүх аймаг орон нутгийн Онцгой байдлын газрууддаа өгсөн. Сүхбаатарын талбай дээр ОБА-ны өдөрлөгөөр тарааж өгч байсныг хүмүүс санах байх аа. Аврах тусгай анги дээр улсын хөрөнгө оруулалтаар орон сууцны асуудлыг сэргээн засварлаж дэмжлэг туслалцаа үзүүлж байсан. Намайг байхад 3800 орчим бие бүрэлдхүүнтэй байсан алба. Энэ хүмүүсийн нийгмийн асуудал дээр онцгой анхаарах ёстой. Төр гэж байгаа бол ийм хүнд хүчир албыг залгуулж байгаа албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдэж өгөх шаардлагатай. Үнэхээр төрийн тусгай алба учраас хувцаслаж байгаа юм. Авдаг цалин бага, нэмэгдлээ гээд өнөөдрийн үнийн өсөлтөө гүйцэж чадахгүй байна шүү дээ.

***Таныг сайдаар ажиллаж байх үед Ми-8 нисдэг тэрэгний осол болж олон аврагчид амь үрэгдсэн. Осол гарсанаас хойш нэлээд хэдэн жил өнгөрчээ. Гэвч энэ үйл явдлыг хүмүүс мартаагүй, янз бүрийн яриа гарч байдаг. Энэ талаар хамгийн бодитой байр суурь илэрхийлэх хүний нэг бол та шүү дээ.***

Аврагчид маань ажил үүргээ гүйцэтгэж яваад Ми-8 нисдэг тэрэгний ослоор үрэгдсэнийг Монголын ард түмэн бүгд л мартдаггүй. Энэ бол туйлын харамсалтай явдал болсон. Мэдээж салбар хариуцсан сайдын хувьд надад тийм амар байгаагүй. Өнөөдөр бид гал усны гашуун зовлонг сөрж яваад амь насаа алдсан олон аврагчдын гэгээн дурсгалыг цаг ямагт дурсаж, эх орныхоо төлөө эр цэрэг шиг явж байгаад амь үрэгдсэн дайчин баатар аврагчдаа дурсан санаж, хүндэтгэж явах ёстой. Энэ үйл явдалд олон дутагдалтай зүйлүүд байсан. Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаварыг хожуу биелүүлж бэлтгэсэн асуудал байдаг. Тэр үед болсон нарийн юмыг ярьвал, ийм юм болохгүй байх байлаа. Мэдээж хэрэг Засгийн газар Ерөнхий сайд үүрэг өгөх, асуудал эрхэлсэн сайд нь үүрэг өгөх гэдэг хуулиар олгогдсон бүрэн эрх байлаа. Ямар ч тохиолдолд үүрэг өгч болно. Зөв



тооцоолж ажиллах нь мэргэжлийн албадуудын үүрэг байдаг. Би тэр үед Швейцарийн Женев хотод Олон улсын хуралд оролцож байсан. Улс оронд их хэмжээний ой хээрийн түймэр гараад битүү утаа мананд бүрхэгдсэн байлаа. Намайг хурлаас дуудаж, бүх хүчээ дайчлаад яаралтай арга хэмжээ ав гэсэн үүргийг Засгийн газраас өгсөн. Онгоц нисдэгийн урд орой би Бээжингээр дамжиж нисч ирсэн. Маргааш өглөө нисэхээр бэлтгэсэн сайд аа гэж танилцуулж байсан. Гэтэл Их хурлын шалгалтаар хэзээ хойно төвөөс нэмэлт хүч хэрэггүй байна гэдэг мэдээллийг нуун дарагдуулсан тодорхой нөхдүүд, хувийн сонирхлоор заавал нисэх тийм шалтгаан үүсгэсэн байдаг юм. Удирдлагыг буруу мэдээллээр хангаж, хариуцлага алдсан хүмүүс байгаа. Засгийн тэргүүнийг



*Сайд С.Отгонбаяр, сайдын зөвлөлийн гишүүдийн хамт 2007 он*

хүртэл буруу мэдээллээр хангасан. Нэгэнтээ миний хариуцаж байсан салбар учраас би тэр үед бүх галыг өөр дээрээ авсан. Хэн ямар зүйл ярьж, хэн ямар үүрэг даалгавар өгч байсан яагаад намайг эзгүй байхад явах гээд байв гээд үйл явдлыг харахаар үнэхээр харамсалтай. Мэдээж хэрэг төр засгийн өмнө тодорхой үүрэг хүлээгээд улс орны өмнө том албыг толгойлно гэдэг амаргүй. Гэхдээ л бүх асуудлыг шийдэхийн төлөө энэ байгууллагын ажлыг алдчихгүй аврагч албан хаагчдын ажлын нөхцөл шаардлагыг бүрэн хангаж чаддаггүй юмаа гэхэд байх түвшинд нь байлгахын төлөө зүтгэж ирсэн.



Монгол Улсын Шадар сайд асан М.ЭНХБОЛД:

## МАНАЙ АВРАГЧИД ОЛОН УЛСЫН АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОНД БАХАРХДАГ

Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайд, Улсын Онцгой комиссын даргаар ажиллаж байсан УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга М.Энхболдтой ярилцлаа.

*Та Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайдаар ажиллаж байсан хүний хувьд Онцгой байдлын албыг дэндүү сайн мэднэ. Таныг Шадар сайдын албыг хүлээн авахад Онцгой байдлын албаны үйл ажиллагаа ямар байв. Та юуг сайжруулахад анхаарлаа хандуулж ажилласан бэ?*

Юуны өмнө өнөөдөр Онцгой байдлын алба үүсч байгуулагдсан 10 жилийн ой болж байгаа учраас энэ байгууллагад ажиллаж байгаа офицер, ахлагч, аврагч нийт бие бүрэлдэхүүнд болон анх үүсгэн байгуулагдах цагаас эхлэн энэ албанд ажиллаж байсан ахмадуудад Онцгой байдлын алба үүсч хөгжсөний 10 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлж, энэ байгууллагын хамт олны цаашдын ажил үйлс үргэлж өөдрөг байж хүмүүсийн аж амьдралд дэм тус болсон, улс оронд тохиолдсон хүнд хэцүү зүйлийн ард дандаа амжилттай гарсан ийм сайхан амжилт бүтээл нь ундарсан хамт олон байхын ерөөлийг өргөн дэвшүүлж байна.

Энэ алба бол Иргэний хамгаалалтын албаас үүсэлтэйгээр байгуулагдсан юм. Монгол Улсад Онцгой байдлын албыг байгуулахад бид Олон улсын байгууллагуудтай ярилцаж, зөвлөлдөж энэ байгууллагыг байгуулж ажилласан. Энэ байгууллага байгуулагдах үед нь би бас УИХ, Засгийн газрын шийдвэрийг гаргахад оролцож, сүүлд би таван жилийн хугацаанд Улсын Онцгой Комиссын даргын албыг хашсан. УОК-ын хийж хэрэгжүүлэх ёстой бүх ажлын ар тал нь болж, мэдээ материалыг нь цуглуулж, гарах бодлого шийдвэрийн төслийг нь боловсруулж байсан газар бол Онцгой байдлын ерөнхий газар, Улсын Онцгой комиссын нарийн бичиг дарга, түүний албад байгаа юм. Би энэ албыг толгойлж Монгол Улсын Шадар сайд, Ерөнхий сайдын албыг хашиж байхдаа хамгийн гол нь энэ байгууллагын бие бүрэлдэхүүний мэдлэг боловсрол, гамшиг ослоос ард иргэдийн өмч хөрөнгийг авран хамгаалах тэр арга техникт суралцах боломж бололцоог бүрдүүлэх, нөгөөтэйгүүр энэ байгууллагын техник хэрэгслийн чадавхийг сайжруулах тал дээр ихээхэн анхаарч ажилласан. Намайг ажиллаж байх хугацаанд нийтдээ 13 томоохон объектууд шинээр баригдаж, бараг 20 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж төв болон орон нутагт байгууллагын чадавхи нэлээд хэмжээгээр өссөн. Жил болгоны төсөвт байгууллагын техник тоног төхөөрөмжийг шинэчлэхэд хоёр тэрбум төгрөг зарцуулдаг байсныг найман тэрбум төгрөг болгож нэмэгдүүлсэн. Зөвхөн нэг жилийн үйл ажиллагаагаар хөрөнгө оруулалтын хэмжээг 4 дахин нэмэгдүүлнэ гэдэг бол энэ хэмжээгээр байгууллагын үйл ажиллагаа сайжрах нөхцөл бүрдсэн гэсэн үг юм.

Нөгөөтэйгүүр энэ байгууллагын ажиллах эрх зүйн орчин нөхцөлийг сайжруулах тал дээр анхаарч, ажиллаж байсан хүмүүсийн санал бодлыг тусган орон нутагт ажиллах нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах асуудлаар төрөөс баримтлах бодлого, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг сайжруулах үндэсний хөтөлбөр гэсэн хоёр томоохон бичиг баримтыг би УИХ-аар оруулж батлуулж байсан. Эдгээр баримт бичиг батлагдсанаар Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаа, чиглэл, зорилго тодорхой болж энд ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн асуудалд нааштай ахиц өөрчлөлт гарсан гэж бодож байна.

*Онцгой байдлын алба бол эр зоригийн алба. Таныг ажиллаж байх үеийн бахархам үйл явдлаас онцолж дурдахгүй юу?*

Намайг ажиллаж байх хугацаанд олон удаагийн гамшигийн нөхцөл байдал үүсч байсан. Үүнээс дурдахад Улаанбаатар хотод гол эх үүсвэр нь гарсан H1N1 гэж хүний амьсгалын замын хурдан тархдаг хүнд өвчин гарч Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа хомс болсон учраас Онцгой комиссын түвшинд улсын хэмжээнд

өндөржүүлсэн байдал зарлаж ажиллах шаардлага гарсан. Мөн 2010 онд байгаль цаг агаарын хүнд нөхцөл үүссэн. Сүүлийн 40 жилд болж байгаагүй ийм цас зуд боллоо гэдэг асуудлыг манай хөдөөгийн ард иргэд ярьж байсан. Зөвхөн 2010 оны зуданд гэхэд УОК зохион байгуулж 45 тэрбум төгрөгийн зардлыг гаргасан. Энэ



*Монгол улсын Шадар сайд М.Энхболд гавьяа байгуулсан аврагчдад шагнал гардуулав 2008 он*

мөнгийг гадаад дотоодын байгууллагын хандив дэмжлэг, УИХ, Засгийн газрын тодорхой шийдвэрийн үр дүнд босгож гамшигт байдлаас гарсан юм. Олон мянган иргэн малгүй болж амьжиргааны эх үүсвэрээ алдсан хүнд үе байсан. Шүлхий өвчин нэг бус удаа гарч байв. Бид маш шуурхай ажиллаж шүлхий гэдэг нь тогтоогдонгуут Засгийн газрын хуралдааныг зохион байгуулж тодорхой арга хэмжээнүүдийг авч тархах нөхцлийг хаах асуудалд анхаарал тавьж ажиллаж байлаа. Хавар намрын хуурайшилтын үед манай улсын олон мянган га ой, хээрийн бүс түймэрт өртөх үйл явдал гарч, орон нутгийн Онцгой байдлын албадад дэмжлэг үзүүлж хүн хүч гаргаж ажиллаж байв. Хаврын улиралд салхи, шороон шуурга гарч зүүн бүс нутагт нэг удаа салхины хурд 28-30 секунд хүрч өмч хөрөнгө эвдрэх, малдаа явсан хүүхэд багачуудын амь нас эрсдэх харамсалтай тохиолдлууд гарч байсан.

Мөн намайг энэ байгууллагыг удирдаж ажиллаж байх үед улс орныхоо төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж гал гамшгийн аюулаас иргэдийн амь нас, өмч хөрөнгийг авран хамгаалах зорилготой явсан манай Онцгой байдлын албаны аврагчид маань МИ-8 нисдэг тэрэгний ослоор, мөн Дорнод аймгийн Баяндун суманд гарсан хээрийн түймэрт амь насаа алдсан харамсалтай үйл явдал болж байсан. Өнөөдөр хэдийгээр баярын өдөр ч гэсэн болж өнгөрсөн гашуун зовлон, амь үрэгдсэн нөхдөө дурсан санаж, тэднийхээ ар тал гэр бүлд нь дэмжиж туслах ажлыг хийх ёстой гэдгийг энэ байгууллагатай холбоотой ажиллаж байсан хүний хувьд хэлэхийг хүсч байна.

Нэг онцлог үйл явдал гэвэл Япон улсад далайн гүний газар хөдлөлтийн улмаас Цунами болж олон хот тосгод, хүний амь нас сүйдсэн гамшиг болсон. Энэ үед УОК Засгийн газрын ээлжит бус хуралдааныг зохион байгуулах саналыг тавьж Засгийн газрын нөөцөөс нэг сая доллар гаргаж, Монголын ард иргэдээс нэг сая

доллартай тэнцэх хэмжээний хандив цуглуулж Японы ард түмэнд 2 сая долларын дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж Японы Засгийн газарт хүлээлгэн өгч байсан. Үүний зэрэгцээ Монголын 12 хүний бүрэлдэхүүнтэй аврах баг анх удаагаа Олон улсын хэмжээний аврах үйл ажиллагаанд баг бүрэлдэхүүнээрээ очиж оролцож байсан бахархуштай үйл явдлыг баярын энэ өдөр цохон тэмдэглэхийг хүсч байна. Маш богино хугацаанд Монголын аврах баг ирж бидэнд дэмжлэг туслалцаа үзүүлсэн хэмээн тухайн үеийн Японы Засгийн газрын удирдлагууд талархлаа илэрхийлж байсан юм.

**Та өмнөх болон одоогийн Онцгой байдлын сайд, дарга нарын үйл ажиллагаанд хэр сэтгэл хангалуун байдаг вэ? Онцгой байдлын албыг цаашид бэхжүүлэх талаар таны бодол...**

Онцгой байдлын алба бол маш шуурхай, түргэн шийдвэр гаргадаг, өөрийнхөө салбарын нөөц бололцоо, аврагчдынхаа хүч чадлыг мэдэрдэг хүмүүс удирдаж ажиллах ёстой ийм алба. Ингэж байж улс орны өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ. Онцгой байдлын албаныхныг би улсыг аюул, гамшгаас хамгаалах ажилдаа улам бүр дадлагажиж мэргэшиж байгаа хүмүүс гэж боддог. Мэргэшсэн хүмүүсийг тогтвортой сайн ажиллуулах, шинэ залуу боловсон хүчнийг сургаж дадлагажуулах явдал бол энэ байгууллагын хамгийн гол асуудал байх ёстой. Үүнд одоогийн ажиллаж байгаа удирдлагууд ч анхаарч ажиллана гэж итгэж байна. Арван жилийн ойн энэ үеэр гаргасан ажил амжилтаа дурдаж ярихын зэрэгцээ ойрын ирээдүйд энэ байгууллагын өмнө ямар гол зорилтыг дэвшүүлж тавих вэ гэдгээ өнөөгийн удирдлагууд бодож боловсруулж, Монголын Онцгой байдлын албаны гамшгаас хамгаалах ажлыг улам эрчимжүүлсэн арга хэмжээнүүдийг хийж баяраа тэмдэглээсэй гэж хүсч байна.

**Манай Онцгойгийнхон таныг одоо ч Шадар сайдаа л гэдэг. Баярын өдрийг тохиолдуулан бие бүрэлдэхүүнд хандаж юу хэлэх вэ?**

Гамшгаас хамгаалах албаны нөхдүүдийг Монголын ард түмэн Онцгойгийнхон гэж ярьдаг. Өнөөдөр 10 жилийнхээ ойг тэмдэглэж байна. Дахин баярын мэнд дэвшүүлье. Та бүхний хийсэн бүтээсэн, ажил амьдралдаа хуримтлуулсан туршлага бүхэн бол Монгол орны ирээдүйн хөгжил цэцэглэлт, ирээдүйн аюулаас хамгаалах асуудалд бодит хувь нэмэр болох учиртай. Анхаарах ёстой нэг асуудал бол хот суурин газар үүсч болох гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, ялангуяа газар хөдлөлтийн аюул осол болзошгүй байгаа учраас энэ асуудалд улам бүр мэргэшиж дадлагажиж ажиллах шаардлагатай байна. Би ажлыг нь эхлүүлснээ бол сайн санаж байна, гамшгаас амжиж анхааруулах систем гэж Улаанбаатар хот, аймгийн хэмжээнд анхны хөрөнгийг



тавиулж, төсвийг нь батлуулж байсан, энэ ажлаа эрчимтэй сайн хийх хэрэгтэй. Онцгой байдлын албаныхан маань өөрсдийнхөө мэдлэг боловсролыг улам дээшлүүлж, ажилдаа шамдаж сайн ажиллах нь чухал. Онцгой байдлын албанд ажиллаж байгаа нийт бие бүрэлдэхүүний ар тал гэр бүл, эцэг эх нь өөрийнхөө хүүгийн, хань ижлийн албаны онцлогийг сайн ойлгож, улс орныхоо аюулгүй байдлын төлөө ажиллах энэ онцгой үйлсдээ өндөр амжилт гаргахыг хүсэн ерөөе.



ОБЕГ-ын дарга асан тэргүүн комиссар Ц.АМГАЛАНБАЯР:

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ЦОЛ ХАЙРЛАХ ЁСТОЙ ЦОЛ ШҮҮ

**Та ОБЕГ-ын даргаар томилогдон ирж байсан үеэ дурсана уу.**

2007 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын шадар сайд М.Энхболд дууддаг юм. Тэр үед би Цагдаагийн дээд сургуулийн захирлын алба хашиж байсан. Чамайг ОБЕГ-ын даргаар ажиллуулах боллоо, маргааш Засгийн газрын хурлаар орно шүү гэсэн гэнэтийн мэдээ байлаа. Би сургуулиа төгссөнөөс хойш Цагдаагийн байгууллагаас өөр газар ажиллаж байгаагүй. Ингээд 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ОБЕГ-ын даргаар томилогдож ирсэн. ОБЕГ-т би яг таван жил ажиллажээ. Өнөөдөр байгууллага маань 10 жилийн ойгоо тэмдэглэх гэж байна. Энэ 10 жилийн 5 жил нь миний ажилласан таван жил, тавин хувь нь гарцаагүй надтай холбогдож байгаа учир би хамт

олноороо бахархаж байдаг. Онцгой байдлын алба бол эр зоригийн шалгуур алба юм. Онцгой байдлын албанд ухаантай, зоригтой, хүн чанар сайтай хүн л ажиллах алба даа.

**Та өөрийн ажиллаж байсан он жилүүдээ дүгнэж хэлэхгүй юу?**

2007 оны 12 дугаар сараас 2012 оны 10 дугаар сар хүртэлх хугацаа бол Онцгой байдлын байгууллагад их бүтээн байгуулалтын он жилүүд байсан. Бид Монгол улсад орчин цагийн Онцгой байдлын байгууллагыг жинхэнэ утгаар нь бий болгож хөгжүүлэх эхлэлийг тавьж чадсан. Бид анх удаа Олон улсын хэмжээнд аврах үйл ажиллагаанд оролцсон. Япон улсад болсон хүчтэй газар хөдлөлт цунамид манай албан хаагчдын бүлэг очиж аврах, эрэн хайх үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэ үйл явдал Монголын аврагчид Олон улсын түвшинд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай болсныг харуулсан. Япон улсын Засгийн газраас Монгол улсын Засгийн газар болон ОБЕГ-ын удирдлагад албан ёсоор талархал илэрхийлж байлаа. Албан хаагчдын дунд албаны болон мэргэжлийн сургалтууд байх ёстой гэж үзээд энэ сургалтыг шинээр бий болгосон. Энэ талаар дотооддоо төдийгүй гадаад улс руу чиглэсэн үйл ажиллагаа явуулсан. БНСУ-ын Онцгой байдлын албатай нарийн нягт холбоо тогтоож чадсан. Солонгосын Онцгой байдлын удирдлагын урилгаар манай удирдлагууд албан ёсоор айлчлал хийж, Солонгосын аврах 119-р тусгай сургалтын төв бааз дээр албан хаагчдаа үнэ төлбөргүй сургаж дадлагажуулах яриа хэлэлцээрийг бүрэн дүүрэн хийж чадсан. Үүний үр дүнд манай төв, орон нутгийн 100 гаруй албан хаагч 14-21 хоногийн сургалтад хамрагдсан. Үүнээс гадна ОХУ-ын Онцгой байдлын яамтай холбоо тогтоож албаны айлчлал хийсний үр дүнд Байгаль нуурын эрэг дээр байдаг Оростоо томоохонд тооцогдох Онцгой байдлын сургалтын төв дээр аврагчдаа жилд 2 удаа сургалтанд хамруулдаг болсон. Манай аврагчид Япон улсад аврах ажиллагаанд Солонгост багшилж байсан аврагч багш нартайгаа мөр зэрэгцэн оролцож байлаа. ОХУ-ын Онц байдлын яамны удирдлагын академид 2009 оноос хойш жил болгон гурван удирдах ажилтнаа, Москвагийн галын инженерийн академид жил болгон 6-8 албан хаагчаа сургаж, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг хийж байна. Мөн хөрш БНХАУ-ын Нийгмийн аюулаас хамгаалах яамтай холбогдож, тэдний зохион байгуулж байгаа ажиллагаанд албан хаагчдаа оролцуулж ирлээ.

**-Албан хаагчид албаны болон техникийн өндөржүүлсэн бэлэн байдалд байх ёстой. Энэ талаар хийсэн ажлаасаа танилцуулна уу?**

Гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд техникийн бэлэн байдлыг хангах үүднээс бид Автобаазыг ОБЕГ-ын даргын 576 дугаар тушаалаар шинээр байгуулж байлаа. Анх 463 нэгж бүхий техниктэй, авто бааз, засвар оношлогоо гэсэн хоёр төвтэйгээр бий болгосон. Жилдээ хоёроос доошгүй удаа бүх аймгуудаар явж техник хэрэгсэлд үзлэг хийж, шаардлагатай оношлогоо тавьсанаар засвар үйлчилгээний бригад явуулж засах системтэй болсон. Мөн Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкад хүсэлт тавьж Улаанбаатар хотын Гал унтраах ангиудын галын машинуудыг шинэчлэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ нь Улаанбаатар

хотод аврах үйл ажиллагаа явуулахад маш том хөрөнгө оруулалт болсон юм.

**Онцгой байдлын албан хаагчдын хувцас хэрэгсэл маш чухалд тооцогдох анхаарал татах асуудлын нэг мөн байх шүү...**

Ажлаа дөнгөж авчихаад би нийт албан хаагчдынхаа хувцасны үзлэгийг хийсэн. Тэгэхэд өвлийн улирал байсан, зарим албан хаагч өвлийн гуталгүй идэр есийн хүйтэнд хавар намрын гуталтай байсан. Өвлийн хангалт үндсэндээ шаардлага хангахгүй хуучирч муудсан байлаа. Хувцас хэрэглэлийг шинэчлэх шаардлагатай байсан тул бусад гадаад улс орнуудад Онцгой байдлын албаны аврагч, гал сөнөөгчид ямар хувцас форм өмсч



***ОБЕГ-ын дарга Ц.Амгаланбаяр тэргүүтэй төлөөлөгчид АНУ-д 2011 он***

байгааг ШУТИС-д захиалга өгч судалгаа хийлгэн, албан хаагчдын хувцасны материалын стандартыг тогтоож, шинэчлэн хийсэн. Мөн хувцас формны хийц, өнгө зүсийг сайжруулах тал дээр их анхаарч ажилласан.

***Одоо мөрдөж байгаа цол ч бас тухайн үед хуулиар өөрчлөгдөн шинэчлэгдэж байсан уу?***

Тухайн үед Гамшгаас хамгаалах хуулинд өөрчлөлт оруулахад шадар сайд М.Энхболд идэвхи санаачилга гарган зүтгэсэн. УИХ-аас Гамшгаас хамгаалах хуульд өөрчлөлт оруулж байж одоогийн мөрдөж байгаа цол бий болсон. Тухайлбал Онцгой байдлын албаны одоо мөрдөж байгаа цолны нэршлийг баталгаажуулсан юм. Тус албаны удирдлагад цэргийн дээд цол олгож болохоор хуулийн нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлт манай албан хаагчдын сэтгэлд нэлээд нийцсэн зүйл болсон. Ер нь Онцгой байдлын албаны цол бол тэр албан хаагчийн нүүр царай юм. Ийм ч учраас цолонд хянамгай хандах ёстой гэдгийг хэлэх хэрэгтэй. Цол бол тухайн албан хаагчийн ажлын үр дүнгийн, албан тушаалын, мэдлэг боловсролын, зүтгэлийнх нь илэрхийлэл юм. Ингэхээр Онцгой байдлын албаны цол бол хайрлах ёстой цол шүү гэж хэлмээр байна.

***Хөдөө орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэстээ хэр анхаарч ажиллаж байсан бэ?***

Төв орон нутагт Аврах гал унтраах 9 ангийг шинээр барьж, ашиглалтанд оруулсан. Ингэхдээ Аврах гал унтраах ангийг нэгдсэн стандарт зурагтай болгосон. Аврах гал унтраах 3-р зэрэглэлийн анги ямар байх,

2-р зэрэглэлийн анги ямар байх вэ гэсэн стандарт зурагтай болгоод энэ стандарт зураглалын дагуу барилгуудаа барьсан. Мөн албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг давхар шийдэж шинээр барьж байгаа аврах гал унтраах ангиудынхаа дээд талд албан хаагчдынхаа орон сууцыг барьж өгсөн.

**Ми-8 нисдэг тэрэгний ослоор амь эрсэдсэн хүмүүсийн ар гэрийн асуудлыг хэр анхаарсан бэ. Одоо тэдэнтэй холбоотой байдаг уу?**

Ми-8 нисдэг тэрэгний ослоор амь үрэгдсэн аврагчдынхаа ар гэрийхэнтэй холбоотой ажиллаж ирсэн. Ажиллаж байх хугацаандаа Шадар сайдад уламжилж түүний тусламжтайгаар ар гэрт нь байрны асуудлыг шийдэж өгсөн. Мөн ээж, аавуудыг нь жилд нэг удаа бүх зардлыг нь дааж, амралт сувилалын газар сувилуулж байгаа. Ажил үүргээ гүйцэтгэж яваад амь үрэгдсэн албан хаагчдадаа зориулан дурсгалын цогцолбор барьж босгосон. Жил бүрийн 6 сарын 14-ний өдөр нийт албан хаагчид маань нөхдийнхөө гэгээн дурсгалыг хүндэтгэж байдаг.

**Онцгой байдлын албаны онцгой үүрэгтэй албан хаагчдаараа бахархаж байсан өдрүүд танд олон байсан бизээ. Тийм үйл явдлаас нэгийг онцлон дурдана уу?**

Хөвсгөл нууранд шатахуунтай машин цөмөрч унасаныг хүмүүс санаж байгаа байх аа. Хөвсгөл далайн 50 метрийн гүнд 13 тонн шатахуунтай цистерн хэрвээ шатахуунаа асгасан бол дэлхийн цэнгэг усны гуравны нэгийг бүрдүүлж байгаа Хөвсгөл далай бохирдож маш ноцтой экологийн сүйрэл учирч болохуйц байсан. Энд манай аврагчид үнэхээр баатарлаг ажилласан. Аврах тусгай ангийн аврагчид, Хөвсгөлийн аврагчидтай цуг ажиллаж өвлийн тэсгим хүйтэнд 50 метрийн гүн ус руу шумбасан. Энэ бол Монгол улсын түүхэнд байгаагүй үйл явдал болсон шүү.

**Энэ албаны даргаар ажиллаж байхдаа таны амьдралдаа хэвшүүлсэн зүйл юу байдаг вэ?**

Онцгой байдлын албаны албан хаагчид 24 цагийн бэлэн байдалд байдаг. Түймэрт амь насаа алдсан, үер усанд урслаа гэсэн гашуудалт мэдээ байнга сонсож байдаг. Тийм ч учраас энэ ажиллаж байсан 5 жилийн хугацаанд утсаа ганц удаа ч унтрааж үзээгүй. Өөрийн удирдлаганд ажиллаж байгаа бүх ажилчдаа 24 цагийн турш гар утсаа унтраахгүй, байнгын бэлэн байдалд байхыг шаарддаг байсан. Намайг ажиллаж байхад даргын зөвлөлд ажиллаж байсан дэд дарга Намсрай, одоо дэд даргаар ажиллаж байгаа Бадрал, Гал түймэртэй тэмцэх газрын дарга Хишигбаатар, Залуухүү, Улсын нөөцийн газрын дарга Батсайхан, Гамшигтай тэмцэх газрын дарга Цогтбаатар, санхүү хэлтсийн дарга Ганбаатар, УОК-ын нарийн бичгийн дарга Энх-Амар нар бүгд л идэвхи санаачилгатай ажиллаж ирсэн. Эдгээр хүмүүстээ талархаж явдаг.




*Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ОБЕГ-т 2009 он*

## ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦОМОГ



*Шүхэрчин аврагчид эх орны дуудлагаар...*



*Аврагчид химийн хорт бодис бүхий агуулахыг ариутгаж байна*





*Тэсэрч дэлбэрэх аюул бүхий бодисыг устгаж байгаа нь*



*Аврагчдад хором бүр үнэтэй*



*Хүйтэн усанд эрэн хайх, аврах ажиллагаа явуулах тийм ч амар биш*



*Ойн түймрийг цурманд оруулж унтрааж байгаа нь*



*Онцгойнхон олуулаа байхдаа хүчтэй*



*Аврагчид байгаа болохоор иргэд амгалан*



*Хөвсгөл далайн гүнээс шатахуунтай тээврийн хэрэгслийг гарган авч байгаа нь 2011 он*





*Нүхтийн осол 2011 он*



*Хүчтэй шуурганы улмаас гэмтсэн өндөр хүчдэлийн шугамыг засч байгаа нь*



*Усанд аврах, эрэн хайх ажиллагаа*





*Гал сөнөөгчид объектэд гарсан галыг шуурхай унтраалаа*





*Монголын аврагчид Цунамигийн голомтод Япон улс 2011 он*



*Шүхрийн буулт*





*Шуурхай бүлэг 105-ын үйл ажиллагаа*





*Тэд гамшигийн голомтод түрүүлж очдог*





*Гамигаас хамгаалах иж бүрэн сургууль Дархан - Уул аймаг 2011 он*





*Цагийн байдлыг илтгэж байна*



*Гамигийн голомтод*



Аврах ажиллагааны үзүүлэх сургууль





*Тайван цагийн дадлага сургууль хамгаас чухал*





*Нээлттэй өдөрлөгийн үеэр 2009 он*



*Шүхэрчин аврагчид*



*Орос Монгол аврагчдын хамтарсан сургалт 2010 он*



*Даргын зөвлөгөө даамай үнэтэй*





*Аврагч гал сөнөөгчид их ажлын дараа*



*Нарантуул худалдааны төвд гарсан галыг унтраалаа 2013 он*



*Хүний амь бүхнээс үнэтэй*



*Цасан шуурганаар Говь-Алтай 2010 он*



*Аврагчид энхийг сахиулах үйлсэд*



*Шүхэрчин аврагчид гарааны шугаманд*



*ОБЕГ-ын бие бүрэлдэхүүн 2012 он*



*Жагсаал чимсэн Онцгой бүсгүйчүүд*



*Эх орондоо тангараг өргөсөн энх цагийн баатрууд*





*Онцгой байдлын албаны 5 жилийн ой*



*Аврагчидад орон сууцны түлхүүр гардуулав 2008 он*



*Нийт бие бүрэлдэхүүн нэгдсэн арга хэмжээний үеэр*



*Гадаад харилцаа хамтын ажиллагаа 2005 он*



*Азийн галын байгууллагын дарга нар 2004 он*






*Баярын хурал 2005 он*



*Нээлттэй өдөрлөг 2009 он*



*ОБЕГ-ын төлөөлөгчид Аляска мужид 2011 он*



*НҮБ, Азийн бэлэн байдлын төв, Монгол улс гамшигтай хамтран тэмцэхээр боллоо 2013 он*



*Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж үерийн аюулаас олон хүний амь нас аварсан аврагчдыг шагнав 2009 он*




*Ерөнхий сайд Н.Алтанхуяг ОБА-ны үйл ажиллагаатай танилцав 2013 он*



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ОДООГИЙН БҮТЭЦ



## ОБЕГ-ЫН БҮТЭЦ



## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Шинэ тутам байгуулагдсан Онцгой байдлын албыг бэхжүүлэхэд үе үеийн Засгийн газраас онцгой анхаарч хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсээр ирсэн байна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төсөв жил бүр нэмэгдэж 2005 онд 13,4 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан бол 2014 онд 83,1 тэрбум төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төсвийн хөрөнгө оруулалт 2005 онд 450.0 сая төгрөг байсан бол 2014 онд 19.6 тэрбум болж 44 дахин нэмэгдсэн байна.

2004-2014 оны хооронд хөрөнгө оруулалтаар Дунд-Говь аймгийн Онцгой байдлын хэлтсийн аврах гал унтраах 25 дугаар ангийн барилга, Өмнө-Говь аймгийн Онцгой байдлын хэлтсийн аврах гал унтраах 24 дүгээр ангийн барилга, Нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр анги, 30 дугаар ангийн барилга, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Аврах гал унтраах 55 дугаар анги, Дорноговь аймгийн Айраг сум дахь Шатахууны нөөцийн салбарын агуулах, Аврах тусгай ангийн аврагчдын 58 айлын орон сууц, Дорноговь аймгийн Замын –Үүд сумын 17 дугаар анги, Айраг сумын аврах гал унтраах 23 дугаар анги, Баянзүрх дүүргийн Гачуурт тосгон дахь аврах гал унтраах 35 дугаар анги, Аврагч спорт хороо, 2011-2012 онд Баянгол дүүргийн аврах гал унтраах 18 дугаар анги, Хан- Уул дүүргийн аврах гал унтраах 65 дугаар анги, Ховд аймгийн Булган суман дахь аврах гал унтраах 38 дугаар анги, Төв аймгийн аврах гал унтраах 24 дүгээр анги, Говь- Алтай аймгийн аврах гал унтраах 59 дүгээр анги, Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь аврах гад унтраах 19 дүгээр анги, Дархан- Уул аймгийн аврах гал унтраах 54 дүгээр анги, Хэнтий аймгийн Бэрх тосгон дахь аврах гал унтраах 49 дүгээр анги, Говьсүмбэр аймгийн аврах гал унтраах 37 дугаар ангиудын барилгыг нийт 26,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бариулж, ашиглалтанд оруулаад байна. 2014 онд Нийслэлийн Багахангай дүүргийн аврах гал унтраах 80 дугаар анги, Завхан аймгийн аврах гал унтраах 43 дугаар ангийн барилгын 3.95 тэрбум төгрөгийг төсвийн хөрөнгө оруулалтаар батлуулж, худалдан авах ажиллагаа зохион байгуулж байна. Олон улсын жишигт нийцүүлэн бие бүрэлдхүүнийг аврах гал унтраах тусгай хувцас, багаж хэрэгслээр хангах зорилтын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар олон улсын стандартад нийцсэн аврах ажлын автомашин, галын үндсэн албаны машин, тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг 32.2 тэрбум төгрөгөөр худалдан авч аврах ажиллагаанд ашиглаж байна.



*Дорноговь аймгийн Замын –Үүд сумын 17 дугаар ангийн барилгыг ашиглалтад хүлээн авав*



*ОБЕГ-ын дарга, дэд дарга нар*



*ОБЕГ-ын удирдлагууд*



*Тамгын газрын хамт олон*



*Бодлого төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын хамт олон*



*Гамшигтай тэмцэх газрын хамт олон*



*Гал түймэртэй тэмцэх газрын хамт олон*





*Улсын нөөцийн газрын хамт олон*



*Санхүү, ар талын газрын хамт олон*



*Албан хаагчид Цэцээ гүний оргилд 2013 он*



*Хангалт үйлчилгээний хэлтсийн ажилтнууд*

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШИНЭЧЛЭЛ

2012 оноос Монгол Улсын Шадар сайдаар Д.Тэрбишдагва, Онцгой байдлын ерөнхий газрын даргаар онцгой байдлын хурандаа Т.Дуламдорж нар ажиллаж байна.

2013-2017 он хүртэл аврах албаны машин техник, тоног төхөөрөмжүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд үе шаттай шинэчлэх юм. Монгол Улсын Засгийн газраас Онцгой байдлын албаны техникийн чадавхийг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд 2013 онд 7.3 тэрбум, өдөр тутмын болон тусгай зориулалтын хувцас хэрэглэлд 5,7 тэрбум батлажээ.

Шинэчлэлийн Засгийн газрын зорилтын хүрээнд тус байгууллага нь бүтэц зохион байгуулалтын болон бүтээн байгуулалтын томоохон ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.



*Шуурхай зарлан мэдээллийн төв 2013 он*

Монгол Улсын Засгийн газрын 11,6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр “Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах төсөл”-ийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын дэргэд Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төв шинээр байгуулагдлаа. Шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвтэй болсноор газар хөдлөлт төдийгүй байгалийн гамшиг, болзошгүй аюулт үзэгдэл ослоос урьтан иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээллийг дуут дохиолол, гар утас, FM радио, телевизээр шууд дамжуулах боломжтой болж байгаа юм.

Япон Улсын Засгийн газар, ЖАЙКА олон улсын байгууллагаас “Улаанбаатар хотын гал унтраах технологи, тоног төхөөрөмжийг сайжруулах” буцалтгүй тусламжийн төслийн хүрээнд нийт 840 сая иен буюу 14.2 тэрбум төгрөгийн өртөгтэй галын 22 автомашиныг Монгол Улсын Засгийн газарт хүлээлгэн өглөө. Монгол орны эрс тэс уур амьсгалд тохируулан Япон Улсад захиалгаар үйлдвэрлэсэн эдгээр галын автомашин Онцгой байдлын салбарын гамшигтай тэмцэх чадавхийг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж нийслэлийн хүрээний аврах, гал унтраах ангиудын автомашин 100 хувь шинэчлэгдлээ.



*Япон улсын буцалтгүй тусламжаар галын 22 автомашин хүлээн авах ёслолын ажиллагаа 2013 он*



*Нийслэлийн хүрээний аврах, гал унтраах ангиудын автомашины шинэчлэл*



*Аврах ажиллагааны катер завь, газар уснаа явагч*

ОХУ, БНХАУ, Япон улсад үйлдвэрлэсэн галын үндсэн албаны автомашин, аврах ажлын бүрэн тоноглолтой автомашин, ковшоос гадна анх удаа газар уснаа явагч, аврах ажиллагааны бүрэн тоноглолтой катер завиар хангагдлаа. Жилийн аль ч улиралд байгаль, цаг агаарын ямар ч нөхцөлд явж үүрэг гүйцэтгэх онцлогтой газар уснаа явагчийг Увс, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар хэлтэс, Нийслэлийн Аврах ангид гардуулав.

Азийн гамшгийн бэлэн байдлын төвтэй хамтран “Гамшгийн менежментийн бүсийн зөвлөлдөх хорооны 10 дугаар хуралдаан”-ыг Монгол Улсад анх удаа зохион байгууллаа. Тус хуралдаанд дэлхийн 19 орон, олон улсын 20 гаруй байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын 130 орчим төлөөлөгч оролцож “Ази, Номхон далайн бүсэд гамшгийн эрсдлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон тогтвортой хөгжлийг орон нутгийн түвшинд уялдуулан төлөвлөх төлөвлөгөөг боловсруулж, санал бодол, туршлагаа солилцон гамшгийн эрсдлийг бууруулахад Азийн гамшгийн бэлэн байдлын төвтэй илүү нягт хамтран ажиллах чиглэлийг тодорхойлсон байна.



*Гамшгийн менежментийн бүсийн зөвлөлдөх хорооны 10 дугаар хуралдаан 2013 он*

Онцгой байдлын албаны үйл ажиллагаа, албан хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд таниулах, иргэдэд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг олгох зорилгоор Онцгой байдлын ерөнхий газар, Монголын үндэсний олон нийтийн телевиз хамтран “Нарны жим” олон ангит уран сайхны кино бүтээх төслийг амжилттай хэрэгжүүлэв.



“Нарны жим” уран сайхны киноны нээлт 2013 он



“Нарны жим” уран сайхны олон ангит кино эфирт цацагдав 2014.06.02

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг иргэдэд олгох, гамшгийн эрсдлийг бууруулах, Онцгой байдлын албаны үйл ажиллагааг сурталчлах зорилгоор Онцгой байдлын ерөнхий газрын дэргэд “Аврагч” студийг шинэчлэн зохион байгуулав.

Шинэчлэн байгуулагдсан тус студид НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Люксембургийн Засгийн газрын санхүүжилтээр Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг сайжруулах нь” төслөөс 27,7 сая төгрөгийн өртөг бүхий техник, тоног төхөөрөмжийг худалдан авч өгч, тус студийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн байна.



“Аврагч” студийн нээлт 2013он



## ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦОМОГ



*Албан хаагчид Төрийн далбааны өдрөөр 2012 он*



*2013 оны дунгийн хурал*





*Бие бүрэлдэхүүн нэгдсэн арга хэмжээний үеэр*





*Тугаа дээдэлж тангараг өргөсөн албан хаагчид*





*ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн төгсөгчид 2013 он*





*ОБЕГ, ХСИС-ийн хамтын ажиллагаа*





*Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва тусгай мэргэжил сургалтын төвд 2012 он*



*Онцгой байдлын албаны удирдах ажилтны цугларалтын үеэр 2014 он*



*“Марш тактик”-ийн тэмцээнд 2-р байр эзлэв 2013 он*





*Япон улсын тусламжаар олгосон галын автомашины цуваа 2013 он*



*Албан хаагчид “Нээлттэй хаалга”-ны үеэр 2011 он*



*Цацраг идэвхит бодис илэрсэн голомтод ажиллаж байгаа нь*



*Галын олон төрөлт тэмцээн*





*Гамигаас хамгаалах команд штабын сургууль Хөвсгөл аймаг 2006 он*





*Төрөл бүрийн аврагчдын хувцас хэрэглэл*





*Гамшгаас хамгаалах удирдах бүрэлдэхүүний сургалт дадлага Дархан-Уул аймаг 2014 он*



*Эрэн хайх, аврах ажиллагааны сургуульд анх удаа нисдэг тэрэг ашиглав Дархан-Уул аймаг 2014 он*



*Сургууль дадлагын үеэр*





*“Миний мэдэх Онцгой байдлын алба” эссе бичлэгийн уралдаан 2011 он*



*Онцгой байдлын албаны залгамж халаа*



*Өвс тэжээлийн цуваа үдэх ажиллагаа 2013 он*



*Дорнод аймаг Халх гол суманд болсон зудын үеэр 2013 он*



Урлагийн их наадам 2014 он





*Урлагийн их наадам 2014 он*





## УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

1990 оноос өмнө БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэд цас, зуд, ган, үер усны аюул, хүн, малын гоц халдварт өвчин, ой, хээрийн түймэртэй тэмцэх үүрэг бүхий олон комисс бие даан ажиллаж байсан бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, гамшиг ослын үед үүрэг гүйцэтгэдэг хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, удирдлагын бүтцийг боловсронгуй болгох зорилгоор гамшгийн



*Өвөлжилтийн бэлтгэл хангах видео хурал 2013 он*

үед ажиллах олон комиссыг нэгтгэж байнгын ажиллагаатай болгох зайлшгүй шаардлага урган гарсан байна. Иймээс БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1990 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 276 дугаар тогтоолоор байгалийн гамшиг, үйлдвэрийн томоохон осол, хүн, малын гоц халдварт өвчин, цацраг идэвхт болон хүчтэй үйлчилгээтэй хорт бодисын аюул нөлөөллөөс хүн ам, улс ардын аж ахуй, байгаль орчныг урьдчилан сэргийлж хамгаалах, хор хөнөөлийг арилгах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Улсын байнгын онцгой комиссыг Сайд нарын зөвлөлийн дэргэд байгуулж, комиссын бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг батлав. Улсын байнгын онцгой комиссын даргаар Сайд нарын зөвлөлийн орлогч дарга, комиссын орлогч даргаар Улсын иргэний хамгалалтын газрын дарга, Батлан хамгаалах яамны орлогч сайд, харин аймаг, хотын Байнгын онцгой комиссын даргаар тухайн аймаг, хотын Ардын депутатын хурлын гүйцэтгэх захиргааны дарга, комиссын Нарийн бичгийн даргаар цэрэг, иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн ахлах офицер байхаар тогтоосон байна.

Сайд нарын зөвлөлийн тогтоолоор заасан албан тушаалын дагуу Улсын байнгын онцгой комиссын анхны даргаар Б.Шаравсамбуу, орлогч даргаар хошууч генерал Г.Махбариад нар ажиллаж байв. Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж яам, тусгай газруудыг /зарим улсын алба бүхий/ цомхотгох, татан буулгах шаардлага зүй ёсоор гарсан зэргийг харгалзан үзэж Засгийн газрын 1990 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Улсын байнгын онцгой комиссын бүрэлдэхүүнийг шинэчилж, урьд гарсан дүрмийг хэвээр мөрдөхөөр үлдээсэн байна. Ажлын эрх ашиг, шаардлагатай нийцүүлэн 1993 оноос Улсын байнгын онцгой комиссын Нарийн бичгийн даргыг газрын орлогчийн зэрэгтэй болгожээ. Комисс нь 1990 оноос Улсын байнгын онцгой комисс, Гамшигтай тэмцэх комисс, 2009 оноос эхлэн Улсын онцгой



комисс хэмээн нэрлэгдэх болсон. Урьд нь Улсын онцгой комиссын даргын үүрэгт ажлыг Сайд нарын зөвлөлийн дарга, орлогч дарга нар хашиж байсан бол өнөөдөр Монгол Улсын Шадар сайд комиссын даргаар ажиллаж байна.

**Улсын онцгой комиссын үе үеийн дарга нар:**

Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Б.Шаравсамбуу 1990 оноос

Д.Дорлигжав УОК-ын дарга

Ч.Пүрэвдорж 1992-1996 он Засгийн газрын шадар сайд

Монгол Улсын Шадар сайд Миеэгомбын Энхболд 2009-2012 он

Монгол Улсын Шадар сайд Дэндэвийн Тэрбишдагва 2012 оноос одоог хүртэл

**Улсын онцгой комиссын орлогч дарга нар:**

Хошууч генерал Галсансанзайн Махбариад 1985.10-1990.9 сар

Хошууч генерал Гомбосүрэнгийн Дамдинсүрэн 1990.9-1996.8 сар

Хошууч генерал Паламын Сүндэв 1996.9-2000.3 сар

Хурандаа Доржхорлоогийн Ренцэнханд 2000.3-9 сар

Хошууч генерал Одхүүгийн Үржин 2000.9-2004.1 сар

Хошууч генерал Дүрэвийн Даш 2004-2007 он

Тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр 2007-2012 он

Хурандаа Тогоочийн Дуламдорж 2012 оноос одоог хүртэл

**Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга нар:**

Хурандаа Ямааранзын Лхавга 1993-1995 он

Хурандаа Пүрэвийн Дамдин 1996-2000 он

Хурандаа Жамсранжавын Чүлтэмсүрэн 2000.4-10 сар

Хурандаа Чимэддоржийн Тогоо 2000-2004 он

Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Ч.Багчулуун 2009-2009.9 сар

Хурандаа Мангалсүрэнгийн Энх-Амар 2009 оноос одоог хүртэл ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 183 дугаар тогтоолоор Улсын онцгой комисс нь татан буугдаж 2005-2008 онуудад улс орны хэмжээнд тохиолдсон томоохон гамшиг, осол сүйрлийн үед ажлын хэсэг, комиссыг түр томилон ажиллуулж байсан нь үүссэн асуудлыг бүрэн төгс шийдвэрлэлгүй хугацаа алдах, ажил удаашруулах, гамшгийн үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд янз бүрээр мэдээлэгддэг, зарцуулсан хөрөнгө болон хариуцлага хүлээх албан тушаалтан нь тодорхой бус, гамшгийн үед хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг байхгүй зэрэг илэрхий дутагдал ажиглагдаж байв. Иймд Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолоор “Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т /Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохицуулах, шуурхай зохион байгуулах үүрэгтэй комисс ажиллуулж болно. Комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална/ гэж заасний дагуу шинэчлэн батлан 2009 оноос эхлэн Улсын онцгой комиссын даргаар Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Улсын онцгой комиссын орлогч даргаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн даргаар хошууч М.Энх-Амар нар ажилласан. Өдгөө Улсын онцгой комиссын даргаар Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Улсын онцгой комиссын орлогч даргаар Онцгой байдлын ерөнхий газрын дарга, онцгой байдлын хурандаа Т.Дуламдорж, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн даргаар онцгой байдлын хурандаа М.Энх-Амар нар ажиллаж байна.

Улсын онцгой комисс нь тусдаа тамга тэмдэг, Улсын онцгой комиссын даргын тушаал, тогтоол, албан даалгавар, хурлын тэмдэглэл, албан бичгийн бланктай. Комиссын ажлын албаны үүргийг Онцгой байдлын ерөнхий газар гүйцэтгэж комиссын өдөр тутмын ажлыг орон тооны Нарийн бичгийн дарга эрхэлдэг. Улсын онцгой комисс нь хууль тогтоомж, журамд заасан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон

асуудлыг хэлэлцэж эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн хэлбэр үл харгалзан дагаж мөрддөг.

Улсын онцгой комиссоос Засгийн газарт оруулж шийдвэрлэсэн асуудлыг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор 2010 онд “Улсын онцгой комиссын ажиллах журам”-д холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулж Засгийн газрын 2010 оны 284 дүгээр тогтоолоор батлуулснаар гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал, тоног төхөөрөмж гаргах, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаархи асуудлаар зөвхөн Сангийн яам, Хууль зүй яамны саналыг нэн даруй авч Засгийн газарт



*Улсын Онцгой комиссын хуралдаан 2014 он*

оруулж шийдвэрлүүлдэг. Засгийн газрын хуралдаанаар шийдвэр гармагц түүнийг тухайн өдөрт нь багтаан албажуулж Сангийн яаманд хүргэх ажлыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар зохион байгуулж, шийдвэрлэсэн хөрөнгийг Сангийн яам ажлын 24 цагийн дотор багтаан холбогдох байгууллагад багтаан олгох арга хэмжээг авна гэж тусгасан нь Улсын онцгой комиссын ажлыг шуурхай явуулах үндсэн эрх зүйн баримт болсон. 2009-2014 оны 5 дугаар сарын байдлаар Улсын онцгой комисс нь гамшигтай холбоотой асуудлаар нийт 80 удаа хуралдаж Улсын онцгой комиссын Албан даалгавар 18, Тогтоол 13, Улсын онцгой комиссын даргын тушаал, шийдвэрийг 74 удаа гаргуулж Засгийн газрын нөөц сангаас 61,0 тэрбум төгрөгийн хөрөнгийг гаргуулан гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд зарцуулаад байна.

Монгол орны хэмжээнд ган, зуд, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, техникийн холбогдолтой осол, тэсэрч дэлбэрэх бодисын хор хөнөөл, үер, усны аюул зэрэг гамшиг түгээмэл тохиолдож байна. Улсын онцгой комисс нь Засгийн газрын тогтоолоор баталсан Гамшгаас хамгаалах улсын албадыг уялдуулан зохицуулахаас гадна аймаг, нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, үүрэг, чиглэл өгөн удирдлагаар ханган уялдуулан зохицуулж ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдааны 65 дугаар тэмдэглэлд аймаг, нийслэлийн Засаг дарга нар харьяа нутаг дэвсгэртээ учирч болзошгүй гамшгийн хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор



*Улсын Онцгой комиссын орлогч, ОБЕГ-ын дарга  
Онцгой байдлын хурандаа Т.Дуламдорж,  
Улсын Онцгой комиссын ажлын албанхны хамт*

аймгийн онцлогоос хамааран тодорхой хэмжээний хөрөнгийг тухайн жилийн төсөвтөө тусган батлуулж байх, батлагдсан хөрөнгийг хуулийн дагуу зарцуулан тухай бүр Улсын онцгой комисст тайлагнаж байхыг даалгасан.

Үүнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 58.2.12 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6, 7 дахь заалтын дагуу орон нутаг гамшгийн хор хохирлыг арилгахдаа эхний шатанд Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах, хэрэв гамшгийн хохирлыг барагдуулахад гарах зардал нь Засаг даргын нөөц хөрөнгөөс хэтэрсэн үед Засгийн газрын нөөц сангаас нэмэлт санхүүжилт авах хүсэлтээ Улсын онцгой комисст ирүүлэхээр шийдвэрлэснээс хойш орон нутгийн удирдлагууд гамшгийн аюулаас өөрсдийгөө хамгаалах чадвар нь эрс нэмэгдээд байна. Энэ хүрээнд 2012 оноос эхлэн аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц санд жил бүр дунджаар 11,6 тэрбум төгрөгийн хөрөнгийг гамшгийн хохирлыг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд зарцуулахаар хуваарилан Улсын онцгой комисс хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

Улсын байнгын онцгой комисс хэмээх их айлын тулгын чулууг Г.Махбариад генерал тавилцаж, Г.Дамдинсүрэн, П.Сүндэв

генерал нар Улсын байнгын онцгой комиссыг хөл дээр нь босгож, материаллаг баазыг бэхжүүлэх талаар ихээхэн зүйлийг хийсэн. О.Үржин генералын үед Улсын иргэний хамгаалалтын газрын үүрэг, бүтэц, зохион байгуулалт үндсээрээ өөрчлөгдөж нэгэн шинэ үеийн түүхэн эхлэл болж, сайд У.Хүрэлсүх, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга М.Энхболд, Д.Тэрбишдагва нар Улсын Онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын шинэ бүтцийг бий болгон олон улсын хэмжээнд хүргэж улс орны гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг улс орны хэмжээнд амжилттай удирдан нэр төртэй үргэлжлүүлж байна.

## УЛСЫН НӨӨЦИЙН УЛААНБААТАР ХОТ ДАХЬ САЛБАРУУД

### “Объект 03”

Тус салбар нь үндсэн үйлдвэрийн томоохон осол, байгалийн гамшиг болон болзошгүй гэнэтийн аюул, эдийн засгийн бэрхшээл, хүндрэл тохиолдсон үед зарцуулагдах үнэт зүйлсийг улсаас тогтоосон нэр, төрөл, тоо хэмжээнд нь гамшгийн бэлэн байдалд байлгах юм. Анх 1972 онд Гурил, тэжээлийн нэгдлийн харьяанд Аюулаас хамгаалах тэжээлийн нөөцийн нэгдсэн төв нэртэйгээр 10 гаруй ажилчинтайгаар байгуулагдаж байжээ.



### Хүнсний нөөцийн салбар



Тус салбар нь 2000.06.01-нд байгуулагдсан. Хүнсний нөөцийн барааг зохих нэр, төрөл, тоо хэмжээгээр нь хугацаанд нь бүрдүүлэн байршил технологийн дагуу хадгалах, хамгаалах, сэлгэн шинэчлэх, нөхөн бүрдүүлэх, байгалын гамшгийн үед зайлшгүй шаардлагатай бараа, материалыг ханган нийлүүлдэг. Мөн гадаад орнуудаас нийлүүлж байгаа тусламжийн барааг хүлээн авах, хадгалах ажлыг зохион байгуулахаас гадна Монгол Улсын Засгийн газраас гадаад орнуудад үзүүлж буй тусламжийн барааг цаг хугацаанд нь хүргэх ажлыг зохион байгуулах үндсэн үүрэгтэй.

Хүнсний нөөцийн салбарын даргаар 2000-2008 онд Онцгой байдлын хошууч Р. Даваажав, 2008-2014 онд Онцгой байдлын дэд хурандаа А.Оюунчимэг нар ажиллаж байв.

### Шатахууны салбар

Тус салбар нь нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, онцгой байдлын үед “Улсын нөөцийн тухай” хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу хэрэглэгдэх шатах тослох материалыг бүрдүүлэх, хадгалах, сэлгэн шинэчлэх, зарцуулах үндсэн үүрэгтэй.



### Улсын нөөцийн агуулах

Улсын нөөцөд шилжин ирсэн өвс, тэжээл, шатахуун, үрийн буудай, хүнсний бараа, материал, үйлдвэр-техникийн бараа, материал хадгалах агуулахууд нь 1962-1990 онд ашиглалтанд орсон, хүйтэн, насжилт өндөртэй, урсгал болон их засвар хийгдээгүй, техник тоног төхөөрөмж нь хуучирч муудсан, сүүлийн үеийн техник технологи нэвтрүүлэхэд тохиромжгүй, бараа, материал хадгалах стандартын шаардлага хангахгүй байгаа нь хадгалж байгаа барааны чанар, хадгалалт хамгаалалтанд сөргөөр нөлөөлөх болсон байна. Нөөцийн бараа, материал хадгалах агуулах, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгоор агуулахын ашиглалтын байдалд судалгаа хийж, засварлахад шаардагдах хөрөнгийн тооцоог гарган жил бүрийн улсын төсөвт хөрөнгийн асуудлыг тусгуулан ажиллаж байна.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫ АВТОБААЗ

Онцгой байдлын ерөнхий газрын Хангалт, үйлчилгээний анги нь анх 2004 онд Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор байгуулагдсан бөгөөд тус анги нь санхүүгийн, хангалт үйлчилгээний, техникийн гэсэн 3



*Авто баазын нээлтийн ёслолын ажиллагаа 2010 он*

албатай, орон тоогоор 58 албан хаагчтай байгуулагдан одоогийн Автобааз үүсэн байгуулагдах үндэс суурийг тавьсан юм.

Автобааз нь Монгол Улсын Шадар сайдын 2008 оны 56 дугаар тушаалаар болзошгүй гэнэтийн гамшиг, байгалийн бэрхшээл, аюул осол тохиолдсон үед авран хамгаалах, урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд Онцгой байдлын албаны техник, хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг бүрэн ханган ажиллах зорилготойгоор ОБЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон байгуулагдсан ба Санхүү ар талын газрын даргын удирдлаганд ажиллаж эхэлснээс хойш 5 дахь жилдээ төрийн өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж иржээ. Энэ хугацаанд Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогод нийцүүлэн “Онцгой байдлын албаны техник шинэчлэлийн дунд хугацааны (2012-2015) дэд хөтөлбөр”-ийг боловсруулан ОБЕГ-ын даргын 2012 оны 576 дугаар тушаалаар батлуулан мөрдлөг болгон ажиллаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Онцгой байдлын албаны хэмжээнд 132 нэгж техникийн хангалтыг хийж, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн нийт 118 нэгж техникт агергатын их засвар, 440 нэгж техникт ашиглалтын засварын ажил үйлчилгээг хийж, техникийн болон албаны бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан байна. Улсын нөөцийн болон олон улсын байгууллага ард иргэдээс ирүүлсэн 1,5 тн/км хандив тусламжийн бараа материалыг цаг агаар хүндэрсэн 21 аймагт тээвэрлэн хүргэжээ.

Автобааз нь штабын бие бүрэлдэхүүн, техник ашиглалтын алба, санхүү, хангалт үйлчилгээний алба гэсэн үндсэн алба бүхий бүтэцтэйгээр 85 төрийн тусгай, 38 төрийн үйлчилгээний нийт 123 албан хаагч Онцгой байдлын албаны 590 нэгж техникийн засвар үйлчилгээг хийн сэлбэг хэрэгслээр ханган ажиллахаас гадна, 98 нэгж техник, хэрэгслийг хариуцан ажил үүргээ гүйцэтгэж, Онцгой байдлын ерөнхий газрын газар, хэлтсүүдэд 22 нэгж шуурхай ажлын автомашинаар үйлчилэн, техникийн шуурхай бэлэн байдлыг ханган ажиллаж,

иргэдийг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох хуулиар хүлээсэн хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ нэр төртэйгөөр биелүүлж, эрхэлсэн ажилдаа оюун ухаан, ур чадвар, сэтгэл зүтгэлээ зориулан ажиллаж, Онцгой байдлын албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх, чадавхийг дээшлүүлж техник зэвсэглэмжийн хангалтыг сайжруулах зорилт тавин ажиллаж байна.



*Албаны бэлтгэл бэлэн байдал, шуурхай тусламж*





## ГАМШИГ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН



Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 8 дугаар захирамжаар дээрх нэгжүүдийг нэгтгэн Гамшгаас хамгаалах ерөнхий газрын бүтцэд Гамшгийн судалгааны төвийг /2 сектортой/ байгуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 4-р сарын 30-ны өдрийн 156 тоот тогтоолоор одоогийн Гамшиг судлалын хүрээлэнг байгуулсан бөгөөд 2008 оны 6-р сарын 16-нд БСШУЯ-наас Улсын бүртгэлийн гэрчилгээ авснаар тус хүрээлэн нь төрийн өмчийн 35 дахь эрдэм шинжилгээний хүрээлэн болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоолоор тус хүрээлэнг Хууль сахиулахын их сургуулийн бүтцэд нэгтгээд байна. Хүрээлэн нь Гамшиг судлалын төв, Нэгдсэн лаборатори гэсэн 2 үндсэн нэгжтэй. Өнөөгийн байдлаар тус хүрээлэнгийн судалгаа,

шинжилгээний ажил эрхэлдэг бүрэлдэхүүний 25 хувь нь эрдмийн зэрэг цолтой, 68 хувь нь магистр, 7 хувь нь бакалаврын боловсролтой байна. Үүнээс 3 судлаач докторантурт сурч байна. Төрийн тусгай албан хаагч 17, Төрийн үйлчилгээний албан хаагч 1, Бүгд 18 хүний орон тоотой ажиллаж байна.

Тус хүрээлэн нь улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн гамшгаас хамгаалах онолыг хөгжүүлж, Онцгой байдлын байгууллагын тулгамдсан асуудал болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаа болох гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний талаар эрдэм шинжилгээ, судалгаа, лабораторийн туршилтын үр дүнгээр зөвлөмж боловсруулан шийдвэр гаргагчид болон иргэдийг хангахад оршино. Гамшиг судлалын хүрээлэн нь үйл ажиллагаандаа Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Улсын нөөцийн тухай хууль, Шинжлэх ухаан технологийн тухай болон бусад хууль, тогтоомжийг мөрдөж, гамшгаас урьдчилан сэргийлэх өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болох аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослыг үнэлэх болон олон улсын хэмжээнд итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулж, Монгол Улсын засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, гамшгаас хамгаалах улсын албад, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.

### Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр: 2010-2011 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлэх арга технологийн судалгаа, 2011-2012 онд Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа, 2012-2014 онд Хиймэл дагуулын мэдээг ашиглан Монгол Улсын хэмжээнд байгалийн гамшгийн эрсдэлтэй газруудыг тодорхойлох судалгаа

### Онцгой байдлын байгууллагын захиалгаар:

Монгол Улсын гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн ерөнхий үнэлгээ, Монгол оронд сүүлийн 15 жилд гарсан байгалийн гамшгийн судалгаа, мэдээллийн сан, Орон нутаг дахь Онцгой байдлын газар хэлтсүүдийн гал унтраах ангиудын техник, зэвсэглэмжийн бэлтгэл бэлэн байдлын судалгаа, Гал түймэр гарч буй нөхцөл,

шалтгаан түүнээс урьдчилан сэргийлэх арга замууд, Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцооны өнөөгийн байдал, хүртээмжийн судалгаа, Монгол орны байгалийн гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн судалгаа, Нийслэлийн эрсдэлийн бүсийг тодорхойлж шаардлагатай газруудад эрсдэлийн микро зураглал гаргах судалгаа, Гамшгийн эрсдэлийн ангилал, түвшин зэрэглэл тогтоох аргачлал боловсруулах судалгаа, Улаанбаатар хот дахь Улсын нөөцийн хүнсний агуулахын бараа, материалын чанар байдал, хадгалалтын судалгаа, Улаанбаатар хотын цацрагийн зураглал, цацрагийн ослын үеийн шуурхай арга хэмжээ, Нийслэлийн хэмжээнд химийн хорт бодис ашигладаг Аж ахуйн нэгж байгууллагуудын судалгаа, Гамшгийн хохирлыг үнэлэх ерөнхий арга зүйг боловсруулах судалгааг тус тус хийжээ.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний талаар:

Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам, Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 176 дугаар тогтоолоор



*Хүрээлэнгийн бие бүрэлдэхүүн*

батлуулсан байна. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж ОБЕГ-ын даргын 2009 оны 378 дугаар тушаалаар, мөн Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах тухай асуудлыг 2009 оны 377 дугаар тушаалаар тус тус албажуулжээ. Гамшгийн эрсдэлийн үнэлгээтэй холбоотой асуудлаар 60 шахам байгууллага, аж ахуйн нэгжид зөвлөгөө өгч, үүний 20 гаруй хувьд нь гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийв. Гамшгийн хохирлыг үнэлэх ерөнхий арга зүйг газар хөдлөлт, үер, химийн осол, зуд гэсэн гамшгийн төрлүүдээр болон гамшгийн хохирлын үнэлгээнд геомэдээллийг хэрэглэх гэсэн чиглэлүүдээр боловсруулжээ.

“Монгол Улсын стратегийн эрсдэлийн судалгаа” төслийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрлүүдээр эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийсэн. “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлэх арга технологийн судалгаа” төслийн хүрээнд Нийслэлийн бүх дүүргүүдийн гал, түймэр, газар хөдлөлт, үер, цацрагийн болон химийн ослын, гоц халдварт өвчний гэсэн гамшгийн төрлүүдээр эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийжээ.

## АЛБАА МАНДУУЛСАН “АВРАГЧ” СПОРТ ХОРОО



Монгол Улсын Шадар сайдын 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 08 тоот тушаалаар ОБЕГ-ын “Аврагч” биеийн тамир спортын хороо байгуулагдаж, 2011 оны 10-р сарын 21-ний өдөр тус хороо спортын ордонтой болсоноор үйл ажиллагаагаа эхлүүлжээ.

Монгол Улсын Засгийн газар ОБЕГ-аас болзошгүй гамшгийн аюулаас ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг авран хамгаалах үүрэг хүлээдэг албан хаагчдынхаа бие бялдрыг чийрэгжүүлэх, бэлтгэл, бэлэн байдал, мэргэжлийн ур чадвар, ажлын чадавхийг нэмэгдүүлэх, тамирчдынхаа амжилтыг ахиулахад хүрэх нэг алхам нь

Онцгой байдлын биеийн тамир, спортын салбар нэгж байгуулсан явдал юм.

“Аврагч” биеийн тамир спортын хороо нь оффис, чийрэгжилтийн танхим, 1843.8 м<sup>2</sup> ам дөрвөлжин талбай бүхий 256 хүний суудалтай улс бүс болон олон улсын тэмцээн зохион байгуулах боломжтой спортын ордон юм. Тус биеийн тамир, спорт цогцолбор нь байгуулагдсанаас хойш Онцгой байдлын бие бүрэлдэхүүний хэмжээнд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, бие бялдар, хурд хүч, тэсвэр хатуужлыг дээшлүүлэх албаны бэлтгэл бэлэн байдлыг хангах албаны спортыг хөгжүүлэх талаар багагүй ажлыг зохион байгуулжээ.

“Аврагч” биеийн тамир, спорт хорооны тамирчдын бэлтгэл сургуулилт тогтмолжиж, тив дэлхий, олон улсын тэмцээнүүдэд үзүүлэх амжилт дээшилж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит Хүн амын бие бялдар хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын хүрээнд нийтийн биеийн тамир спорт, мэргэжлийн спортыг хөгжүүлэх, албан хаагчдынхаа бие бялдрыг чийрэгжүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг ханган ажиллах боломж бүрдэв.

2012 онд Монголын бүх ард түмний спортын XIII их наадам 23 төрлөөр зохион байгуулагдсанаас “Аврагч” биеийн тамир, спорт хорооны 235 тамирчин, 14 дасгалжуулагч оролцож Алтан медаль 17, Мөнгөн медаль 21, Хүрэл медаль 18-ыг хүртэж 120 оноогоор багийн дүнгээр 3 дугаар байранд шалгарав. Хүндийн өргөлт, байт харваа, талбайн теннис, самбо, жудо, чөлөөт, кураш бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 50 гаруй медаль, улсын хэмжээнд зохиогдсон тэмцээнээс 260 гаруй медаль хүртжээ. БНСУ-ын Жинжү хотод болсон Гал унтраах техникийн олон төрөлт спортын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож довтолгооны шат болон байлдааны тархалтын төрөлд Монгол Улсын рекорд амжилтыг шинэчлэн тогтоож 7 тамирчин ОУХМ болзлыг ханган биелүүлж багийн дүнгээр 7-р байр эзэлсэн байна.

“Аврагч” биеийн тамир спорт хороо байгуулагдсанаас хойш тамирчдын амжилт тогтмол өсч сүүлийн 2 жилд ОУХМ 27, Спортын мастер 42, дэд мастер 76 төрөн гарсны зэрэгцээ тус албанаас спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдэж мэргэжлийн ур чадвар, аврагчдын бие бялдрын түвшин дээшилсэн байна. “Аврагч” спорт хорооны анхны даргаар хурандаа Пүрэв-Очир, Онцгой байдлын хурандаа Д.Сүхбат нар ажиллаж байсан бол өдгөө Монгол Улсын заан, гавьяат тамирчин Ц.Баярсайхан ажиллаж байна. Дэд даргаар Олон улсын хэмжээний мастер, Онцгой байдлын дэд хурандаа Д.Дэлгэрмаа, ахлах дасгалжуулагчаар спортын мастер, Онцгой байдлын хурандаа А.Батмөнх, дасгалжуулагч багшаар Аймгийн арслан, спортын мастер, Онцгой байдлын дэд хурандаа Ц.Шийрэв нар ажиллаж байна.



*“Аврагч” спорт хорооны хамт олон*



*“Аврагч” спорт хорооны тамирчид 2009 он*



## Онцгой байдлын дэд хурандаа Ц.ШИЙРЭВ: ЖУДО БӨХ ИХ САЙХАН СПОРТ

*Анх спорт хороо байгуулж байсан түүхээсээ хуучлаач. Он жил өнгөрөөд бас түүх болсон байна шүү...*

Анх “Аврагч” нэртэй спорт клубыг байгуулах шийдвэр гарч даргаар Пүрэв-Очир, намайг дасгалжуулагчаар томилж “Аврах” тусгай анги дээр байгуулагдаж байсан үе саяхан мэт санагдаж байна. Тэр үед үндсэн тамирчин цөөхөн байлаа. Анхны тамирчид гэвэл сумогийн дэлхийн 2 удаагийн аварга олимпын бус их наадмын дэлхийн гурван удаагийн аварга Бямбажав, аймгийн арслан, жүдогийн насанд хүрэгчдийн улсын аваргын мөнгө, хүрэл медальтай Давааням Японд жүдогоор 7-8 жил суралцаад дөнгөж ирж байсан, самбо барилдааны залуучуудын дэлхийн аварга, Азийн аварга, жудо бөхийн Гранпри тэмцээний мөнгө, хүрэл медалтай Бат-эрдэнэ нар анхны албан ёсны тамирчид болж байлаа. Тэр жилээсээ эхлээд багаараа өсвөрийн залуучуудын улсын аваргад түрүүлсэн. Тамирчин Д.Төмөрхүлэг 17 насандаа бүх ард түмний спартакиадын 62 кг жинд түрүүлээд манай албан ёсны тамирчин болж байсан. Тэр жилдээ 2008 оны дэлхийн жудо бөхийн залуучуудын аваргаас залуучуудын анхны мөнгөн медаль авсан юм. Тэмүүлэн бас энэ тэмцээнээс анхны хүрэл медаль авч байлаа. Монголын тамирчдын авсан анхны медалиуд учир үүгээрээ би их бахархдаг. Мөн Бямбажав маань сумо бөхийн дэлхийн аварга болсон юм. Тэр жил жудо, сумо, самбоор дэлхийн аварга болон тивийн аваргад өндөр амжилт гаргасан гээд намайг дэд хурандаа цолоор шагнаж байлаа. Үүнээс хойш манай тамирчид олон медаль авчээ. 2010 онд миний 8 шавь жүдогоор алтан медаль авч байсан нь миний хамгийн дурсгалтай сайхан үе юм.

***Та олон сайн шавь төрүүлжээ. Дасгалжуулагч багшийн хөдөлмөр гэж юуг хэлэх вэ? Та шавь нараа юунд голлон сургахад анхаардаг вэ?***

Ер нь юм сайн ойлгодог толгой сайтай хүн л сайн барилдаж амжилт гаргадаг юм байна лээ. Монгол хүнд бөхийн спортын төрөлхийн авъяас байдаг нь давуу тал юм. Хүнийг амжилт гаргатал хөдөлмөрлөхөд багш хүн хамгийн гол нь сэтгэл зүрхээ бүрэн зориулна гэсэн үг. Дасгалжуулагч багшаас сайн сэтгэл зүйч, бариа засалч, зурхайч гээд олон чадвар шаарддаг. Би нэг ч удаа бэлтгэл тасалж үзээгүй. Багш шавь хоёулаа сэтгэлээ гаргаж хөдөлмөрлөж байж амжилт гаргана. Түүнээс гоц авъяастай хүүхэд авчираад амжилт гаргаж байгаа хэрэг биш юм. Бөхөд барьц гэж нэг айтгар юм байдаг. Үндэсний бөхөд гэхэд аварга арслангууд өөр өөрийн үндсэн барьцтай байдаг. Барьц гэдгийг тусгайлан судлах хэрэгтэй гэж би боддог. Нэг барьц авчихвал тэрийг нь ямар ч бөх тавиулж чаддаггүй. Барьц гэж үүнийг хэлээд байгаа юм. Ямар ч хүнд дархан мэх гэдэг нэг юм байна. Ер нь бөх хүн сурсан ганц дархан мэхээ хийгээд насаараа ч барилддаг. Тэр дархан мэхний эсрэг ямар мэх хийх вэ гээд толгойгоо ажиллуулж бодно. Үүн дээр их анхаарч шавь нараа хөгжүүлж байна. Өрөөсгөл барьцтай биш баруун зүүн аль ч талдаа тэнцүү байхаар хөгжүүлдэг. Бэлтгэлийн үед хүүхдийн ачааллыг зөв хуваарилна. Анхлаад ирж байгаа хүүхдүүдийг хамаагүй бахардтал гүйлгэж шантрааж болохгүй. Сонирхолыг нь төрүүлж хөгжүүлэх тал дээр нэлээд анхаарна. Хүүхдийн 5 дахь мэдэрхүйг зургаа болгох, бүр чадвал долоо болговол аугаа биз дээ. Тэгж хөгжүүлээд ирэхээр шавь нар минь өөрсдөө амжилт гаргаад ирж байгаа юм. Жудо бол их сайхан спорт шүү. Спорт хороо гэдэг сайн тамирчдынхаа нэр алдраар явдаг. Олон мянган аврагчдыг эгнээндээ багтаасан Онцгой байдлын албаны нэрийг өргөж яваадаа би бахархалтай байдаг.

## ГАЛ УНТРААХ ТЕХНИКИЙН ОЛОН ТӨРӨЛТ СПОРТ



Манай улсад 1956 оноос эхлэн гал сөнөөгчдийн гал унтраах ур чадвар, дадлагыг дээшлүүлэх, гал унтраах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор уралдаан тэмцээн зохион байгуулж ирсэн нь гал унтраах техникийн төрөлт спорт үүсэж хөгжихийн эхлэл болсон гэж үздэг. Монголын Биеийн тамир спортын төв зөвлөлийн тэргүүлэгчдийн 1971 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн тогтоолоор гал унтраах техникийн олон төрөлт спортыг БНМАУ-ын /хуучин нэрээр/ спортын нэгдсэн ангилалд оруулж, тамирчдад олгох спортын цол, зэргийн нормыг батласан юм.

Үүнээс хойш манай баг тамирчид хуучин социалист орнуудын Галын байгууллагуудын баг тамирчдын дунд зохион байгуулдаг олон улсын тэмцээнд анх 1973 онд Болгар улсад зохион байгуулагдахад оролцсон бөгөөд түүнээс хойш 1986 он хүртэл тасралтгүй оролцсон. Энэ тэмцээн 2 жил тутам зохион байгуулагддаг байсан бөгөөд манай баг тамирчид Болгар-1973, Герман-1975, Чехословак-1977, Сочи-1979, Унгар-1981, Минск-1984, Польш-1986 тэмцээнд оролцож байсан. ЗСБНХУ-ын Сочи хотод 1979 онд болсон Өсвөрийн гал сөнөөгчдийн олон улсын III тэмцээнд манай улс анх удаа өсвөрийн гал сөнөөгчдийн баг тамирчид бэлтгэн оролцож 3-р байр эзлэж байсан билээ. Мөн тухайн онд зохион байгуулагдсан насанд хүргэгчдийн олон улсын тэмцээний 4x100 м-ийн буухиа уралдааны 4-н замд Монгол улсын Үйлчилгээний гавьяат ажилтан гал унтраах техникийн олон төрөлт спортын олон улсын хэмжээний мастер Т.Отгон 3 секундэд багтаан тэвшний галыг унтрааж тусгай шагнал авч байсан.

ОХУ-ын Москва хотод 2002 онд зохион байгуулагдсан анхны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд манай баг тамирчид оролцсон бөгөөд ОХУ-ын Владивосток хотод 2003 онд болсон Азийн аварга шалгаруулах IX тэмцээнд манай баг тамирчид оролцон 4x100 метрийн буухиа тэмцээнд 3 дугаар байр эзлэн хүрэл медаль авсан бөгөөд улсын рекорд амжилтыг уг төрөлд тогтоосон юм. Манай баг тамирчид Беларусь улсын Минск хотод 2004 онд Дэлхийн аварга шалгаруулах II тэмцээн, 2010 онд Солонгос улсын Дэгү хотод Дэлхийн гал сөнөөгчдийн XI удаагийн тоглолт, 2012 онд Турк Улсын Анталья хотод Дэлхийн аварга шалгаруулах YIII удаагийн тэмцээнд ажиглагчаар, 2013 онд Солонгос улсын Жинжү хотод Дэлхийн аварга шалгаруулах IX удаагийн тэмцээнд тус тус оролцсон бөгөөд 2013 оны Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд спортын мастер Э.Энхбат довтолгооны шатны төрөлд 13.92 сек амжилт үзүүлэн улсын дээд амжилтын шинэчлэн, мэргэ онох тархалтын тэмцээний төрөлд 32.91 сек амжилтаар улсын дээд амжилтыг тус тус шинэчлэн тогтоож ирсэн баялаг түүхтэй билээ.

Гал сөнөөгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, дадлага чадвар олгох зорилгоор манай улсын баг тамирчид 1992-2000 онуудад ОХУ-ын Иркутск, Красноярск, Улан-Удэ, Чита, Ангарск хотод зохион байгуулагдсан олон улсын нээлттэй тэмцээнд тогтмол оролцож ирсэн билээ. Манай улс бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 1971 оноос 2 жил тутамд 1 удаа, улсын аварга шалгаруулах тэмцээнийг 1984 оноос эхлэн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд шалгарсан баг тамирчдын дунд зохион байгуулж ирсэн түүхтэй. Энэ уламжлал тасраагүй өнөөг хүртэл үргэлжилж байна. Галын аюулаас хамгаалах газрын дарга агсан хурандаа Ж.Жанчив гуайн санаачлагаар 1983-1984 оны хооронд өөрсдийн дотоод нөөц бололцоо, бие бүрэлдэхүүнийхээ хүчийг дайчлан улсаас нэг ч төгрөгийн төсөв зардал гаргалгүй Баянхошуунд спорт сургалтын төвийг хорт хий, утааны камер, усан бассейн, шүхэрчин гал сөнөөгч, гал сөнөөгчдийн сэтгэл зүйн полигоны хамт иж бүрнээр нь байгуулсан бөгөөд одоог хүртэл ашиглаж байна.

Онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүн энэхүү спортоор хичээллэж спортын өндөр амжилт гарган олон улсын хэмжээний мастер 6, спортын мастер 102, дэд мастер 136, I, II, III зэргийн тамирчид 800 гаруй

төрөн гарсан байдаг.



*Гал унтраах техникийн олон төрөлт спортын тэмцээн 2013 он*



## ХУУЛЬ САХИУЛАХ ИХ СУРГУУЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН СУРГУУЛЬ



*Онцгой байдлын сургуулийн бие бүрэлдэхүүн*

Онцгой байдлын сургуулийн анхны суурь 1990 онд НАХЯ-ны Цагдаагийн дээд сургуулийн бүтцэд мэргэжлийн гал сөнөөгч бэлтгэх дамжаа байгуулагдсанаар тавигдсан. 2012 онд Шадар сайд, Хууль зүй Дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн дэргэд Онцгой байдлын сургуулийг байгуулснаар үйл ажиллагаа нь өргөжин ажиллаж эхэлсэн. 2010 оноос БСШУ-ны сайдын 19/А/39 тоот тушаалаар 4 жилийн сургалттай бакалаврын боловсролын зэрэгтэй Онцгой байдлын байгууллагын ажил-эрх

зүй чиглэлээр өдрийн анги байгуулагдан сургалтаа явуулж байна.

Үүнээс гадна 2012 оноос захиалагч байгууллагын хүсэлтээр ахлагчийн сургуульд 185 ахлагч, 25 офицер бэлтгэн төгсгөжээ. 2013-2014 оны хичээлийн жилийн магистрын шатны сургалтыг БСШУ-наас зөвшөөрөл авч эхлүүлэн 24 магистрант элсүүлэн суралцуулж байгаагаас гадна ахлагчийн сургуульд бакалавр боловсролоор 69 сонсогч, аврагч гал сөнөөгч мэргэжлээр 30 сонсогч бэлтгэж байна. 2013-2014 оны хичээлийн жилд нэгдүгээр дамжаанд 49 сонсогч, хоёрдугаар дамжаанд 28 сонсогч, гуравдугаар дамжаанд 31 сонсогч, дөрөвдүгээр дамжаанд 25 сонсогч, Ахлагчийн сургуульд 99 сонсогч нийтдээ 232 сонсогч өнөөдрийн Онцгой байдлын албаны шинэ боловсон хүчин болохоор суралцаж байгаа юм.



*Онцгой байдлын сургуулийн сонсогчид 2014 он*





ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн захирал, хурандаа П.БАТТОГТОХ:

## ИХ ХҮМҮҮСИЙН ДУНД...

Мэдээлэлжүүлэлтийн олон улсын академийн академич, Цэргийн шинжлэх ухааны доктор, профессор, ГХЕГазрын тамгын газрын дарга, ОБЕГ-ын ТЗУГ-ын даргаар ажиллаж байсан, ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн захирал, хурандаа П.Баттогтохтой ярилцлаа.

***Онцгой байдлын албаны 10 жилийн ойг тохиолдуулан офицерийн хувьд олон сайхан дурсамжтай байдаг байх. Та тэр сайхан дурсамжаасаа хуваалцахгүй юу?***

2004 онд Дэлхий нийтийн нийтлэг жишгээр Онцгой байдлын албыг шинээр байгуулагдахад нь ГХЕГ-ын анхны Тамгын газрын даргаар томилогдон ажилласнаас хойш энэ албанд нэг мэдэхэд 10 жил хурдан өнгөрчээ. Хамгийн эх оронч хүмүүс бол хилчид юм байна гэж би боддог байсан. Шинэ албанд томилогдоод хилчид шиг бас тангараг өргөсөн ард иргэдээ гамшиг ослоос авран хамгаалах үүрэг хүлээсэн олон арван шилдэг залуус болох аврагчид, гал сөнөөгчидтэй хамтран 10 жил ажиллах хугацаанд тэднээс их зүйл сурч, бас тэднээр бахархаж дурсамжтай, дурсгалтай олон үйл явдлын гэрч болсон.

***Онцгой байдлын албыг анх шинээр байгуулагдахад ажиллаж байсан хамт олныхоо талаар дурсвал...?***

ГХЕГ-ын даргаар анхдугаар Үндсэн хууль батлалцсан АИХ-ын депутат, хашир туршлагатай удирдах ажилтан доктор, профессор, хошууч генерал П.Даш, тэргүүн дэд даргаар, доктор, профессор, хошууч генерал О.Үржин, дэд даргаар хурандаа Д.Хишигбаатар, дэд дарга бөгөөд улсын нөөцийн газрын даргаар энгийн Т.Ганболд, БХЗГ-ын даргаар хурандаа Ж.Намсрайжав, МУГ-ын даргаар хурандаа Д.Батбаатар, СХОХэлтсийн даргаар Даваа нар ажиллаж байсан. Тухайн үед Төр засгаас авч хэрэгжүүлсэн энэхүү бодлогын алсын харааг ойлгоогүйгээс зарим нэг хүмүүс Төрийн албаны тухай хуулинд харшилсан үйлдэл үзүүлж эсэргүүцэх хандлага ч бас байсан. Эдгээр хүмүүс аяндаа цагийн эрхээр байдлыг ойлгож албанаас гарсан. Ер нь Төр засгийн бодлого, дэлхийн нийтийн нийтлэг жишгийг сөрөөд хаа холдох вэ? Харин ч орон нутагт ажиллаж байгаа аврагч, гал сөнөөгч, офицерууд энэ нөхцөл байдлыг хамгийн сайн ойлгож байсанд баярладаг. Гурван өөр сайдын эрх ашгийн хүрээнд байсан гурван агентлагийг нэгтгэх нь зарим нэг удирдах албан тушаалтанд амар байгаагүй байхаа. Сайд У.Хүрэлсүх томилогдсоныхоо дараа энэ албаны эрх зүйн орчныг бүрдүүлэх, албыг чадваржуулах ажилд шуурхайлан орсон. Юуны түрүүнд Гамшгаас хамгаалах хуулинд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайн үед ОБЕГ-ын Төрийн захиргаан удирдлагын газрын бие бүрэлдэхүүн өдөр шөнөгүй, амрах цаггүй ажилладаг байлаа. 2004-2005 онд энэ албаны эрх зүйн орчин үндсэндээ бүрджээ. Аврагч, гал сөнөөгчдийн ажиллах, амьдрах орчин нөхцөл үлэмж сайжирсан, цалингийн зэрэглэлийн хувьд авч үзвэл ОБА-ны ахлагчийн цалин Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн бага тушаалын офицеруудын цалинтай тэнцэх хэмжээнд болж ирсэн. Албанд шинэ төрлийн техник, тоног төхөөрөмжөөр хангах ажиллагаа сайжирсан. Одоо хийгдэж буй техникийн шинэчлэлийн ихэнх асуудал тэр үед шийдэгдсэн.

***Онцгой байдлын сургуулийн анхны захирлаар томилогдсон тухай?***

2012 оноос эхлэн ХСИС-д ОБС-ийг шинээр байгуулсан. Өмнө нь БХИС, ХЦДС-д ажиллаж байсан туршлагыг минь харгалзан үзсэн байхаа. ХСИС-ийн бүрэлдэхүүн ОБС нь 6 тэнхим, 1 клиник сургалтын төвтэйгээр, Удирдлагын сургуульдаа ОБА-ны оператив-стратегийн профессорын багтай, Ахлагчийн сургуульдаа ОБА-ны тэнхимтэй, Шинжлэх ухаан технологийн газартаа Гамшгийн эрсдлийн төвтэйгээр үйл ажиллагаагаа явуулахаар бүтэц орон тоогоо батлуулан ажиллаж байна. Мөн энэ жилээс анхны Гамшиг судлалын магиструудаа аван хичээлээ эхлүүлсэн. Ирэх хичээлийн жилээс Гамшиг судлалын чиглэлээр докторын сургалтаа эхлүүлэхээр төлөвлөж байна. Боловсролын салбарт хийгдэж буй шинэчлэлийн хүрээнд манай сургууль бусад тэргүүлэх их сургуулиудаас хоцрохгүй байх бодлого баримталж, багшлах бүрэлдэхүүнийг эрдэмшүүлэх шаардлага гарч байна. Ний нуугүй хэлэхэд ОБА нь шинээр байгуулагдсан салбар учраас өөрийн



гэсэн мэргэжлийн дуу хоолойгоо зоригтой хэлэх эрдэмтэн судлаачид цөөхөн байна. Жишээлбэл, Батлан хамгаалах яам цэргийн шинжлэх ухаанаар 60 гаруй, Хил хамгаалах байгууллага 40 гаруй, Хууль зүйн шинжлэх ухааны чиглэлээр 100 шахам эрдэмтэдтэй болчихсон байгаа нь тухайн салбараа шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх, бэхжүүлэхэд нь мэргэжлийн дуу хоолойгоо Төр засаг, улс төрийнхний хүрээнд ойлгуулахад үлэмж нэмэртэй байдаг. Тун удахгүй Онцгой байдлын салбар ч ялгаагүй өөрийн гэсэн эрдэмтэдтэй болох байх гэж боддог. Энэ чухал үйлсэд хүчин зүтгэсэн олон сайн багш нар байгаа нь бидний бахархал юм. Тухайлбал хурандаа Д.Эрдэнэбилэг, Ж.Ганбаатар, дэд хурандаа Б.Машбат, С.Батгөмөр, хошууч У.Ганхөлөг, Х.Сүхбаатар нар юм.

***Аливаа юманд анхдагч байх сайхан. Таныг олон зүйлд анхдагч болж байсан гэж сонсож байсан. Ямар ямар зүйлд анхдагч болж байсан бэ?***

Цэргийн офицер хүн ажил мэргэжлээрээ бахархаж, албаа хүндэтгэж, үргэлж шинийг сурч мэдэхийн төлөө зүтгэж байвал амжилт бүтээл аяндаа ирдэг гэж боддог. Мөн хамт алба хааж байсан дарга, цэрэг нараараа бахархаж амжилт бүтээлийг хамтдаа хуваалцаж, бэрхшээлийг хамт сөрж гарч байх нь хамгийн сайхан дурсамж юм шиг санагддаг. Миний хувьд зөвхөн өөртөө бахархал болгож дурсах ганц хоёр юм бий. 1983 онд төгссөн нэг үеийн 200 шахам дэслэгч нараас ажил бүтээлээрээ шалгарч Тэргүүний залуу офицеруудын зөвлөгөөн, тэргүүний онц хилчин харуулчдын зөвлөлгөөнд оролцож байлаа. Үеийнхнээсээ хамгийн анхдагч нь болж хорооны захирагч болж байсан, 1994 онд хурандаа цол хүртэж байсан, цэргийн ухаанаар докторын зэрэг хамгаалж байснаараа бахархдаг. Ер нь тэр үеийн офицеруудаас олон шилдэг тэргүүний хүмүүс төрж гарч байсан. Тухайлбал УИХ-ын гишүүн, генерал Х.Жекей, хилийн цэргийн дэд дарга, генерал А.Лхагвасүрэн нар ч манай оны офицерууд юм. Мөн ОБА-нд ажиллаж байгаа ахархан хугацаанд хэд хэдэн удаа анхдагч болж байжээ.

Тухайлбал ГХЕГ-ын анхны Тамгын газрын дарга, ОБЕГ-ын анхны ТЗУГ-ын дарга, ШУТЗ-ын орлогч дарга, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн анхны эрдэмтэн нарийн бичгийн дарга, анхны комиссаруудын нэг, энэ албаны анхны улсын парадыг удирдсан. Онцгой байдлын сургуулийн анхны захирал гээд миний хувьд бахархуштай дурсамж байдаг. Мөн Төрийн албаны зарчим хэм хэмжээг ойлгодоггүй улс төрийн албан тушаалтны шийдвэрээр нэг жилийн дотор 9 удаа халагдаж, 3-н шатны шүүх хурлаар орж, энэ албанд 10 орчим албан тушаалд томилогдож байсан сонин түүх бий. Цэргийн мөрдөс зүүснээс хойш 35 дах жилдээ алба хааж байна. Ингэхдээ би Монгол Улсынхаа хилийг бараг бүтэн тойрсон бөгөөд хилийн цэргийн боловсон хүчнийг сургадаг эрдмийн уурхай болсон Хилийн Цэргийн дээд сургуульд хамгийн анхны хилийн факультетийн даргаар, мөн ХХЕГ-т Шинжлэх ухаан, технологийн зөвлөл байгуулагдахад хамгийн анхны эрдэмтэн нарийн бичгийн даргаар, мөн хилчдээ төлөөлөн ҮАБЗ-ийн ажлын албанд референтээр томилогдон ажиллаж байсан. Үргэлж шинэ Хамт олны дунд орж би өөрөө бас шинэ хамт олноосоо их зүйлийг мэдэж суралцаж байсан юм. Тухайлбал Онцгой байдлын анхны сайд У.Хүрэлсүх, генерал Ш.Арвай, Д.Базарсад, П.Сүндэв, П.Даш, О.Үржин ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга доктор Р.Болд нар юм.

Ялангуяа Онцгой байдлын анхны сайд У.Хүрэлсүх, анхны дарга генерал П.Даш нар шинэ тутам байгуулагдсан энэ албыг ахар богино хугацаанд хөл дээр нь босгож дотооддоо төдийгүй дэлхий нийтэд таниулж чадсан. Үүнийг цаг хугацаа харуулна гэж боддог.

***10 жилийн ойгоо тэмдэглэж байгаа хамт олондоо хандаж таны хэлэх үг?***

Улсынхаа дархан хилд алба хаасан тэр үе маань хамгийн сайхан мөч байлаа. Мөн энх цагийн баатрууд болсон үе үеийн аврагч, гал сөнөөгч нийт хамт олондоо хамгийн сайн сайхныг хүсэн ерөөж байна. ОБА-ны ирээдүй удирдах бүрэлдэхүүн болох одоогийн сонсогчдодоо аз жаргал сайн сайхныг хүсье.

## АХМАДЫН БАЙГУУЛЛАГА

Улсын иргэний хамгаалалтын газрын Ахмадын хороо /хуучин нэрээр/ анх 1989 онд байгуулагдан үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд төрийн болон төрийн бус байгууллагыг шинэчлэн бүртгэхэд 2005 онд Онцгой байдлын ерөнхий газрын Ахмадын хороо болон зохион байгуулагдсан байна. 1989 оноос хойш Улсын иргэний хамгаалалтын болон Онцгой байдлын ерөнхий газрын Ахмадын хорооны даргаар чөлөөнд байгаа дэд хурандаа М.Алтансүх, хошууч генерал Г.Махбариад, хурандаа Б.Жанчив, дэслэгч генерал Г.Дамдинсүрэн, бэлтгэл комиссар Д.Хишигбаатар нар ажиллаж байжээ.

Ахмадын байгууллага туслах аж ахуй хөгжүүлэх, ахмад настнууддаа тусалж дэмжих, ногоон байгууламж бий болгох, орчноо тохижуулах, тасалгааны цэцэг, жимс жимсгэний бут сөөг тарих тэднийг арчилж хамгаалах, асуудлыг хариуцан ажиллаж үхрийн нүд, монос, нохойн хошуу, шар хуас, хуш зэрэг 1600 ширхэг мод тарьж, 640 метр квадрат талбайг зүлэгжүүлжээ. Түүний зэрэгцээ алба хаагчдад ашиглах гарын авлага, “Эргэн дурсах он жилүүд”, “Гал түймэртэй тэмцэх байгууллагын мөнх дурсагдах үйлстэн, ахмад ажилтны дурсамж”, “Гал унтраах сургалт” зэрэг сурах бичиг бичиж хэвлүүлэх, объектын болон ой хээрийн түймрээс



*Одонт эхчүүдийн өдөрлөг 2013 он*

урьдчилан сэргийлэх ажилд ихээхэн үүрэг гүйцэтгэж иржээ. 2009 онд Онцгой байдлын ерөнхий газрын дарга асан тэргүүн комиссар Ц.Амгаланбаяр анх удаа ахмад настнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодит дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын сан” байгуулах тухай 264 тоот тушаал гарган 2010 онд 3 сая, 2011 онд 14 сая, 2012 онд 18 сая төгрөгний фонд байгуулан Ахмадын хороог үйл ажиллагаагаа явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллажээ. Энэ тушаал мөрдөгдсөнөөс хойш амьдралын түвшин доогуур өөрийн гэсэн орон гэргүй 9 ахмад настанд гэр худалдан авч өгч, мөн давхардсан тоогоор 130 гаруй ахмад настанг рашаан сувилалд эмчлүүлэн сувилуулж гарсан зардлын 50 хувийг сангаас олгодог болсон, хүндээр өвчлөн эмнэлэгт болон гэртээ эмчлүүлж байсан 70 гаруй ахмад настанд сэтгэл санааны дэмжлэг, мөнгөн тусламж үзүүлж, 75 ба түүнээс дээш настай 27 ахмад настанг витаминжуулах хөтөлбөрт хамруулжээ.

2010 оны 6 дугаар сард Онцгой байдлын албаны Ахмад залуу үеийн чуулга уулзалтыг анх удаа зохион байгуулж байгууллага, хамт олон, ахмад настны өмнө тулгамдаж байгаа асуудлыг ярилцаж, шийдвэрлэх

арга замаа тодорхойлон үйл ажиллагаагаа идэвхжүүлсэн байна. Энэ арга хэмжээнд төв орон нутгаас 3 үеийн төлөөлөл болж 200 гаруй алба хаагч, ахмад настнууд оролцжээ. Энэ уулзалтаас “Ахмад залуу үеийн чуулга уулзалт”-ыг 3 жил тутамд зохион байгуулж байхаар шийдвэр гаргасан байна.

2009-2013 оны хооронд ахмад настны хөдөлмөрч дайчин уламжлал, ажлын баялаг дадлага, туршлагыг залуу үед өвлүүлэх, ахмад настнаа алдаршуулах зорилгоор 22 ахмад настны хөдөлмөрийн алдрыг тэмдэглэсний зэрэгцээ Улсын иргэний хамгаалалтын болон Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн салбарт он удаан жил, идэвх зүтгэл гарган ажилласан 200 гаруй ахмад настанг төрийн дээд шагнал одон, медаль, салбарын шагналд тодорхойлноос 109 ахмад настан төрийн дээд шагнал Цэргийн болон Хөдөлмөрийн гавьяаны улаан туг, Цэргийн гавьяа, Алтан гадас, Тусгаар тогтнолын одон, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, Эх орны төлөө медаль, Ардын боловсрол, Батлан хамгаалах, Санхүү бүртгэл, Соёлын, Онцгой байдлын албаны тэргүүний ажилтан, Осолгүй манлай жолооч, Онц гал сөнөөгч, Онцгой байдлын албаны төлөө I зэрэг, Монголын Ахмадын холбооны болон ОБЕГ-ын Ахмадын хорооны шагнал “Ахмадын алдар”, тэмдгүүдээр тус



Манзуширын хийдийн аялал 2013 он

тус шагнуулжээ.

Ахмад настнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор жил бүр эх орны түүх дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газар болох 3-4 чиглэлд тойрон аялал хийх, спортын 10 гаруй төрлөөр уралдаан тэмцээн зохион байгуулдаг болов. 2013 онд Онцгой байдлын албаны гурван үеийн хоёр дахь чуулга уулзалтыг зохион байгуулсаны дээр ахмад настнуудын үүсгэл санаачлагыг харгалзан Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбоог байгуулах ажлыг дэмжсэн байна. ОБЕГ-ын Ахмадын хорооны дэргэд урлаг уран сайханы “Золбоо” хамтлаг ажилладаг бөгөөд 2013 онд Солонгос улсын Сөүл хотод зохион байгуулагдсан Дэлхийн ахмад настнуудын урлагын их наадамд оролцон хоёрдугаар байранд шалгарч байжээ.

Онцгой байдлын байгууллагын Ахмадын холбоо байгуулагдснаар төв орон нутгийн Ахмадын хороо, зөвлөл, салбарын ажлыг нэгтгэн удирдах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ахмад настнуудын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхэд ач холбогдолтой болсон байна.

2009 оноос эхлэн Ахмадын хорооны удирдах зөвлөлийн гишүүнээр түшиглэсэн байгууллагын дэд даргыг сонгон ажиллуулдаг болсон нь Ахмадын хорооны үйл ажиллагааг удирдлагад танилцуулах, тэдний зүгээс дэмжлэг авахад үр дүнгээ өгсөн бодит ажил болжээ.



*Хөдөлмөрийн алдар 2012 он*



## ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСЭД



*Онцгой байдлын албаны энхийг сахиулахын нэгдүгээр ээлжийн алба хаагчид 2012 он*

Монгол улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд анхны цэргийн баг илгээж байснаас хойш 10 гаруй жил болжээ. Харин 2012 онд Хүчний байгууллагуудын хамтарсан анхны бие даасан батальон БНӨСУ-д НҮБ-ын Unmiss ажиллагаанд оролцсон юм. Тус энхийг сахиулах ажиллагаанд Монгол улс 850 албан хаагчаа илгээсэн. Энхийг сахиулахын 1-р ээлжинд ОБА-наас нийтдээ 28 албан хаагч 2012 оны 8 дугаар сарын 27-нд явж 7 дугаар сарын хугацаатай үүргээ амжилттай биелүүлээд иржээ. Энэхүү 28 албан хаагчийн 27 нь Өмнөд Судан улсад, 1 албан хаагч Хойд Судан улсад үүрэг гүйцэтгэсэн байна. Энхийг сахиулахын 1-р ээлжийг Аврах тусгай ангийн захирагчийн орлогч, штабын дарга Онцгой байдлын дэд хурандаа Б.Үнэнбаатар ахалж явжээ. Хоёрдугаар ээлжинд Онцгой байдлын албанаас 37 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ ээлжийг Ховд аймгийн Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 48-р ангийн захирагч Онцгой байдлын ахмад Д.Эрдэнэбат ахалж явсан. Гуравдугаар ээлжинд нийт 35 албан хаагч үүргээ гүйцэтгэж байгаа бөгөөд энэхүү ээлжийг Нийслэлийн Аврах шуурхай бүлгийн салбарын эмч, Онцгой байдлын ахмад Г.Хатанбаатар ахалж явсан байна.

Онцгой байдлын дэд хурандаа Б.ҮНЭНБААТАР:

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНЫХАА НЭРИЙГ ӨНДӨРТ ӨРГӨСӨН**

Бид Өмнөд Судан улсад усан эргүүл, хол ойрын эргүүл мөн баазын харуул хамгаалалтын үүргийг Зэвсэгт хүчний албан хаагчидтай мөр зэрэгцэн биелүүлж байсан. Анх Өмнөд Суданд буухад нэмэх 40 гаруй хэмийн халуун байлаа. Үүрэг гүйцэтгэгч бүр сум нэвтэрдэггүй хантааз, гурван магазин сум, малгай, өвдгөвч, тохойвч гээд нийтдээ 10 гаруй кг ачаатай явна. Очсон өдрөө энд яаж долоон сар болно доо гэж бодож байлаа. Биднийг тэр халуунд байж ядаж байхад нутгийн иргэд 45 хэмийн халуундаа хөл бөмбөг, сагсаа тоглоод байж байдаг юм билээ. Сар хүрэхгүй хугацааны дараа гэхэд Монгол цэргүүд халуунд дасч, сагс гар бөмбөгөө тоглоод гүйж харайгаад байж чаддаг болсон. Монгол хүн дасан зохицох чадвар өндөр гэдэг үнэн юм байна даа гэж бодож байлаа.



*“НУБ-ын энхийн төлөө” медаль гардав*

Биднийг Өмнөд Суданд алба хааж байхад болсон нэгэн мартагдашгүй үйл явдал бол Монгол улсын Ерөнхийлөгч, Монгол улсын зэвсэгт хүчний командлагч Ц.Элбэгдорж цагаан сараар очиж байлаа. Ерөнхийлөгч энхийг сахиулах албаны үүрэг гүйцэтгэгчдээ анх удаа эргэж очсон нь энэ юм. Гэтэл ямар ч орны Ерөнхийлөгч өөрийн энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа албан хаагчдаа бааз дээр нь ирж эргэж байсан түүх байхгүй юм билээ. Тэнд байгаа гурван баазаар очиж бүх албан хаагчидтайгаа золгож, шагнал гардуулсан. Миний хувьд Ерөнхийлөгчөөс “НУБ-ын энхийн төлөө” медаль гардан авч байлаа. Энэ бол мартагдашгүй үйл явдал болж сэтгэлд минь үлджээ.

Мөн тэнд үүрэг гүйцэтгэж байх 7 сарын хугацаанд 7 тэргүүний салбарын офицер шалгарсны нэгээр шалгарч, Батальон захирагч Л.Гансэлэмийн гарын үсэг бүхий дурсамж гардан авсандаа үнэхээр бахархдаг. Энэ бол ОБА-ныхаа албан хаагчдын нэр төрийг хамт өргөсөн явдал юм. Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон албан хаагчид их тэсвэр хатуужилтай бас хүнээс үг сонсож чаддаг болсон гээд хувь хүнийхээ хувьд олон сайхан чанарыг өөртөө бий болгож чаддаг юм билээ.



*Энхийг сахиулагчид нэгдүгээр ээлж 2013 он*



Энхийг сахиулагчид хоёрдугаар ээлж 2013 он



Энхийг сахиулагчид гуравдугаар ээлж 2014 он





## ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Монгол улсад тохиолдсон гамшиг ослын үед Гадаадын олон улс орнуудаас хүмүүнлэгийн тусламжийн гараа харамгүй сунгаж байсан жишээ олон бий. Тэрхүү сайхан сэтгэлийн дэм тусаар олон гамшиг зовлонг давж ирсэн. Монгол хүн “тэвдэж явахад тэвнээр” туслах, тусыг бага гэж чамладаггүй уужуу ухаантай ард түмэн юм. Гэхдээ бид үргэлж авахыг эрмэлзэж байгаагүй. Ямар ч үед монгол хүн аяганы хариу өдөртөө агтын хариу жилдээ хэмээн хэлдэг. Дэлхий ертөнцийн аль ч өнцөг буланд байгаа улс оронд хэлж ирдэггүй хийсч ирдэг гай зовлон тохиолдсон үед тусламжийн халуун гараа сунгаж, сэтгэлийн дэм үзүүлж ирсэн түүх байдаг.

### 2004 он

Япон улсад далайн хүчтэй шуурга болж, газар хөдлөн, олон мянган хүн амь эрсдэж, хот тосгод сүйрч, байгалийн гамшгийн өмнө хүчин мөхөсдсөн энэ үед Гамшгаас хамгаалах газар санаачилан Японы ард түмэнд туслах хандив тусламж цуглуулах аяныг Монгол улс даяар зохион байгуулж байсан. Энэхүү аянд 200 шахам төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, пүүс компани, хувь хүмүүс оролцож 50 мянган ам доллар хандивласан. Хандив тусламжийн арга хэмжээний хаалтын ажиллагаа болгож, урлагийн нэрт мастеруудын тоглолт зохион байгуулж байв. Монгол улсын ерөнхий сайд Н.Энхбаяр болон, Япон улсаас Монгол улсад суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Тацүо Тода нар оролцсон юм.

### 2005 он

Индонезийн Суматра арлын орчимд болсон газар хөдлөлтийн улмаас үүссэн далайн хүчтэй цунамид Зүүн Азийн 12 улс нэрвэгдэж олон мянган хүн амь насаа алдаж, үлэмж хэмжээний хохиролд өртсөн. Эдгээр гамшигт өртсөн улс орнуудад тусламж үзүүлэх хөдөлгөөн Дэлхий нийтэд өрнөсөн тул Монгол оронд ч эрчимтэй өрнөж, МУЗН-ээс тусламжийн уриалга гаргасны зэрэгцээ, НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газраас гамшигт өртсөн олон зуун мянган хүүхдүүдэд зориулсан хандивын сан нээж ажиллуулж байв. Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагаас гамшгийн нөхцөл байдал сайжирсны дараа гамшигт өртсөн улс орнуудын гамшгийн удирдлагын бие бүрэлдэхүүнд зориулсан бэлэн байдлын тусгай сургалт зохион байгуулахад ОБЕГ түүний харъяа анги салбаруудаас нэг өдрийн цалингаа хандивласан. Энэхүү хандив нийтдээ 5490 гаруй ам доллар буюу 6,7 сая төгрөгийг ОУИХБ-ын дансанд шилжүүлжээ.

### 2011 он

Япон улсад хүчтэй газар хөдлөлт түүнээс үүдэлтэй цунамид нэрвэгдэгсэд хандив тусламж үзүүлэх ажлыг УОК, ОБЕГ шуурхай зохион байгуулж, Монгол улсын засгийн газар, ард иргэдээс 2 сая долларыг Японы ард түмэнд дэмжлэг тусламж болгон өгсөн. Гамшгийн үеэр эрэн хайх, аврах ажиллагаанд Онцгой байдлын албаны аврагчид анх удаа гамшиг болсон улс оронд очиж үүрэг гүйцэтгэсэн анхны тохиолдол болсон юм. Тус газрын Гамшигтай тэмцэх газрын ахлах мэргэжилтэн дээд ахмад Ш.Ганболдоор ахлуулсан 12 аврагч оролцож үүргээ амжилттай биелүүлээд ирэв. Энэхүү үйл явдал нь Монгол улс болон Онцгой байдлын албаны нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөсөн төдийгүй бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар дэлхийн хэмжээнд үнэлэгдэж, олон улсын хэмжээнд ажил үүрэг гүйцэтгэх чадвартай болсныг илтгэн харуулсан юм.



## Онцгой байдлын ахлах дэслэгч Ц.ЭРДЭНЭБИЛЭГ: ЦУНАМИГИЙН ГОЛОМТОД АЖИЛЛАСАН

2011 оны 3 дугаар сарын 13 -ны Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр Япон улсын цунамид өртсөн ард түмэнд туслах аврагч нарыг явуулах болж Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар Онцгой байдлын ерөнхий газрын Гамшигтай тэмцэх газрын Шуурхай удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Ш.Ганболд, Аврах тусгай ангийн Эрэн хайх аврах бүлгийн дарга ахлах дэслэгч Ц.Эрдэнэбилэг, хүний их эмч дэслэгч Б.Ариунбат, аврагч химичин ахлах ахлагч Ю.Ганзориг, аврагч шүхэрчин О.Батбилэг, аврагч, ахлах ахлагч Ч.Ганзам, Х.Бямбадорж, С.Энхболд, Н.Цоггэрэл, Н.Хуягбаатар, Ж.Баяртогтох, ахлагч Ч.Бямбадорж нарын бүрэлдэхүүнтэй эрэн хайх, аврах, сэргээн босгох үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр 2011 оны 03 дугаар сарын 15 нд Япон улсыг зорьсон билээ.

Газар хөдлөлт болж цунами бий болсноор олон мянган хүн нас барж орох оронгүй болж олон арван барилга байшин сүйдсэн аймшигт аюул болж орилсон, үймсэн, хашгирсан, сандарсан хүмүүс байх байхдаа гэж бид бодож төсөөлж байтал харин шал өөр орчин хүлээж авсан. Газар хөдлөлтийн дараагаар ямар ч барилга байшин сүйрээгүй бөгөөд зөвхөн цунамид хамаг зүйл сүйрснийг хараад Япон улсын барилга байгууламжийн хийц технологи нь газар хөдлөлтөд маш их тэсвэртэй юм байна гэсэн бодол төсөөлөл төрж байсан. Хичнээн том байгууламж, хэдий сайн хамгаалалт байлаа гээд байгаль дэлхийн өмнө хүн гэдэг ямар өчүүхэн, байгалийн өмнө хүчин мөхөсдөх нь харагдаж байлаа. Харин нэг зүйл онцлоход япончууд бол ийм хэцүү үед юманд маш тайван ханддаг улс юм байна гэдэг нь харагдлаа. Тэгж айхтар гамшгийн аюул бий болж байхад үймж шуугихгүй, ёс журам дэс дараагаа нягт барьж ажиллах юм. Энэ олон сая хүн орилж хашгираад, дайраад унавал цунамигаас аюултай юм болох байсан байх. Ийм айхтар байгалийн аюулын аман дээр байдаг улсад тайван уужуу байх л хамгийн чухал зүйл байдаг юм байна даа гэж бодогдож байсан. Үүнийг бүр хар багаасаа хүүхэд байхаасаа сурч төлөвшсөн байдаг нь гамшгаас хамгаалах менежмент сайн хэрэгжиж байсны үр дүн гэж бодож байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх байгууламж менежментийг үнэхээр сайн боловсруулсан байсан нь гамшиг гарсны дараа бус гамшиг гарахаас өмнөх урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь үнэхээр анхан шатны нэгж буюу аж ахуй нэгж байгууллага, иргэддээ хүрч чадсан байгаа юм. Мянги муж Сэндай хотын спортын цогцолбор хотхоны гадна талбай дээр манай баг байрласан байсан. Мөн ОХУ, БНСУ, Австрали, ӨАБНУ, Куба, Малайз улсуудын “Аврах баг”-ууд тухайн газар байрласан байлаа. Манай улсын аврах баг гамшгийн голомтод ӨАБНУ, Тайвань, Малайз улсуудын “Аврах баг”-уудтай мөн Сэндай хотын цагдаагийн байгууллагатай байнга хамтран ажиллаж байлаа. Манай аврах баг эрэн хайх, аврах ажиллагаагаа Сэндай хотын Нисэх онгоцны буудал, Усан онгоцны боомт, Натори, Милазоно гэсэн тус тус газруудад хийсэн.

Япон улсын аврах алба нь гамшгийн голомтонд дөрвөн үе шаттай “эрэн хайх, аврах, сэргээн босгох” ажиллагааг явуулахдаа:

- 1 дүгээр ээлжинд гамшгийн голомтоос амь тэмцэж байгаа нэрвэгдэгчид аврах ажиллагааг явуулж,
- 2 дугаар ээлжинд гамшгийн голомтоос цогцосыг гаргах ажиллагааг явуулж,
- 3 дугаар ээлжинд гамшгийн голомтонд нягтлан үзэх ажиллагааг явуулж үзлэг явуулсан орчинд амьд хүн, цогцос байхгүй гэсэн үед,
- 4 дүгээр шат буюу сэргээн босгох ажиллагааны эхний алхам, гамшгийн голомтонд хүнд механизм оруулж нурангийг цэвэрлэх ажиллагааг явуулж байлаа.

Бид ажиллагааны үеэр хайнга буюу бусад улс орны аврагч нарт итгэн гамшгийн голомтонд нурангийн ямар нэгэн хэсэгт амьд хүн, цогцос харахгүй, мэдэлгүй өнгөрөөсөн бол маш том алдаа гаргах байлаа. Учир нь нурангийг зөөж ангилан ялгах цэг дээр хүргэж байсан юм. Хэрвээ алдаа гаргавал Монгол Улсын аврагч нарын нэр хүнд олон улсын тавцанд унах, Монгол Улсын Онцгой байдлын алба олон улс, Монголын ард түмний дундах үнэлэмж ямар хэмжээнд очих байсан нь тодорхой юм.

Үүсэх байдлыг урьдчилан таамаглаж байсан учир алдаа дутагдал гаргахгүй ажиллахыг манай багийн гишүүд бүгд ухамсарлаж байсан. Дэлхий дээр зэрэгцэн оршиж байгаа улс орнууд бие биенээсээ суралцаж, туршлага солилцож өөрийн орныг хөгжүүлэх нь байх ёстой зүйл. Бидэнд суралцах зүйл их байгааг мэдэрч явлаа.



*Монголын аврагчид Цунамигийн дараахь аврах эрэн хайх ажиллагаанд оролцож байгаа нь. Япон улс 2011 он*

Монголын аврагчид олон улсын хэмжээнд анх удаа аврах үйл ажиллагаанд оролцсоныг Монгол Улсын Ерөнхийлөгч өндрөөр үнэлж биднийг “ШУДАРГА ЖУРАМ” медиалаар шагнасан. Мөн Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд гамшигт өртсөн хүмүүсийг аврах үйлст их хувь нэмрээ оруулсан гэж өндрөөр үнэлж “ТАЛАРХАЛ” –ын бичиг багийн гишүүдэд гардуулсан билээ.



## “МОНГОЛ УЛСАД ГАМШГИЙН АЮУЛЫГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ” ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

НҮБХХ, Люксембургийн Засгийн газраас Монгол Улсын гамшгийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний болон орон нутгийн түвшинд эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 3.685.000 ам долларын хөрөнгө оруулалт бүхий “Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” төслийг 2002-2011 онд 3 үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлэв.

Тухайлбал, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Монгол Улсын гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх үндэсний хөтөлбөрийг Гамшгийн аюулыг бууруулах Хёогогийн тунхаглал, Мянганы хөгжлийн зорилттой уялдуулан боловсруулах, Онцгой байдлын ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжүүдийг бэхжүүлэх хүрээнд албан хаагчдыг сургаж бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад бодит дэмжлэг үзүүлсний зэрэгцээ сургалтын гарын авлага ном, товхимол гаргаж, нийтийн хүртээл болгожээ. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гамшгаас хамгаалах боловсрол олгох зорилгоор “Аюулгүй амьдрах ухааны үндэс” хичээлийн материалыг боловсруулж, хэвлүүлэн бүх аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлснээс гадна уламжлалт ардын ухааны талаар телевизийн цуврал хичээлийг нэвтрүүлж, DVD, гарын авлагыг ард иргэдэд түгээв. Нутгийн иргэдэд тулгуурласан гамшгийн менежментийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 75 жижиг төсөл хэрэгжүүлж, үр шимийг нь 10 мянга гаруй хүн шууд хүртжээ.

Төслийн 4 дэхь шаг буюу 1,500,000 ам.долларын санхүүжилт бүхий “Орон нутгийн түвшинд



*Төслийн дөрөв дахь шатны хамт олон*

гамшгийн эрсдлийг бууруулах менежмент, зохицуулалтын чадавхийг бэхжүүлэх нь” төслийг гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах удирдлага, зохицуулалтын оновчтой механизмыг хэрэгжүүлэх замаар гамшгийн менежментийн төвлөрөл, хот суурин газар, хөдөө орон нутгийн эмзэг байдлыг бууруулах зорилготойгоор 2013-2016 онд хэрэгжүүлэхээр Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, НҮБ-ын суурин зохицуулагч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч хатагтай Сезин Синаноглу, ОБЕГ-ын дарга онцгой байдлын хурандаа Т.Дуламдорж нар 2013 оны 2 дугаар сард төслийн баримт бичигт гарын үсэг зурж, үйл ажиллагааг нь эхлүүлээд байна.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ХУРАНДАА ГЕНЕРАЛ С.РАВДАНГИЙН НЭРЭМЖИТ АВРАХ ТУСГАЙ АНГИ

1967 онд Төмөр замын барилга засвар, сэргээн босголтыг хариуцан гүйцэтгэх үүрэгтэйгээр “Төмөр замын тусгай батальон” нэртэйгээр анх байгуулагдсан. 1969 онд Сургууль байлдааны зориулалттай машин техникүүдийг засварлах, хадгалах үүрэгтэйгээр “Армийн Иргэний Хамгаалалтын инженерийн тусгай батальон”, 1984 онд улс орны иргэний хамгаалалтын системг бэхжүүлэх бодит шаардлагад үндэслэн “Иргэний хамгаалалтын механикжуулсан тусгай хороо” болон өргөжсөн.

1991 онд Зэвсэгт Хүчний 122-р анги. 2004 онд Гамшгаас Хамгаалах Ерөнхий Газрын харьяа Гамшгаас хамгаалах тусгай анги. 2005 онд Онцгой Байдлын Ерөнхий Газрын харьяа Аврах Тусгай Анги болон өөрчлөгдсөн.



2006 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Засгийн газрын тогтоолоор Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит Онцгой Байдлын Ерөнхий Газрын харьяа Аврах Тусгай Анги болсон.

### Ангийн удирдлагууд

Хурандаа М.Чимэд 1967-1978 он, хурандаа Ц.Бямбасүрэн 1978-1979 он, хурандаа Б.Нямаа 1979-1987 он, хурандаа Х.Төмөр 1987-1989, хурандаа Х.Будцэрэн 1989-1996 он, хурандаа Ч.Намсрайжав 1996-2004 он, 2005-2006 он, хурандаа П.Наваансүрэн 2004-2005 он, комиссар Б.Эрдэнэбаяр 2006-2008 он, хурандаа

А.Батмөнх 2008-2012 он, хурандаа Д.Чинзориг 2012 оноос одоо хүртэл ажиллаж байна.

**Ангийн үндсэн үүрэг:**

- Улсын болон орон нутгийн хэмжээнд гамшгийн голомтод хүн хүч, техник хэрэгсэл, мэргэжлийн бүлэг, удирдлага хүрэлцэхгүй үед шуурхай шилжин байрлах.
- Эрэн хайх, аврах ажлыг зохих журмын дагуу явуулах.
- Нэрвэгсдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх.
- Тэднийг аюулгүй газарт зөөвөрлөн гаргах.
- Эд хөрөнгийг нь хамгаалах.



Аврах тусгай ангийн бие бүрэлдэхүүнийг төдийгүй Төв орон нутгийн онцгой байдлын албаны аврагч нарын мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлэх, ангийн цаашдын тогтвортой үйл ажиллагааны хөгжлийг хангаж, аврах ажиллагааны чадавхийг олон улсын хэмжээнд оролцох хүртэл нэмэгдүүлж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын аврах ажиллагааны болон гамшгаас хамгаалах сургалтын төв, бүх төрлийн сургалт, дадлагын материаллаг бааз болгон хөгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Тус анги нь: Штаб, Сургалт, соёл хүмүүжлийн алба, Санхүү үйлчилгээний алба, Мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын төв, Эрэн хайх аврах салбар, Агаарын ажиллагааны салбар, Тусгай чиг үүргийн салбар, холбооны болон хөгжмийн бүлэгтэйгээр үүрэг гүйцэтгэж байна. Сургалтын хөтөлбөрийн дагуу ангийн албан хаагчидтай жил бүр мэргэжлийн бэлтгэл хичээлийг онол, дадлага, хээрийн гаралтаар сургалтуудыг зохион байгуулдаг. Үүнд: Хээрийн гаралтын сургалтанд орон нутагт урсгал ус болон тогтмол усны, барилгын нуранги, хүн малын гаралтай гоц халдварт өвчин, тэсэрч дэлбэрэх бодисоос урьдчилан сэргийлэх, онгоцноос эрэн хайх дадлага. 2011 оноос тус төвийн үйл ажиллагаа эхэлж, цэргийн хэргийн мэдлэг олгох анхан шатны сургалт болон мэргэжил дээшлүүлэх давтан сургалтуудыг зохион байгуулж явуулсан. Үүнд: Цэргийн хэргийн мэдлэг олгох анхан шатны сургалт, аврагч- гал сөнөөгч, гал унтраах автомашины жолооч, дуудлага хүлээн авагч нийт 417 албан хаагчийг хамруулан бэлтгэж, Онцгой байдлын албанд оруулж, төв, орон нутгийн салбар, салаа, бүлгийн дарга нарын зэрэг нийт 74 албан хаагчийг мэргэжил дээшлүүлэх давтан сургалтанд суралцуулан ажиллаж ирсэн.

Албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, боловсрол, ур чадварыг сайжруулах зорилгоор сүүлийн 3

жилд ОХУ-52, БНСУ-32, Япон улсад-11, АНУ, БНХАУ, Турк, Индонез, Франц, Малайз, Филиппин зэрэг улс орнуудад давхардсан тоогоор 113 албан хаагчийг сургаж, дадлагажуулснаар аврагчдын ур чадвар дээшилж, аврах ажиллагааг амжилттай гүйцэтгэж байна

Аврах тусгай анги нь жилд дундажаар 25 удаагийн аюулт үзэгдэл, гамшиг, ослын дуудлагаар давхардсан тоогоор 260 орчим аврагч ажил үүрэг гүйцэтгэж, 75 эрдэнэт хүний амь насыг, 2 тэрбум орчим төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалан ажиллаж байдаг.

**Томоохон аврах ажиллагаа:**

-2010 оны 09 сард зүүн гурван аймагт гарсан малын гоц халдварт “Шүлхий” өвчний голомтод Улсын онцгой комиссын шийдвэрээр химичин-аврагч нар 93 хоног үүрэг гүйцэтгэж 32,435 хүн ариутгаж, 6,657 өвчтэй малыг устгаж, 20,204 техник ариутгах ажлыг зохион байгуулан ажиллаж, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, аж ахуйн нэгжид учирч болох аюулыг бууруулан ажиллав.

-Япон улсын Синдай мужид 2011 оны 03 сард болсон газар хөдлөлтийн улмаас үүссэн цунамиын гамшгийн голомтод Монгол Улсын засгийн газрын шийдвэрээр олон улсын аврах багийн бүрэлдэхүүнд 11 албан хаагч томилогдон үүрэг гүйцэтгэв.

-2011 оны 02 сард Хөвсгөл далайд Урал маркийн 2 автомашин нийт 6,510 тонн шатахуун тээвэрлэж яваад мөс цөмөрч, орсныг тус ангиас томилогдсон 8 аврагч 50 метрийн гүнээс усанд шатахуун алдалгүйгээр



гаргах ажиллагааг амжилттай зохион байгуулав.

-Олон улсын энхийг сахиулах ажиллагааны багт тус ангиас 31 албан хаагч томилогдон Өмнөд Судан улсад үүрэг гүйцэтгэсэн байна.

## НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор нийслэлийн Иргэний хамгаалалтын штаб, Гал түймэртэй тэмцэх хэлтсийг нэгтгэж нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб байгуулагдаж, 2005 оны 48 дугаар тогтоолоор нийслэлийн Онцгой байдлын газар нэртэйгээр байгуулагдсан.

Улаанбаатар хотын 4.7 мянганкм<sup>2</sup> газар нутгийн хэмжээнд 1.281.5 мянган хүн амын аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй Нийслэлийн Онцгой байдлын газар нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны Б/143, А/376 дугаар тушаалаар 197 офицер, 718 ахлагч, 9 төрийн үйлчилгээний, 39 гэрээт ажилчин 9 дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 14 анги, нийслэлийн Аврах ангид албан хаагчид үүргээ гүйцэтгэж байна. Өнгөрсөн хугацаанд аюулт үзэгдэл техникийн холбогдолтой ослын нийт 21625 удаагийн дуудлагаар шуурхай ажиллаж 1747 хүний амь нас, 86,3 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг гамшгийн аюулаас авран хамгаалж хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллажээ.

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргаар Онцгой байдлын хурандаа С.Цогтбаатар, Х.Батбилэг нар ажиллаж байсан бөгөөд өдгөө Онцгой байдлын хурандаа Н.Уламбаяр ажиллаж байна.



*Нийслэлийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн*



*Тамгын хэлтсийн хамт олон*



*Гал унтраах хэлтсийн хамт олон*



### ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь Алтан гадас одонт 1 дүгээр зэрэглэлийн Аврах гал унтраах 10 дугаар анги нийт 117 албан хаагч, 10 машин, техник хүч, хэрэгсэлтэйгээр байнгын бэлэн байдалд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2003-2005 онд нийслэлийн тэргүүний Гамшгаас хамгаалах штаб, 2004 онд Тэргүүний штаб, 2005 онд НОБГ-ын Тэргүүний хэлтсийн дарга, Тэргүүний аврах, гал унтраах анги, 2006, 2007, 2009 онд Тэргүүний хэлтэс, Тэргүүний гал, унтраах аврах анги, 2005-2011, 2013 онуудад дүүрэг, нийслэл, Онцгой байдлын ерөнхий газарт ажлаараа дүүрэн хангалттай шалгагдаж нийслэлийн тэргүүний Онцгой байдлын хэлтэсээр тус тус шалгарсан.



*Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 10 дугаар ангийн хамт олон*

### БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Багахангай дүүрэг нь Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоос хатуу хучилттай замаар 90 км, төмөр замаар 107 км зайд оршдог. Тус дүүрэгт анх 1989 оноос Материал техникийн хангамжийн нэгдлийн гэрээт Гал унтраах анги, Нефть хангамжийн баазын 79 дүгээр анги үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Багахангай хороон дахь Материал Техникийн хангамжийн нэгдлийн гэрээт Гал унтраах команд нэртэйгээр байгуулагдаж байжээ. Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгвй байдлын тухай, Ойн тухай хуулиуд болон бусад холбогдох эрх зүйн актуудыг удирдлага болгон хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



*Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 80 дугаар ангийн хамт олон*

### ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх аж ахуй нэгж байгууллага албан тушаалтан иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулан үйл ажиллагаагаа зохион явуулж байна.



*Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 14, 30, 65 дугаар ангийн хамт олон*

### БАГАНУУР ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Улаанбаатар Багануур хоорондын засмал зам, 1889.0 хоорондох 62020 га нутаг дэвсгэрт амьдарч байгаа дүүргийн 24771 хүн амд болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үндсэн чиг үүрэгтэйгээр үүрэг гүйцэтгэдэг. Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь 6, Аврах, гал унтраах 64 дүгээр анги нь 56 албан хаагчидтай. Үүнээс офицер 9, ахлагч 51, гэрээт 2 ажилтан үүргээ гүйцэтгэж байна.



*Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 64 дүгээр ангийн хамт олон*

### БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход гамшгаас хамгаалах албад, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах уялдуулан зохицуулан Гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 1954 онд Сайд нарын зөвлөлийн тогтоолоор “Төв түүхий эдийн бааз, бөөний худалдааны нэгдлийн гэрээт Гал унтраах анги” нэртэйгээр анх байгуулагдаж, 1954-1997 он хүртэл гэрээт гал унтраах анги, 1997 оноос эхлэн улсын төсвийн II зэргийн Аврах гал унтраах анги зэрэглэлтэй үүрэг гүйцэтгэж байна



*Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 18 дугаар ангийн хамт олон*

### БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Тус хэлтэс нь Аврах гал унтраах 63, 35 дугаар ангиудын офицер 16, ахлагч 77, гэрээт ажилтан 9, нийт 102 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Сүүлийн 10 жилийн байдлаар тус хэлтэс нь нийт 3000 гаруй объектын гал түймрийн дуудлагаар ажиллаж 252 хүний амь насыг аварч, байгууллага аж ахуйн нэгж, иргэдийн 12.8 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалжээ

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 322 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2008 оны 60 дугаар тушаалаар Нийслэлийн Онцгой байдлын газрын Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэсийн харьяа хоёрдугаар зэрэглэлийн Аврах гал унтраах 35 дугаар ангийг 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан байна.



*Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 35, 63 дугаар ангийн хамт олон*

### НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Тус хэлтсийн Аврах, гал унтраах 28 дугаар анги 1962 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 206 тоот тогтоолоор Налайх хотыг хариуцсан улсын гал команд болон үүсэн байгуулагдсан. Налайх дүүрэг нь 68,7 мянган хавтгай дөрвөлжин км нутаг 8992 өрхийн 32513 хүн амтай, 40568 малтай, 810 гаруй байгууллага, аж ахуйн нэгжтэй бөгөөд тус хэлтэс нь дүүргийнхээ иргэдэд болзошгүй гамшгийн аюулаас авран хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.



*Налайх дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 28 дугаар ангийн хамт олон*

### СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 51 дүгээр тогтоолыг үндэслэн дүүргийн Цэрэг - иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалтын чиг үүрэг бүхий Гамшгаас хамгаалах штабт шилжүүлснээр 2004 онд Гамшгаас хамгаалах штаб, 2005 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болж шинээр зохион байгуулагдан Аврах гал унтраах 11,26,29 ангиудыг удирдлагаар хангаж ажилладаг бөгөөд оронтоогоор 152 албан хаагчтай. Үүнээс 23 офицер, 119 ахлагч, энгийн 5 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Аврах, гал унтраах 26 дугаар анги нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 60 тоот захирамжаар Улсын онц чухал объект Мах консерв-Гурилын комбинатын Гал команд нэртэйгээр анх байгуулагдсан түүхтэй.

Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Аврах, гал унтраах 26 дугаар анги нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 60 тоот захирамжаар Улсын онц чухал объект Мах консерв-Гурилын комбинатын Гал команд нэртэйгээр анх байгуулагдсан түүхтэй.



*Сонгинохайрхан дүүргийн онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 11, 26, 29 дүгээр ангийн хамт олон*

### СҮХБААТАР ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Онцгой байдлын хэлтэс нь гамшгаас урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажлыг хэрэгжүүлэн явуулж байна. Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс нь дарга, онцгой байдлын хурандаа Б.Ганбат, Гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч, онцгой байдлын ахмад Ц.Лхагвасүрэн, Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, онцгой байдлын ахмад Н.Хишигбаатар, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, онцгой байдлын хошууч Б.Баттулга, Хэлтсийн нягтлан бодогч, онцгой байдлын ахмад Н.Хажидмаа, Урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, онцгой байдлын дэслэгч Б.Баатар, бичиг хэргийн эрхлэгч Б.Лхамаа, онцгой байдлын дэд хурандаа Д.Цэцэндалай даргатай Аврах, гал унтраах 34 дүгээр анги 50 албан хаагч, гал унтраах үндсэн албаны 3, тусгай албаны 1, шуурхай албаны 1 машинтай техник хүч хэрэгсэлтэйгээр байнгын бэлэн байдалд үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.



*Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Аврах гал унтраах 34 дүгээр ангийн хамт олон*

### НИЙСЛЭЛИЙН АВРАХ АНГИ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/145 дугаар тушаалаар нийслэлийн Аврах анги байгуулагдан Аврах шуурхай салбар, Эрэн хайх аврах салбарын офицер, ахлагч нар иргэдийн осол гэмтлийн дуудлагад шуурхай ажиллаж авран хамгаалж байна.

Нийслэлийн аврах ангийн албан хаагчид анх удаа 2013 онд олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцож нар Өмнөд судан улсад хугацаанд үүрэг гүйцэтгээд ирсэн юм.

Аврах ангид ирсэн дуудлагыг ангилвал дийлэнхийг ахуйн хүрээний осол гэмтэл, химийн бодисын хэрэглээний горим зөрчигдсөн мөн зам тээврийн осол гэмтлийн дуудлага эзэлж байна.



*Нийслэлийн Аврах ангийн хамт олон*



*Баярын парад 2011 он*

## АРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Гамшгаас хамгаалах ерөнхий газрын харьяа Гамшгаас хамгаалах штаб байгуулагдаж анхны даргаар хурандаа Д.Ринчиндорж томилогдон ажиллаж байв. 2005 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 47 дугаар тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Онцгой байдлын хэлтэс болон өөрчлөгдөж, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2012 оны дугаар сарын өдрийн дугаар тушаалаар Урьдчилан сэргийлэх хяналтын тасаг, Аврах, гал унтраах 51-р анги, Эрэн хайх аврах салбар, Төвшрүүлэх суман дахь Улсын нөөцийн салбартайгаар тусгай албан хаагч 73, үүнээс офицер 21, ахлагч 51, энгийн 3, гэрээт 6 ажилтан албан хаагчтай, аврах, гал унтраах болон тусгай зориулалтын 12 автомашин техник, 50 гаруй нэр төрлийн аврах багаж хэрэгсэлтэйгээр үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж байна.

Тус хэлтсийн даргаар 2009-2013 онд онцгой байдлын хошууч Д.Эрдэнэбаатар, 2013 оны 06 сараас онцгой



байдлын дэд хурандаа Г.Баттөгс томилогдон ажиллаж байна. Нийт бие бүрэлдэхүүний 38 хувь нь дээд боловсролтой 62 хувь нь бүрэн дунд боловсролтой.

Сүүлийн 10 жилийн хугацаанд аймаг орон нутагт тохиолдсон 1000 гаруй аюулт үзэгдэл, ослын голомтонд ажиллаж төр, ард түмний өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж ажилласан хөдөлмөрийг үнэлж манай хамт олны дундаас Төрийн дээд одон медаль Цэргийн гавьяаны одонгоор 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 1, Цэргийн хүндэт медалиар 5, Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтнаар 1, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар 4, Онц гал сөнөөгч тэмдэгээр 7, Онцгой байдлын ерөнхий газрын 2012 оны тэргүүний ажилтнаар 1 албан хаагч тус тус шагнагдсан. Мөн БНӨСудан улсад явуулсан НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Онцгой байдлын ахлах ахлагч Ш.Энхболд, Онцгой байдлын ахлах ахлагч Б.Нямхүү нар амжилттай оролцож, үүргээ биелүүлж ирсэн нь бидний бахархал юм.

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

2008 онд Баянхонгор аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн 129 дүгээр тогтоолоор Онцгой байдлын хэлтсийг Монгол Улсын баатар Норпилын Жамбаагийн нэрэмжит болгон өргөмжилсөн. Тус хэлтэс нь Улсын нөөцийн салбарыг хамруулаад нийт 63 албан хаагчтай, үүнээс офицер албан хаагч 13, ахлагч 33, үйлчилгээний 13, гэрээт 4 ажилтантай. Орчин үеийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан шаардлагатай багаж зэвсэглэмжийн хангалт үйлчилгээг цаг тухайд нь хийж, одоогийн байдлаар Гал унтраах тусгай зориулалтын 5, гамшгийн үед ажиллах туулах чадвар сайтай Газ-66 автомашин 4, Зил 131 автомашин 1, шуурхай албаны 5 автомашинтайгаар үүрэг гүйцэтгэж байна.

Баянхонгор аймаг дахь Улсын нөөцийн салбар нь тогтоосон нэр төрөл, чанарын түвшин, тоо хэмжээнд бараа материалыг нөөцлөн, Баянговь, Бууцагаан, Заг сумдын цэгүүдээр дамжуулан иргэддээ ажил үйлчилгээгээ



хүртээмжтэйгээр хүргэн ажиллаж ирсэн.

Өнгөрсөн богино хугацаанд тус хэлтсээс Төрийн одон медаль -19, ОБЕГазрын “Хөдөлмөрийн аварга”-5, Салбарын “Тэргүүний ажилтан”-1, “Онц гал сөнөөгч”-6, аймгийн “Хөдөлмөрийн аварга”-1, аймгийн “Оны тэргүүний албан хаагч”-1, сумын “Хөдөлмөрийн аварга”-4, аймгийн “Тэргүүний ажилтан” -11, сумын “Сайн үйлстэн”-9, Спортын мастер-2, дэд мастер 3 төрөн гарсан.

Мөн тус хэлтсийн шигшээ багийн тамирчид 2012 оны ГУТОТСпортын Улсын аварга шалгаруулах тэмцээнд шилдэг 24 багийн баг тамирчидтай хурд хүч, авхаалж самбаагаа сорьж багийн дүнгээр 2-р байр, 2013 оны Төвийн бүсийн ГУТОТСпортын аварга шалгаруулах тэмцээнд 5 төрөлтийн 4 төрөлд алтан медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр, Монгол Улсын “Хууль сахиулахын их сургууль”-ийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан ГУТОТСпортын тэмцээнд урилгаар оролцож 1-р байрт шалгарсан бахдам амжилтуудыг үзүүлээд байна.



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

1971 онд Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Баян- Өлгий аймгийн Нийгмийг аюулаас хамгаалах хэлтсийн дэргэд “Гал команд” нэртэйгээр байгуулагдаж, анхны даргаар Ц.Банди томилогдон, 25 хүнтэй, гал унтраах 2 автомашинтай үүрэг гүйцэтгэж эхэлсэн байна. Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Цагдаагийн ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар болсноор Гал команд нь бие даасан гал түймэртэй тэмцэх алба болж, улмаар аймгийн Засаг даргын 2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 12 тоот захирамжаар Гал түймэртэй тэмцэх хэлтэс болон өргөжсөн байна. Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын хэлтэс нь 3 дугаар зэрэглэлийн Гал унтраах 31 дүгээр анги, Эрэн хайх - аврах бүлэг, Нөөцийн салбартайгаар аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагаар зохион байгуулагдсан.

Тус хэлтэс нь бүтцийн хувьд Урьдчилан сэргийлэх хяналтын тасаг, Гал унтраах 31 дүгээр анги, Эрэн



хайх, аврах бүлэг, Улсын нөөцийн салбар зэрэг нэгжтэй бөгөөд нийт 74 албан хаагчтай, гал унтраах үндсэн автомашин 2, усны цистерн 2, фургон 2, суудлын автомашин 1, ачааны ГАЗ- 66 автомашин 1, эмнэлгийн түргэн тусламжийн автомашин 1, моторт завь 2 болон бусад аврах багаж хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.



## БУЛГАН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Сайд нарын зөвлөлийн 1976 оны 6 дугаар сарын 17 –ны өдрийн 276 тоот тогтоолоор захиргаа аж ахуй, гал сөнөөгч зэрэг 20 хүний орон тоотой гал унтраах зориулалтын 2, ус тээвэрлэгч цистерн нэгтэйгээр аймгийн Цагдан сэргийлэх ангийн харъяанд байгуулагдаж даргаар нь Ц.Дашзэвэг томилогдон ажиллажээ.

Засгийн газрын 1991 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 90 дүгээр тогтоолоор аймгийн Цагдаагийн хэлтсийн харъяалалаас гарган аймгийн АДХГЗ-ны дэргэдэх Гал түймэртэй тэмцэх алба болгон зохион байгуулсан бөгөөд 2001 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн аймгийн Засаг даргын 214 тоот захирамжаар Гал түймэртэй тэмцэх албыг хэлтэс болгон өргөжүүлэн зохион байгуулсан.

Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Байгалийн гамшгаас аврах салбар, Улсын нөөцийн салбаруудыг нэгтгэн Булган аймаг дахь Гамшгаас хамгаалах штаб болгон өргөжүүлж,



2005 онд Засгийн газрын тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болгон өөрчилж, 2008 онд Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар Онцгой байдлын газар болон өргөжсөн.

Өнөөдөр тус газар нь офицер 24, ахлагч 76, энгийн 10 нийт 110 алба хаагчтай, Аврах, гал унтраах 2 анги, /Булган сум, Хялганат тосгонд / Эрэн хайх, аврах салбар 1-тэй, гал унтраах тусгай зориулалтын болон шуурхай дуудлагын 18 авто машинтай. Гал түймэртэй тэмцэх алба байгуулагдсан үеэс одоог хүртэл ажиллаж байсан хамт олны дундаас хийсэн ажил, байгуулсан гавьяаг нь төрөөс үнэлж төрийн дээд шагнал “Байлдааны гавьяаны улаан туг”-ийн одонгоор 1, “Цэргийн гавьяа”-ны одонгоор 4, “Алтан гадас” одонгоор 2, Хөдөлмөрийн хүндэт медаль 2, Цэргийн хүндэт медаль 16, ойн медалиудаар 90 гаруй хүн, “Онц гал сөнөөгч” энгэрийн тэмдгээр 20 алба хаагч тус тус шагнагдсан байна.

Тус газрын хамт олон нь 2005, 2006, 2008 онуудад ажлаараа улсын хэмжээнд тэргүүлж “Тэргүүний хамт олон”, 2009 онд Онцгой байдлын албаны “Шилдэгийг шилдэг” хамт олон, 2010 онд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болзолт уралдаанд тэргүүлж “Тэргүүний хамт олон”-оор шалгарч фургон авто машинаар шагнуулсан ажилсаг эвсэг хамт олон юм.

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 236-р тогтоолоор НАХЯ-ны харьяа Говь-Алтай аймгийн НАХХ-ийн харьяалалын мэдэлд байгуулагдах шийдвэр гарч 1977 оны 07-р сарын 06-нд Говь-Алтай аймгийн даргын тушаалаар байгуулагдан 1977 оны 08-р сарын 01-ний өдрөөс эхлэн 25 хүний бүрэлдэхүүнтэй, гал унтраах зориулалтын авто насос 2, ус тээвэрлэгч авто цистерн 1, нийт 3 нэгж техниктэйгээр гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх, гарсан гал түймрийг унтраах үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна. 1977 оны 10-р сард тус аймгийн Нефть хангамжийн баазын дэргэд галын гэрээт пост байгуулагдаж бүтэц зохион байгуулалт нь өргөжиж эхэлсэн билээ.

1991 оны 3-р сарын 15-ны өдрийн Засгийн Газрын 90-р тогтоолоор Гал командыг Цагдаагийн хэлтсийн харьяаллаас гаргаж бие даалган үйл ажиллагаа явуулах шийдвэр гарч 1991 оны 10-р сарын 04-ны өдрийн 124 тоот аймгийн АДХГЗ-ны тогтоолоор Гал командыг Гал түймэртэй тэмцэх алба болгон ГТТА-ны дэргэд 2-р зэрэглэлийн Гал унтраах 59-р анги байгуулагджээ. Аймгийн Засаг даргын 1999 оны 11-р сарын 30-ны өдрийн



180 тоот захирамжаар Гал түймэртэй тэмцэх албыг одоо байгаа орон тоонд нь зохицуулан Гал түймэртэй тэмцэх хэлтэс болгон өөрчилсөн байна. Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 2-р сарын 27-ны өдрийн 51-р тогтоолоор нөөцийн салбаруудыг нэгтгэн Гамшгаас хамгаалах штаб болгосноор бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн байна. Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 48-р тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг Онцгой байдлын ерөнхий газар болгосонтой холбогдуулан Говь-Алтай аймаг дахь Гамшгаас хамгаалах штабыг Онцгой байдлын хэлтэс болгон өөрчилж хуучин ажиллаж байсан бүрэлдэхүүнийг эгүүлэн томилж ажил үйлчилгээг нь үргэлжүүлэн явуулсан байна.

Тус хэлтсийн даргаар 1991-2009 онд онцгой байдлын хурандаа М.Содномжамц, 2009-2011 онд онцгой байдлын дэд хурандаа Г.Нэргүй, 2011-2014 онд онцгой байдлын дэд хурандаа С.Пүрэвсамдан, 2014 оноос онцгой байдлын хурандаа Г.Чулуунбаатар нар томилогдон ажиллаж байна.

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Онцгой байдлын хэлтэс нь анх 1991 онд Чойр хотын гал унтраах анги, 1992 онд Говьсүмбэр аймгийн Гал түймэртэй тэмцэх алба, 2003 онд Говьсүмбэр аймгийн Гамшгаас хамгаалах штаб, Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоол, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2005 оны 24-р тушаалаар аймаг, нийслэл, дүүрэгт Онцгой байдлын газар, хэлтэс зохион байгуулагдсантай холбогдуулан тус аймагт Онцгой байдлын хэлтэс байгуулагдсан. Тус хэлтэс Урьдчилан сэргийлэх хяналтын тасаг, Аврах гал унтраах 37 дугаар анги, Аврах бүлэг гэсэн нэгжтэй, гал унтраах автомашин 3, шуурхай бүлгийн автомашин 2, Дуудлагын автомашин 2, тусгай зориулалтын автомашин 1 ажил үүргээ гүйцэтгэж байна.

Манай хамт олон нь 2007 онд Сүмбэр сумын “Тэргүүний хамт олон”, 2009 онд аймгийн “Тэргүүний хамт олон”-оор шалгарч байсан. Мөн манай хамт олон дотор онцгой байдлын албаны нэр хүндийг олон улсын болон Монгол улс, аймаг орон нутгийн хэмжээнд өндрөөр өргөж яваа, ахлах ахлагч Д.Ариунжаргал хөнгөн атлетикийн олон улсын хэмжээний мастер, Ази тивийн марафон гүйлтийн аварга болж байлаа. Тэрээр 2013



онд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн тусгай албадын дунд зохиогддог “Марш тактик тусгай бэлтгэл”-ийн тэмцээнд амжилттай оролцож 2 дугаар байр эзэлсэн. Аймгийн “Хүндэт дэвтэр”-г нэрээ мөнхжүүлсэн бөгөөд эдүгээ энхийг сахиулах үйлсэд албаа төлөөлөн оролцож байгаа, Ахлах ахлагч Д.Жамбалсүрэн 2012 онд ОБЕГ-ын хэмжээнд “Шилдгийн шилдэг” аврагч, Ахлах ахлагч Н.Ганбаяр аймгийн 2010 онд “Лидер залуу”, Сүмбэр сумын “Онцлох хүн”-ээр, 2011 онд Зүүн бүсийн “Шонхор клубын шилдэг тамирчин”, Дэлхийн аварга шалгаруулах Гал унтраах техникийн олон төрөлт спортын тэмцээнд 2012, 2013 онуудад шалгарч амжилттай оролцсон зэрэг ажил мэргэжил спортоор тэргүүлсэн олон залуучуудаараа бид бахархдаг.



## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Дархан хотод 1962-1963 онд, Гурил тэжээлийн үйлдвэр, Нефт бааз, Дархан, Шарын гол, Хөтөл, Эрхэтийн гал командууд, Цахилгаан станц, Цементийн завод, Хөгжимт драмын театр, Шарын голын шатах тослох материалын агуулах галын постууд байгуулагдсан үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Дээрх гал командууд галын постуудыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор НАХЯ-ны сайдын тушаалаар 1981 оны 08 дугаар сард Дархан хотын галын аюулаас урьдчилан сэргийлэх тасаг нэртэйгээр Цагдан сэргийлэх хэлтсийн харьяанд байгуулагдаж анхны даргаар дэд хурандаа Осорын Жанцан томилогдож байсан.

-1988 онд Галын аюулаас хамгаалах алба

-1991 онд Монгол улсын Засгийн газрын 90 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх алба

-1993 онд Дархан хотын АДХГЗ-ны 15 дугаар тогтоолоор хөдөө орон нутагт анх удаа Гал түймэртэй тэмцэх хэлтэс болон байгуулагдсан.

-2004 онд Засгийн газрын 51 дүгээр тогтоолыг үндэслэн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2004 оны



96 дугаар захирамжаар Гамшгаас хамгаалах штаб,

-2005 оноос Засгийн газрын 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс

-2008 оноос Онцгой байдлын газар болон өргөжсөн.

Онцгой байдлын газар нь 2013 онд батлагдсан орон тоогоор нийт 166 нэгжтэй, энгийн 4, офицер 31, ахлагч 130 ажиллаж байгааг, боловсролын зэргээр ангилвал магистр 5, бакалавр 23, дипломын дээд буюу тусгай дунд 15, бүрэн дунд 118 албан хаагчтай Дархан-Уул аймгийн хэмжээнд ажил үүргээ нэр төртэй гүйцэтгэж байна.

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1968 оны 5-р сарын 23-ны өдрийн 168-р тогтоолоор 1 дүгээр сарын 06-нд Дорноговь аймгийн Сайншанд хотод Гал команд байгуулагдан өдгөө 44 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Засгийн Газрын 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Гал Түймэртэй тэмцэх алба, 1999 онд Засаг даргын захирамжаар Гал түймэртэй тэмцэх хэлтэс болон өргөжсөн. 2003 онд Гамшгаас хамгаалах штаб байгуулан, 2005 онд Монгол Улсын Засгийн Газрын 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болгосон.

Тус хэлтэс нь төрийн тусгай албан хаагчийн 167 хүний орон тоотойгоор гал унтраах зориулалтын 10 бусад зориулалтын 10 нийт 20 автомашинтай үйл ажиллагааг явуулж байна.

“Шинэ Дорноговь-2” аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөтөлбөр, Аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний дагуу хамтын ажиллагаатай Япон улсын “ШИЗОУКА”-мужаас Гал унтраах зориулалтын нийт 4 автомашиныг 2014 оны 2 дугаар улиралд хүлээн аван ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 322 дугаар тогтоолоор Замын-Үүд, Айраг суманд Аврах,



гал унтраах 2-р зэрэглэлийн 17, 23-р анги шинээр байгуулах шийдвэр гарч 2012 онд ашиглалтанд орж үйл ажиллагаагаа эхлээд байна.

Мөн Сайншанд, Айраг суманд байрлах Улсын нөөцийн салбарууд нь 37 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.



## ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Дорнод аймгийн Онцгой байдлын хэлтэс нь Монгол улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоол, тухайн үеийн нэрээр ГХЕГазрын даргын 2004 оны 73 дугаар тушаалаар аймгийн Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Аврах отряд, Улсын нөөцийн салбарыг нэгтгэн Гамшгаас хамгаалах штаб, нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоол, ОБЕГ-ын даргын 46 дугаар тушаалаар 2005 оны 3 дугаар сараас Онцгой байдлын хэлтэс болсон. Тус хэлтэс нь Эрэн хайх аврах салбар, Аврах гал унтраах 52 дугаар анги, Улсын Нөөцийн салбар гэсэн үндсэн нэгжүүдтэй үйл ажиллагаа явуулж байна. Алс Дорнодод олон улсын байдал хурцдаж милитарист Японы зүгээс БНМАУ-д халдан довтлох аюул улам бүр өсөн нэмэгдэж байсан 1938 оны эцсээр ДЯЯ-ны сайдын тушаалаар Баянтүмэн хотод “Монгол тээхийн галын пост”-ыг Лувсандамба гэдэг бага даргатай 12 гал сөнөөгчтэй байгуулсан нь манай гал командын эх суурь нь тавигдсан түүхтэй. 1939 оны 5-р сард ДЯЯ-ны шийдвэрээр уг постыг татан буулгаж, Гал команд нэртэй өөрчилж 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Дайны үе тул БАЯНТҮМЭН хот байнгын түгшүүртэй, Японы бөмбөгөнд өртөж гал гарах нь цөөнгүй байсан учир Гал командын бие бүрэлдэхүүн үргэлж байлдааны бэлэн байдалд ажиллаж гарсан галыг түргэн шуурхай унтрааж байлаа. 1961 онд ЗИЛ-164 маркийн ПМЗ-17 автоцистерн 2, ус тээвэрлэгч 2-той 1973 он хүртэл ажиллаж байгаад гал унтраах 52 дугаар анги болсон. Аврах



Гал унтраах 52-р анги нь ОХУ-д үйлдвэрлэсэн ЗИЛ 130, ЗИЛ-131 маркийн гал унтраах тоног төхөөрөмж бүхий үндсэн албаны 2, туслах зориулалтын 2, шуурхай албаны 1 нийт 5 автомашинтай, салаан захирагч 4, гал унтраах авто машины жолооч 16, аврагч-гал сөнөөгч 32, дуудлага хүлээн авагч 4 гээд нийт 57 албан хаагчтайгаар ажиллаж байна. 2004 онд Засгийн газрын 51-р тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрын Дорнод аймгийн гамшгаас хамгаалах штабын Аврах отряд болон зохион байгуулагдаж д/х Ө. Хүрэлбаатар даргатайгаар ГАЗ-66 машин 1, УАЗ-2207 машин-1, 24 албан хаагчтайгаар үүрэг гүйцэтгэж ирсэн. 2011 оноос Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх аврах салбар болон өөрчлөгдөж үйл ажиллагаа явуулж байна.

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын зөвлөлийн 1977 оны 644-р тогтоол, Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1977 оны 8-р сарын 01-ний өдрийн 143-р тушаалаар “ Гал команд” нэртэйгээр офицер 2, ахлагч 28, бүгд 30 хүний орон тоотой ЗИЛ-130 /АЦ-40У/ гал унтраах үндсэн албаны автомашин 2, ус тээвэрлэгч ЗИЛ-130 автомашинтай аймгийн төв Мандалговь хотод анх байгуулагдсан. Анхны даргаар хошууч Дагдангийн Содном ажиллаж байсан.

БНМАУ-ын Засгийн Газрын 1991 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоол, аймгийн АДХГЗ-ны даргын 1991 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 25 дугаар захирамжаар Гал түймэртэй тэмцэх алба, Монгол Улсын Засгийн Газрын 2004 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах штаб, 2005 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болон ажиллаж байна.

Онцгой байдлын хэлтэс нь аврах, гал унтраах анги, нөөцийн салбартайгаар төрийн тусгай 47, энгийн 2, нийт 49 албан хаагч, аврах, гал унтраах шуурхай 9 машин бусад багаж хэрэгсэлтэй ажил үүргээ гүйцэтгэж байна. 2011 оны 12-р сараас хурандаа Я.Алтанхундага тус хэлтсийн даргаар томилогдон ажиллаж байна. 2010 оны 9-р сард тус хэлтэс шинэ байранд орж үйл ажиллагаагаа явуулж ирэв.





## ЗАВХАН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Завхан аймгийн Онцгой байдлын хэлтэс нь ОБЕГ-ын даргын 2003 оны 06 сарын 07-ны өдрийн Б/438 дугаар тушаалаар төрийн тусгай 87 албан хаагч, 3 гэрээт албан хаагчийн бүрэлдхүүнтэй зохион байгуулагдаж, ажил үүргээ гүйцэтгэж байна.

Тус хэлтэс нь 2-р зэрэглэлийн Аврах гал унтраах 43-р анги, 3-р зэрэглэлийн Аврах гал унтраах 39-р анги, Улиастай, Тосонцэнгэл, Завханмандал, Тэс, Шилүүстэй, Сонгино сумдад Улсын нөөцийн салбар ажиллаж байна.

Албан хаагчдын 28% дээд, 3% тусгай дунд, 56% бүрэн дунд боловсролтой, нийт бие бүрэлдхүүний 87% эрэгтэй, 13% эмэгтэй, 20-30 настай 23%, 30-40 настай 42%, 40 дээш настай 35% байна.

Аврах гал унтраах 43-р анги авто насос 2, ус тээвэрлэгч 1, 39-р ангид авто насос 1, ус тээвэрлэгч 1, шуурхай албаны 3 автомашин, Ландкрузер 100 -1, туулах чадвар бүхий СЕЁ 131 автомашин 2, Газ 66 -1, Газ 53 -1, СЕЁ-1 гээд нийтдээ 14 нэгж техниктэй байна. Мөн сансарын холбооны иридиум утас 2, гар сантц 14, GPS 4 болон завь, задаргааны багаж, хамгаалалтын хувцас зэрэг багаж зэвсэглэлтэй ажил үүргээ гүйцэтгэж байна.



## ОРХОН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

1976 оны 06 дугаар сарын 21-нд Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 39 тоот тушаалаар “Гал команд” нэртэйгээр анх байгуулагдсан

1991 оны 04 дүгээр сарын 21-нд Эрдэнэт хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны 77 тоот тогтоолоор Гал түймэртэй тэмцэх алба 1993 оны 11 дүгээр сарын 18-нд Эрдэнэт хотын 123 тоот тогтоолоор Гал түймэртэй тэмцэх хэлтэс 2004 оны 03 дугаар сарын 25-ний өдрийн Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 109 тоот тушаалаар Гамшгаас хамгаалах штаб 2005 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Онцгой байдлын ерөнхий



газрын даргын 53 тоот тушаалаар Онцгой байдлын хэлтэс 2008 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 282 тоот тушаалаар Онцгой байдлын газар болон өргөтгөсөн.

I зэргийн гал унтраах 56 дугаар анги -79, II зэргийн гэрээт гал унтраах 58 дугаар анги - 58, III зэргийн гал унтраах 81 дүгээр анги-34, Улсын нөөцийн салбар -8 “Эрдэнэт” дулааны цахилгаан станцын байцаагч гээд нийт 198 бүрэлдэхүүнтэйгээр ажил үүргээ гүйцэтгэж байна. Гал унтраах 56 дугаар анги 1976 онд “Мед Молибдени Стройни”, Барилгын удирдах газрын гэрээт анги нэртэйгээр байгуулагдсан. Гал унтраах 58 дугаар анги нь 1978 онд байгуулагдсан. Гал унтраах 81 дүгээр анги нь 2006 онд шинээр байгуулагдан Монгол улсын “Гал унтраах ангийн зэрэглэл, галын автомашины тоо” MNS:5108:2001 стандартын дагуу гал унтраах ангийн 3 дугаар зэрэглэлтэйгээр ажиллаж байна. Улсын нөөцийн газрын харьяа Орхон аймаг дахь Улсын нөөцийн салбар 1997 оны 06 дугаар сарын 01-ний өдөр анх байгуулагдан ажиллаж эхэлсэн. Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрын харьяа Орхон аймаг дахь Улсын нөөцийн салбар болон ажиллаж байна.

Эрдэнэт ДЦС-ТӨХК-ны гэрээт галын хэсэг 1987 онд байгуулагдан 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаад 2004 оноос гэрээт байцаагчтай үүрэг гүйцэтгэж байна.

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар нь гал унтраах 2 ангитай, Хархорин, Сант, Нарийнтээл суманд улсын нөөцийн салбартай. Хархорин сумын гал унтраах 45 дугаар анги нь БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 148, 157 дугаар тогтоол, Хөдөлмөр цалин хөлсний улсын хорооны 1972 оны 101 дүгээр тогтоол гарч НАХЯ-ны сайдын 1972 оны 534 дүгээр тушаалаар Хархорин суманд 2 гэртэй анх байгуулагдсан. 1974 онд сум, сангийн аж ахуйн авто гражийн нэг хэсгийг НАХЯ-ны үйлчилгээ аж ахуйн газрын хүсэлтээр одоогийн байрлаж байгаа объектод гал унтраах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 2 ширхэг АЦ-40 130-63А маркийн автоцестернтэйгээр шилжин орж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Гал унтраах 12 дугаар ангийг өөрчлөн нь 1975 онд БНМАУ-ын СнЗ-ийн 464 дүгээр тогтоолоор Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод гал команд болгон байгуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ тогтоолыг



хэрэгжүүлэх зорилгоор анх 1977 оны 09 дүгээр сарын 01-нд гал унтраах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон АЦ-40 130-63А маркийн автоцестерн 2-тойгоор гал команд байгуулагдаж УАА-н ТМС /хуучин нэрээр/-ийн гражийг түшиглэн уг гражид машинаа байрлуулан харуул ээлжийн бие бүрэлдэхүүн гэрт байрлаж харуулын үүрэг гүйцэтгэж эхэлжээ.

1991 онд гал унтраах 12. 45 дугаар ангиуд НАХХ-ээс салж бие даан Гал түймэртэй тэмцэх алба болж, галын аюулгүй байдлын тухай хууль, УИХ-ын 1999 оны 5 дугаар сарын 28-ний өдрийн 40 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2000 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 28 дугаар захирамжаар Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Монгол улсын Засгийн газрын 2004 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах штаб болон аймгийн Цэрэг иргэний хамгаалалтын штабын иргэний хамгаалалт, Гал түймэртэй тэмцэх хэлтэс, Хархорин, Сант суман дахь Улсын нөөцийн салбарууд нэгдэн өргөжсөн. ОБЕГ-ын даргын 2011 оны 3 дугаар сарын 30-ний өдрийн 160 тоот тушаалаар тус хэлтэс нь Онцгой Байдлын Газар болон өргөжин үйл ажиллагаагаа явуулж байна.

Онцгой байдлын газар, гал унтраах 12, 45 дугаар анги, Хархорин, Сант суманд улсын нөөцийн салбар, Нарийнтээл суманд улсын нөөцийн цэгт нийт 96 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Онцгой байдлын хэлтэс нь 2004 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор хэлтэс, Гал унтраах 21 дүгээр анги, Улсын нөөцийн салбар гэсэн нэгжийн бүрэлдэхүүнтэй, 88,4 хувийн нөхөн хангалттайгаар алба үйл ажиллагаагаа явуулж байна.

Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 700 гаруй аж ахуй нэгж, ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 20 гаруй уул уурхайн компаниудад Монгол улсын “Гамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай” хууль, тогтоомж, дүрэм, стандартын хэрэгжилтэд хяналт тавин, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажиллаж



байна.

Улсын нөөцийн салбар нь нөөцийн бараа, материалыг 3 цэгт байршуулан, Монгол Улсын Засгийн газраас тогтоосон нэр төрөл тоо хэмжээнд чанар стандартыг алдагдуулалгүй хадгалж хамгаалах, сэлгэн шинэчлэх, нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 34.700,0 мянган төгрөгөөр говийн бүсийн спорт сургалтын цогцолбор, сэтгэл зүйн зурвасыг бусад газар хэлтсүүдэд жишиг болохуйцаар барьж байгуулсан. Мөн газар хөдлөлт болон техник, технологийн холбогдолтой ослын аврах ажиллагааны үед ашиглах 2010 оны дэвшилтэт технологиор Голланд улсад үйлдвэрлэгдсэн Холматро үйлдвэрийн багаж, мөн Герман улсад үйлдвэрлэгдсэн өндөр даралтын Импульсэн буу нийт 71,2 сая төгрөгийн багаж зэвсэглэмжийг авч албандаа ашиглаж байна.



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

1934 оны 8 дугаар сарын 22-нд Ерөнхий сайдын 17 дугаар тушаалд зааснаар Сэлэнгэ аймагт Дотоодын хамгаалах ангийн дэргэд 5 хүнтэй галын аюулаас хамгаалах комисс байгуулсан нь эдүгээ Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын хөгжлийн үндэс суурь тавигджээ. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд агентлаг хэлбэрээр Гамшгаас хамгаалах штаб болон зохион байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулсан. 2005 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болон өөрчлөгдсөн. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/578 дугаар тушаалаар Онцгой байдлын газар болон өргөжин ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар нь аймгийн хэмжээнд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумдад байрлах Аврах, гал унтраах 4 анги, Эрэн хайх, аврах салбар, Мандал, Баянгол, Орхонтуул сумдад байрлах Улсын нөөцийн 3 салбартайгаар, гал унтраах зориулалтын 10, тусгай зориулалтын 8, шүүрхай албаны



6 автомашин, туслах албаны 5 автомашин, 231 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна

Тус хамт олноос сүүлийн 10 жилийн хугацаанд “Цэргийн гавьяаны одон”-гоор 3, “Цэргийн хүндэт медаль”-аар 6, “Онцгой байдлын албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр 5, “Онц гал сөнөөгч” тэмдгээр 6, Онцгой байдлын байгууллагын тэргүүний албан хаагчаар 3 албан хаагч тус тус шагнагдсан байна.



## СҮХБААТАР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

БНМАУ-ын СнЗ-ийн 1972 оны 266 дугаар тогтоолоор Сүхбаатар аймагт Гал команд байгуулахыг НАХЯ-нд зөвшөөрсөнөөр тус аймагт анх гал команд үүссэн түүхтэй. Мөн ондоо Аймгийн АДХГЗ-ны 51 дүгээр тогтоолоор аймгийн барилга угсралтын конторын автомашины граж, эрчим хүчний үйлдвэрийн 2 айлын орон сууцны модон барилга зэргийг шинээр байгуулагдсан гал командад шилжүүлэн өгсөнөөр НАХХ-ийн дэргэд Баруун-Урт хотын гал команд нэртэйгээр анх байгуулагдсан.

1991 оны Засгийн газрын 90-р тогтоолоор Гал түймэртэй тэмцэх алба, Сүхбаатар аймгийн Засаг дарга, ИТХ-ын саналыг үндэслэн ГТТГ-ын даргын тушаалаар 2000 онд Гал түймэртэй тэмцэх хэлтэс болон өргөжсөн бөгөөд 2003 оны 09 дүгээр сарын 01-нд Галын депогийн иж бүрэн цогцолбор барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор ГТТГ, УИХГ, УНГ-уудыг нэгтгэн Онцгой байдлын алба болгон нэгтгэсэн. Монгол улсын Засгийн газрын 2004 оны 51-р тогтоолоор “Гамшгаас хамгаалах штаб”, Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор “Онцгой байдлын хэлтэс” гэсэн байгууллагын нэр хаягийг өөрчлөн хэлтэс, гал унтраах анги, аврах бүлэгтэйгээр үйл ажиллагаагаа амжилттай гүйцэтгэж ирсэн байна.

НАХЯ-ны 1-р орлогч сайдын тушаалаар 1972 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр тус байгууллагын анхны даргаар хошууч Н.Жарантай нь томилогдон ажиллаж байсан бөгөөд түүхэн 42 жилийн хугацаа өнгөрч нийт 9 дарга тус байгууллагыг удирдан ажилласан байна.

Түмэнцогт суман дахь Улсын нөөцийн салбар нь анх 2000 онд зүүн гурван аймгийг өвс, тэжээлээр хангах зориулалттайгаар байршлын хувьд дундаж газар гэж тооцон Түмэнцогт сумын төвд гурван хүний



бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан. Өнөөдөр 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

## ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Төв аймгийн Онцгой байдлын газар нь 1958 онд Төв аймгийн Цагдан сэргийлэх хэлтсийн харъяанд гал хариуцсан 2 байцаагчтайгаар ажиллаж эхэлснээр үүсэн байгуулагдсан.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1973 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 464 тоот тогтоолоор 3 аймагт гал унтраах анги байгуулахаар шийдвэрлэхэд Төв аймаг орсон байна.

Ингээд 1976 оны 09 дүгээр сард НАХЯ-ны сайдын 236 тоот тушаалаар Зуунмод хотод Гал унтраах ангийг Цагдан сэргийлэх хэлтсийн харъяанд байгуулж 1991 он хүртэл ажилласан. БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Төв аймагт Гал түймэртэй тэмцэх алба байгуулан аймаг, хотын АДХГЗахиргаанд харъяалуулахаар шийдвэр гаргасны дагуу Төв аймгийн Засаг даргын 1991 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 65 тоот захирамжаар Цагдаагийн хэлтсээс галын албыг аймгийн нутаг дэвсгэрт галын аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан галыг унтраах, хэрэг бүртгэлт явуулах үндсэн чиг үүрэгтэйгээр Цагдаагийн ерөнхий газрын харъяа, Гал түймэртэй тэмцэх алба болгон өргөжүүлсэн 1999 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн Төв аймгийн Засаг даргын 165 тоот захирамжаар Гал түймэртэй тэмцэх хэлтэс болон зохион байгуулагдсан байна. 2004 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор Гал түймэртэй тэмцэх хэлтэс нь Байгалийн гамшгаас хамгаалах аврах салбартай нэгдэн 2005 оны 03 дугаар сарын



31-ны өдөр Засгийн газрын 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс, 2008 оны 4 дүгээр сард Онцгой байдлын газар болон өргөжсөн. Эдүгээ 62 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хамт олон нь Онцгой байдлын ерөнхий газрын хэмжээнд 2007 онд Тэргүүн байр, аймгийн агентлагуудаас оны ажлаараа 2005, 2007, 2008, онуудад Тэргүүн байр, 2010 онд дэд байранд шалгарч байсан хамт олон юм.

## УВС АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор аймаг, нийслэлийн Гамшгаас хамгаалах штаб байгуулагдаж, 2005 оны 3 дугаар сараас аймаг, нийслэлд Онцгой байдлын газар, хэлтэс зохион байгуулагдсан. Увс аймгийн Онцгой байдлын хэлтэс нь Аврах, гал унтраах 41 дүгээр анги, Улаангом, Баруунтуруун сум дахь Улсын нөөцийн салбар гэсэн бүтцээр ажиллаж байна.

Онцгой байдлын хэлтсийн бүтэц орон тоо нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/377 дугаар тушаалаар 52 төрийн тусгай албан хаагч, 5 гэрээт албан хаагчийн орон тоотойгоор батлагдсан.

Онцгой байдлын хэлтэс нь Урьдчилан сэргийлэх хяналтын тасаг, Аврах гал унтраах 41 дүгээр анги /3 дугаар зэрэглэл/, эрэн хайх, аврах бүлэг гэсэн нэгжтэй. Хэлтэс нь 9 албан хаагч, **Урьдчилан сэргийлэх хяналтын тасаг** нь 4 албан хаагч, **Аврах, гал унтраах 41** дүгээр анги нь 33 албан хаагч, **Эрэн хайх**, аврах бүлэг нь 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдрийн байдлаар Онцгой байдлын хэлтэст 15 офицер, 35 ахлагч, 3 энгийн, нийт 53 албан хаагч ажиллаж байна.

Тус аймгийн Онцгой байдлын хэлтсийн Аврах, гал унтраах 41 дүгээр анги нь /хуучнаар/ БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор Увс аймгийн Улаангом



хотын Гал командыг 1969 оны 8 дугаар сарын 10-нд ПМЗ-63А маркийн хөөрөг бүхий авто насос, гурван ээлжийн зохион байгуулалттайгаар байгуулагдаж байжээ.

1969 онд Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын тушаалаар ЗХУ-д галын техникийн дунд сургууль төгссөн ахлах дэслэгч Д.Цоодолыг Увс аймгийн Улаангом хот дахь Гал командын анхны даргаар томилсон байна. Онцгой байдлын хэлтэс нь ОХУ-ын Тува Улсын Иргэний хамгаалалт, Онцгой байдлын ерөнхий газартай харилцаа тогтоож хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.



## ХОВД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Ховд аймгийн Онцгой байдлын газар нь 2004 онд Монгол улсын Засгийн газрын 51 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах штаб, 2005 онд Монгол улсын Засгийн газрын 48 дүгээр тогтоолоор Онцгой байдлын хэлтэс, 2011 онд Онцгой байдлын газар болон өргөтгөн зохион байгуулагдаж, 2012 онд Аврах гал унтраах 38 дугаар ангийг Булган суманд байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус газар нь Эрэн хайх, аврах салбар, Аврах гал унтраах 38,48 дугаар анги, Улсын Нөөцийн салбар гэсэн 3 нэгж, 125 хүний бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр Ховд аймгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, тэмцэх ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Эрэн хайх, аврах салбар нь 1998 онд, Аврах, Гал унтраах 48-р анги нь 1969 онд, Аврах гал унтраах 38 дугаар



анги нь 2012 онд Булган, Алтай, Үенч сумдад байгуулагдаж байсан.

Улсын нөөцийн салбар нь 2001 онд байгуулагдаж, Монгол улсын Засгийн газрын 2008 оны 249 дүгээр тогтоолоор баглагдсан нормативын дагуу хүнсний 8 нэр төрлийн бараа, өвс, тэжээл, шатахуун хадгалж байна. Тус газарт цэргийн шинжлэх ухааны магистр 1, бизнесийн удирдлагын магистр 1, төрийн удирдлагын менежер 4, баклавар 27, дээд 1, тусгай дунд 18, бүрэн дунд боловсролтой 55 албан хаагч ажил үүргээ гүйцэтгэж байна. Албан хаагчдын 67 % нь 21 – 40 насны, 33 хувь нь 41 – 59 насны, 38 % нь 1 – 5 жил, 25 % нь 5-10, 29 % нь 10-20 жил, 9 % нь 20 – 25 жил ажилласан албан хаагчид байна.

Тус хамт олны дундаас Олон улсын Иргэний хамгаалалтын баатар цол, тэмдэгээр 1, Цэргийн гавьяаны одонгоор 1, Цэргийн хүндэт медалиар 6, хөдөлмөрийн хүндэт медалиар 4, шударга журам медалиар 1 албан хаагч тус тус шагнагдаж, Онцгой байдлын албаны Тэргүүний ажилтан 2, Онц гал сөнөөгч 2, гал унтраах техникийн олон төрөлт спортын дэд мастер 4 ажиллаж байна.



## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС

Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолын дагуу Гамшгаас хамгаалах штаб, Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор Онцгой байдлын хэлтэс болгон өргөжүүлж одоо тус хэлтэс нь Аврах, гал унтраах 27 дугаар анги, Эрэн хайх, аврах салбар, Улсын нөөцийн салбартайгаар төрийн тусгай 90 албан хаагч, энгийн 7, нийт 97 албан хаагчтай, гал унтраах болон шуурхай дуудлагын нийт 8 автомашинтай, аврах багаж хэрэгсэлтэйгээр ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Хатгал хотод 1934 онд 10 хүний бүрэлдэхүүнтэй гал эсэргүүцэх гэрээт пост



нэртэйгээр Хөвсгөл аймгийн галын байгууллага анх үүсэн байгуулагдаж, 1955 онд Хатгал хотын дамжлага баазын дэргэд гэрээт гал команд 24 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан нь аймгуудын хэмжээнд анхны гал команд болсон түүхтэй.

1970 оноос Хатгал дамжлага бааз, нефть хангамжийн баазын гэрээгээр Ханх нефть баазын галын пост шинээр байгуулагдсан. 1978 оны 9 дүгээр сард Ханх нефть баазын галын постыг өргөжүүлж техникжсэн галын салаа байгуулж Мөрөн нефть баазын гэрээт гал команд болж өргөжин 1989 онд 30 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаад 1994 онд Мөрөн нефть 62 дугаар гал унтраах анги татан буугдахад Хөвсгөл аймгийн Мөрөн хотын гал команд 24 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан билээ.

Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх аврах салбар нь анх 1969 онд тухайн үеийн нэрээр ой модны аж үйлдвэрийн яамны харьяа түймэр эсэргүүцэх агаарын харуулын хөдөлгөөнт отряд нэртэйгээр хавар, намрын ой хээрийн түймрийн улиралд АН-2 онгоцтой ирж ажилладаг байсан. 1975 оны 3 дугаар сард 15 шүхэрчин гал сөнөөгч, 1 автомашин, түймэр унтраах төрөл бүрийн багаж хэрэгсэлтэйгээр Булган, Архангай, Завхан, Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэн унтраах чиг үүрэгтэйгээр Мөрөн хотод байнгын салбар болж байгуулагдсан байна. 2000 онд Аврах салбар болж зөвхөн гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэдэг болсон. Одоо аймгийн Онцгой байдлын хэлтсийн Эрэн хайх аврах салбар нэртэйгээр 3 офицер, 14 төрөл мэргэжлийн аврагч, 2 нэгж машинтай үйл ажиллагаагаа явуулж байна.

## ХЭНТИЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

Засгийн газрын 2004 оны 02-р сарын 27-ны өдрийн 51-р тогтоолоор тус аймгийн Улсын нөөцийн салбар, Байгалийн гамшгаас аврах салбар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн үйл ажиллагааг нэгтгэж Гамшгаас хамгаалах штаб нэртэйгээр Онцгой байдлын газар байгуулагдсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны Б/438 дугаар тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу газрын удирдлага Аврах, гал унтраах 32, 49-р анги, Эрэн хайх, аврах салбар, Улсын нөөцийн салбар гэсэн нэгжтэй, 25 офицер, 109 ахлагч, гэрээт ажилтан 5, нийт 138 албан хаагчидтай, офицерын нөхөн хангалт 81.5%, ахлагчийн нөхөн хангалт 91% үүрэг гүйцэтгэж байна.

Гамшиг осол, гал түймэртэй тэмцэх ажиллагаанд гал унтраах зориулалтын автомашин 5, шуурхай



албаны пургон 4, “Ландкрузер-1, “Ниссан сани”-1, эмнэлгийн зориулалтын “Старик”-1, нийт 12 автомашин, ой хээрийн түймэр унтраах үлээгч аппарат-18, ус шүршигч РЛО-25, аврах завь-2ш зэрэг техник, багаж зэвсэглэмжтэй үйл ажиллагаа явуулж байна. Онцгой байдлын газрын удирдлага, Аврах, гал унтраах 32 дугаар анги, Улсын нөөцийн салбар нь Хэрлэн сумын төвд 1-р багийн нутаг дэвсгэрт орших 3 давхар барилгад байрлаж байгаа бөгөөд Эрэн хайх аврах салбарын байрыг 2013 онд барьж ашиглалтанд оруулав.

Тус газраас ОБЕГ-ын “Тэргүүний ажилтан”-аар || “Онц гал сөнөөгч” тэмдгээр 6, “ Жуух бичиг”-ээр 18, ОБЕГ-ын нэрэмжит шагналаар 26| Төрийн дээд одон медалиар 10 албан хаагчид тус тус шагнагдаж, ОБЕГ-ын Хөдөлмөрийн аваргаар 6 албан хаагч шалгарсан ба 2004, 2006, 2009, 2011 онуудад аймгийн “Шилдэг төрийн байгууллагаар”, үйл ажиллагаагаараа ОБЕГ-ын хэмжээнд 2008 онд 3-р байр, 2009 онд тэргүүн байр, 2010 онд дэд байр, 2011, 2012 онуудад тэргүүн байр тус тус эзэлж байсан.



# ДУРСАМЖ ДУРДАТГАЛ



Хошууч генерал Г.МАХБАРИАД:

## ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН СУРГАЛТАНД АРД ИРГЭД ЗААВАЛ ХАМРАГДАГ БАЙЛАА

Би 1985 онд Батлан хамгаалахын орлогч сайд, Иргэний хамгаалалтын газрын даргаар томилогдсон. Тэр үед социалист орнуудад ч манай оронд ч Иргэний хамгаалалтын үйл ажиллагаанд дайны үеийн үүрэг багасаж, байгалийн, үйлдвэрлэлийн томоохон ослын хор уршгийг арилгах, хүчтэй үйлчилгээтэй хорын бодис алдагдсан тохиолдолд түүнтэй хэрхэн тэмцэх арга ажиллагаанд сургаж дадлагажуулахад голлон анхаарч ажиллаж байсан. Иргэний хамгаалалтын сургалтанд ард нийтээрээ заавал хамрагдаж 20 цагийн хичээл үздэг малчид тариаланчид, гэрийн ажилтай хүмүүст гарын авлага зөвлөмжийг судлуулдаг болсон. Үүнээс гадна оюутан сурагчдад иргэний хамгаалалтын 30-70 цагийн хичээл ордог төгсөх ангийн оюутнууд 6-7 хоног хээр гарч дадлага сургууль хийдэг байлаа.

1986 оноос жил бүр 3-4 аймагт иргэний хамгаалалтын иж бүрэн сургууль хийдэг болгосон. Энэ иж бүрэн сургуульд хамрах хүрээ, зарцуулах хөрөнгө, зохион байгуулах ажиллагааны хувьд том хэмжээний үр өгөөжтэй сургалтын хэлбэр болсон. 1987 оны 10 сард Дундговь, Дорноговь аймгийн зарим сумдыг хамарч их хэмжээний цас орж мөсөн бүрхүүл тогтсоноос 547 суурийн 800 гаруй мянган малыг нүүлгэн шилжүүлж байлаа. 1988 онд Баруунхараагийн Гурил тэжээлийн үйлдвэрт болсон дэлбэрэлт болон ой хээрийн түймэр унтраах аврах ажлуудыг удирдан зохион байгуулж байв. Иргэний хамгаалалтын газар нь өөрийн 122-р цэргийн ангиас гадна Зэвсэгт хүчний хорь шахам ангийг Иргэний хамгаалалтын томилгоотой болгож, тэр чиглэлээр сургах дадлагажуулах ажлыг зохион байгуулж хийлгэдэг байв. МХЗЭ-ийн Төв хороо, Монголын Пионерийн төв зөвлөлөөс сурагчдын дунд “Дөл” гэдэг сургалт зохион байгуулдаг. Энэ нь хүүхдүүдийг цэрэг эх орны хүмүүжилтэй иргэний хамгаалалтын анхан шатны бэлтгэлтэй болгоход ычухал ач холбогдолтой арга хэмжээ болж байв. Пионерийн зуслангууд дээр өөрсдийн санаачилгаар хүүхдүүдийн дунд цэрэг иргэний хамгаалалтын сэдэвтэй уралдаан тэмцээн тогтмол явж хэвшсэн.

Мөн Монголын Улаан загалмай нийгэмлэгтэй Ариун цэврийн нөхөрлөлийн аварга шалгаруулах тэмцээнийг үе шаттай явуулдаг. Энэ ажилд аймаг, хот, албан байгууллагын удирдлагууд их ач холбогдол өгч сайн бэлтгэдэг байлаа. Эмнэлэгийн анхны тусламжийн нөхөрлөлийн улсын тэмцээнийг зохион байгуулдаг байсан нь эмнэлэгийн анхан шатны мэдлэг олгоход их ашиг тустай байжээ.

ЗХУ-ын Иргэний хамгаалалтын дарга ЗХУ-ын маршал В.И.Чуйков, армийн генерал А.Т.Алтунин, Л.В.Говоров, ОХУ-ын Онцгой байдлын яамны сайд Армийн генерал С.К.Шойгу нар манай оронд янз бүрийн хугацаанд айлчилан төр засгийн тэргүүнтэй уулзан Монгол улсын иргэний хамгаалалтын байгууллагын байдал цаашид авах арга хэмжээ ялангуяа мэргэжлийн боловсон хүчин сургаж бэлтгэх шаардлагатай техник хэрэгслээр хангаж бэхжүүлэх талаар ихээхэн арга хэмжээ авсан юм.



## Хошууч генерал Г.ДАМДИНСҮРЭН: ХОРВОО ГЭДЭГ ХАТУУ ҮЕДЭЭ МӨН Ч ХАТУУ



Г.Дамдинсүрэн гуай сэрүүн тунгалаг ахуйдаа өөрийн туулж ирсэн ажил амьдралын тухай “Генерал” нэртэй дурсамжийн номоо бичиж хэвлүүлсэн нь хувь ганц хүний түүх төдийгүй Монгол улсын Зэвсэгт хүчний нэгэн үеийн түүхийг харуулсан ном болжээ. Түүний Улсын иргэний хамгаалалтын даргаар ажиллаж байсан зургаан жилийн дурсамжаас түүний ар гэрийхний зөвшөөрлөөр түүвэрлэн авлаа.

Иргэний хамгаалалтын газрын даргаар ажилласан он жилүүдэд ажлын маань ихэнх хэсэг нь гамшиг осолтой тэмцэх арга хэмжээг зохион байгуулж явуулах ажилд чиглэгдэж байсан даа.

1990–ээд оны эхэн үед хэдэн жил ой хээрийн түймэр маш их гарч байлаа. 1993 он шиг санагдаж байна. Төв аймгийн нутаг Жаргалантын нурууны урд хэсэгт маш хүчтэй түймэр гарсан мэдээ бидэнд ирсэн юм. Тухайн үеийн Ерөнхийлөгч П.Очирбат түймрийн байдлыг газар дээр нь явж үзье, хамт нисье гэж байна гэв. Би нисгэгч нартаа үүрэг өгөөд байж байтал ямар нэгэн хамгаалалтгүй, гуперийн тэрэг ч үгүй Ерөнхийлөгч маань ороод ирлээ шүү. Бид экипажийнхаа хамт талбай дээр онгоцныхоо дэргэд жагсаж хүлээж аваад нислэг эхэллээ. Ямар нэгэн хэвлэл мэдээллийн хүмүүс байгаагүй, нэг л залуу дагаж явсан, бодвол туслах нь байх. Тэгээд л баахан түймэр дээгүүр ниссээр байгаад Архангайд бууж тэндээсээ шатахуунаа аваад шууд Булган аймагт буухаар нислээ. Гэтэл замд нэг бага шиг түймэр тааралдаад түүнийг хоёр морьтой хүн цохиж байгааг Ерөнхийлөгч хараад энд бууж хэдүүлээ туслая гэж байна. Нэлээд салхитай байсан ч бид буулаа. Нэг харсан чинь П.Очирбат ерөнхийлөгч маань савхин цамцаа тайлаад түймэр цохиж байсан юм. Зүй нь бид хамаагүй буух ёсгүй байсан. Тэгээд ч нисдэг тэргэн дотор төрийн тэргүүн маань явж байгаа шүү дээ. Бид тэр түймрийг унтрааж дийлэлгүй Булганд яаралтай бууж үүрэг өгч байлаа.

1993 оны нэг өдөр өрөөндөө ажлаа хийж суутал Ерөнхий сайд П.Жасрай гуай өөрөө залгаад ярьж байна. Дорнод аймгийн засаг дарга А.Батсүх яриад байна. Буйр нуурт хэдэн залуус машинтайгаа цөмрөөд осолдсоныг гаргаж авах талаар тусламж хүсч байна. Мэргэжлийн байгууллагын хувьд та нар арга хэмжээ авч үз гэв. Би ч мэдлээ даргаа, бид зохион байгуулаад танд илтгэе гэлээ. Тэр гүнзгий нуурын гүнээс осолдсон хүмүүсийг яаж гаргах талаар бодоход энэ талын мэргэжлийн хүн, мөн зориулалтын хувцас, баг гээд шаардлагатай зүйл байхгүй байлаа. Тэр үед манайд зөвхөн хорт утааны баг л байсан байх. Хэсэг бодож байгаад “ах нараасаа л” тусламж хүсэхээр шийдэв. Өөр арга байсангүй. Урд жил нь Германаас буцаж явах замдаа ОХУ-ын ОБЯ-ны сайд армийн генерал С.К.Шойгутай уулзаж байсан болохоор шууд л мань хүнтэй ярьж яаралтай тусламж хүсэхээр шийдлээ дээ. Тэр даруйдаа Шойгу сайдтай утсаар холбогдвол маш шуурхай дор нь хүлээж аваад тэгэлгүй яахав би одоохон Алс дорнодын төвийн командлалдаа үүрэг өгье цаашдаа асуудал гарвал хэзээ ч хамаагүй ярьж байгаарай гээд миний хүсэлтийг маш сайхан хүлээж авсан юм. Хожим тэрбээр Сүндэв генералын урилгаар манай улсад албан ёсны айлчлал хийж олон чухал асуудлыг шийдэж өгч байсан, Монгол улсад элэгтэй, найрсаг хүн байсан юм. С.К. Шойгу сайдтай ярьсан тэр өдөр л манай газрын опертивын жижүүр дээр дуудлага ирж намайг Чита мужаас ярья гэхээр нь утсаа автал урдаас генерал В.Лящинко байна, би төвөөс үүрэг аваад гурван машинтай командынхаа бүрэлдхүүнтэйгээр танай хил рүү гарах гэж байна. Хэнтий аймгийн төвөөр дайраад Дорнод руу явна. Та хилээр орох зөвшөөрөл, тосож авах газарчингаа яаралтай явуулвал сайн байна гэдэг юм байна. Мөн өөрөө маргааш нисдэг тэрэгтэй Улаанбаатарт бууна. Тэгээд тантай хамт Дорнод явъя гэхэд нь тэгье гэж тохиролцлоо. Бүх зүйлийг ярьсан ёсоор болгож, Орос нөхөд маань ирэх очих шатахуун, хоол хүнс бүх бэлтгэлээ өөрсдөө зохион байгуулсан байлаа. Бид шууд нууран дээрээ цуглараад ажилдаа орлоо. Буйрын мөсөн дээр Лящинко генерал бид хоёроос гадна тавь гаруй насны, мэргэжлийн нэг аврагч, түүний бэлтгэл ажилд нь туслах гурван аврагчтайгаар ажиллагаагаа эхэллээ. Туслагчид мөсөн дээр дулаацах жижиг майхан

барьж, ус руу өмсч орох аврагчийн бүх өмсгөлийг нь өмсгөж өгөв. Бусад хүмүүс нуурын эрэг дээр хүлээж байлаа. Аврагч маань өмсгөлөө өмсөж ус руу ороод байдлыг газар дээр нь үзээд гарч ирэв. Үрэгдсэн улс бүгд машин дотор байна, нэг нь гараа юмаар оосорлоод гаднах толиноосоо уясан байна, бүгд дөрвөн хүн байсан



байна гэлээ. Тэгээд л тэр нөхдүүд маань эргэж ороод нэг нэгээр нь гаргаж ирсэн юм.

Ер нь манай аврагчид усанд унасан, гал түймэрт өртсөн олон хүнийг аварч байсан ч үер ус, гал түймрийн аюул осолд амиа алдсан олон ч хүний асуудлыг шийдвэрлэхэд байгууллагын даргын хувьд биеэр байлцахад хүрдэг байсан даа. Яая гэхэв, миний хариуцсан ажил ийм л эрдэлтэй хойно.

Тэр өдрийн орой нь Сүмбэрийн хилийн цэргийн отрядын буудалд орос генерал бид хоёул амарч байтал буудлын үйлчлэгч цэрэг тантай хоёр хөгшин уулзах гээд ирээд байна гэхээр нь яах гэсэн юм бол гэсэн чинь мэдэхгүй гэдэг байна. Тэгэхээр нь оруул оруул гэж хэлтэл өндөр настай эхнэр нөхөр бололтой хоёр хөгшин ороод ирлээ. Мэнд усаа мэдэлцээд байтал өвгөн нь: За та хоёрт их баярлалаа. Хэрэв та нар хүүгийн минь цогцосыг гаргаж өгөөгүй бол хөгшин бид хоёр ирэх хавар болтол хэзээ мөс хайлж нуурын ус давалгаагаараа эрэгтээ гаргаж хаяхыг хүлээгээд элгээ хатгал энэ нуурын захыг сахих байлаа даа гээд хоолой нь зангирч байсан юм. Би хүүгээ алдсан эцэгт хандаж үнэхээр гай гэдэг хэцүү юм даа, сэтгэл санаагаа сайн барь даа та хоёр минь, өөр яахав дээ гэж арай чамай нэг юм хэллээ. Тэгтэл өвгөн: Харин ч бид хоёр бас азтай, энэ осолдсон нь ах нь байгаа юм. Дүүгээ тэр өдөр аваад яваач гээд байхаар нь загнаад нуурын эрэг дээр үлдээсэн байна лээ. Тэгээгүй бол бид бүүр дүүрэх байлаа шүү дээ хүү минь гэж байлаа. Миний сэтгэл их л өвдөж, хорвоо гэдэг хатуу үедээ мөн ч хатуу, зөөлөн үедээ зөөлөн л байх юм даа гэж бодож суусан юм.



Хошууч генерал П.СҮНДЭВ:

## ЭРГЭН САНАХАД АМЬДРАЛ ДУРСАМЖААР БАЯН

Ээлжийн амралтаасаа дуудагдсан намайг Төв аймгийн Заамарт төвлөрч ажиллах Улсын Байнгын Онцгой Комиссын ажлын хэсгийг ахлах үүргийг хүлээлгэсэн юм. Учир нь газар аваад байсан булчин задрах халдварт өвчний голомтыг дарах зорилгоор УБОК гурван ч газар ажлын хэсэг томилж бүсчилж ажиллах шаардлага гарсан. Би уг ажилд оролцсон нөхдийн хамт сар гаруй хугацаагаар ажиллаад буумагц Халдвартын эмнэлэгт хорио цээрийн журмаар хэвтэж, хяналтад нилээд хэд хоногоор байж, сая уг ажил шувтарч билээ. Гэвч удалгүй иргэний хамгаалалтын холбогдолтой ажил миний өдөр тутмын үйл болж, би УИХГ-ын даргаар томилогдсон нь нэг талаар дээрх булчин задрах халдварт тахал өвчний голомтод ажилласан маань иргэний хамгаалалтын системд ажиллах эхлэл байсан гэж үзэж болох мэт санагдана. Өгүүлэн буй үе нь 1996 оны долоо, наймдугаар сар л даа. Гарт орж, ижил дасал болсон

Хилийн албаа шинэ ажлаар солиход сэтгэл санааны хувь нэгд, бэлэн биш, хоёрт, ерөөсөө хүсмээргүй байсан боловч цэргийн хүн тушаалаар хойно шилэлт, сонголт гэх биш, шинэ ажилтайгаа танилцах ч завгүй шууд орсон юм. Тэр жил, мөн дараа жил нь олон зуун удаа ой хээрийн түймэр гарч, үүнтэй зэрэгцээд ган, зуд гэх мэт байгалийн бэрхшээл, гамшиг шил шилээ дарж, тэр бүхний хор уршгийг арилгах хэрэгт зөвхөн иргэний хамгаалалт төдийгүй нийтээрээ эрвийх дэрвийхээрээ хөдөлж, хүн хүч, хөрөнгө зардал, удирдлага зохион байгуулалтын их ажил ундарч байсан үе тул арга ч үгүй биз ээ.

Иргэний хамгаалалтын алба нь хилийн албатай харьцуулахад хялбар талтай ч, бас үүний зэрэгцээ зохион байгуулалт, үйл ажиллагааны бүтэц нь энгийн, цэргийн холимог, бүрэлдэхүүн нь орон тооны болоод орон тооны бус онцлогтой, мөн эрсдэл өндөр зэрэг хүндрэлтэй алба л даа. Тиймээс эдгээр өвөрмөц нөхцөлүүдийг судалж, хамт олны сэтгэл зүй, уур амьсгалыг мэдэрч, албаны тогтсон хэв маягийг дордуулахгүйгээр улам сайжруулахад чиглэсэн шинэ эрэл хийх, байгаа болоод шавхаж болох боломж, бололцоог олж нээж, хэрэглэх явдал чухал байлаа. Ажлын ийм шаардлага зөвхөн гамшиг, ослын талбарт ч төдийгүй бүр 30 гаруй жилийн турш засвар тордлого үзээгүй төв байрны засварт ч хэрэгтэй байсан л даа.

Дурьдан буй үед буюу 1996-2000 онд иргэний хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдолтой ололт, туршлага, сургамжийн талаар “Монгол Улсын Иргэний хамгаалалт” /түүхийн тойм/ нэртэй, 16 х.х. бүхий хамтын бүтээлд тодорхой дурьдсан байдаг тул энэхүү товч дурсамжинд бүгдийг үл өгүүлэн ганц нэг зүйл дээр тогтбуй хэмээв. Улсын Иргэний хамгаалалтын 35 жилийн ойг 1998 онд орон даяар тэмдэглэн өнгөрүүлж, энэ хүрээнд түүхийн тойм ном хэвлүүлж, Иргэний хамгаалалтын үйл ажиллагааг төв, орон нутагт сурталчлах, шүлэг, дууны уралдаан зарлах, дүгнэх, хурандаа-генерал С.Равдан агсны дурсгалыг мөнхжүүлэх, хэвлэлийн бага хурал зохион байгуулах зэрэг олон ажлыг хамт олны идэвхи, урам зоригийг хөгжөөн дэмжсэний дүнд амжилттай төлөвлөн зохион байгуулсан билээ. Урьд өмнө нь тус байгууллагын ойг тэмдэглэдэггүй байсан, энэ удаа нилээд хөлтэй зохион байгуулсан нь манай хамт олны урам зоригийг мэдэгдэхүйц дээшлүүлж, байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндийг олон түмэн болоод нийгмийн хэмжээнд өргөж дээшлүүлсэн сэтгэл зүйн ач холбогдол бүхий ажил болсон билээ.

Энэ баялаг түүхийг өдгөө Онцгой Байдлын Ерөнхий Газар, түүний харьяа отряд, анги, салбарууд мөн мэргэжлийн ангийнхан нэр төртэй үргэлжлүүлж байгаад хувьдаа баяртай байна.





Бэлтгэл хурандаа Д.РЭНЦЭНХАНД:

## НИСДЭГ ТЭРЭГТЭЙ БОЛОХ БОЛОМЖ БАЙСАН...

2000 онд намайг УИХГ-ын даргаар ажиллаж байхад баруун болон төвийн аймгуудыг хамарсан их зуд, Хэнтий аймгийн хойд талын сумдад гарсан ой хээрийн түймэр, Дорноговь аймгийн Улаанбадрах суманд дэгдсэн шүлхий зэрэг гамшгийн хор уршгийг даван туулахад Улсын иргэний хамгаалалтын дарга, Монгол Улсын ерөнхий сайд Р.Амаржаргал, Улсын байнгын Онцгой комиссын дарга, Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж нарын удирдлага дор байнгын комиссын ажлын аппарат болж Улсын Иргэний хамгаалалтын газрын бүрэлдэхүүн, Онцгой комиссын Улсын албадын туршлагатай ажилтнуудтай хамтран шуурхай арга хэмжээ авч, гамшгийн хор хохирлыг амжилттай даван туулсан билээ.

Зудын эхний үед УБОК өөрийн эрх мэдлийн хүрээнд зудтай тэмцсэн боловч зудын гамшиг дийлдэшгүй хүчин зүйл болж хувирахад төр засгаас эхлэн иргэн хувь хүний идэвхитэй оролцоотойгоор улс оронд тохиолдсон гамшгийн тухай мэдээлэл сурталчилгааг гадаадын улс орнуудад болон олон улсын байгууллагуудад хүргэснээр зудын хор уршгийг арилгаж чадсан гэж боддог. УБОК-ын орлогч дарга, одоогийн “Таван толгой” компаний захирал Батсуурь гуай Япон улсад ажиллаж байхдаа тус улсын иргэдэд бодитой мэдээлэл хүргэснээр Япон улсын иргэдээс ихээхэн хандив тусламж УБОК-д ирж байсныг малчдыг малжуулахад зориулж байлаа. Зудын гамшгийн дараа ч улс орнуудаас тусламж үзүүлэх саналаа ирүүлсээр байсан. Тухайлбал Кувейт улсаас 200 гаруй сая ам долларын тусламжид ямар тусламж авах саналаа ирүүлэхийг хүсэхэд Батлан хамгаалахын сайд асан Гүррагчаатай санал солилцон УБОК-д зориулж вертолёт авах санал явуулахаар тохирсон боловч тухайг үед ажил хэрэг бололгүй унтарч тэрхүү тусламжийн мөнгө намрын тариа хураалтын шатахууны зардалд зориулагдсан гэдэг. Гамшгийн тухай түүний хохирлыг талаархи мэдээлэл сурталчилгааг өргөжүүлэх зорилтын хүрээнд тус газрын мэдээллийн сүлжээг өргөтгөж хүчин чадлыг сайжруулснаар манай газрын ажилтнуудын харилцдаг хүрээ өргөжиж гадаад улс орнуудын туршлагаас суралцах, мэдээллээ түгээх боломж өргөжсөн билээ. Тухайн үед төр засгийн томоохон дэмжлэг, гадаад улс орнуудыг тусламжтайгаар УБОК их зудын хор хохирлыг даван туулсан юм.

2000 оны 4-р сард ОХУ-аас хил давж орж ирсэн ой хээрийн түймэрт Хэнтий аймгийн Дадад сум шатаж байна гэсэн мэдээ долоо хоногийн ажлыг төгсгөлийн өдөр Ерөнхий сайдад ирж, түймрийг унтраах үүргийг УБОК авч, шөнө дөлөөр хуралдаж ой хээрийн түймрийн цагийн байдлыг газар дээр нь үнэлэн унтраах үүрэгтэйгээр УБОК-ын хоёр орлогч Байгаль орчны сайд Мэндсайхан, мөн миний бие, УИХГ-ын мэргэжилтэн дэд хурандаа Д.Намсрай, галын газрын мэргэжилтэн О.Ганхуяг болон шүхрийн дадлагын хаврын буултаа хийж бэлтгэлээ хангасан Нийслэлийн аврах ангийн 20 гаруй шүхэрчин гал сөнөөгчийн хамт Хэнтий аймагт очиход ой хээрийн түймэр олон га газрыг хамарч, тухайн үеийн ажиллаж байсан хүч хэрэгслээр унтрааж чадахааргүй болсон байлаа. Түймрийн цагийн байдалд үнэлгээ хийж Хэнтий аймгийн засаг дарга Энхээтэй зөвлөлдөн, хүн хүч техник хэрэгслийн дайчилгааг явуулан ажилласны үр дүнд дээрхи түймрийг Дадал сумаас 1 километрийн зайд унтрааж билээ. Ой хээрийн түймрийг унтраахад ойд буусан шүхэрчид, тал хээрийн түймрийг унтраахад үлээгчтэй аврагчид маань зориг тэвчээр, авхаалж самбаатай ажилласны хүчээр тус түймрүүдийг хүч хэрэгслийн бага хохиролтойгоор унтраасан юм. Түймрийн голомтод шүхэрчдийг буулгах, түймрийг унтраах тактик боловсруулахад ИХГ-ын мэргэжилтэн дэд хурандаа Д.Намсрай, Галын хурандаа О.Ганхуяг нар голлох үүрэг гүйцэтгэж байсныг энд дурдахад таатай байна. Ийм туршлагатай мэргэжилтнүүдийг тогтвор суурьшалтай ажиллуулж тэдний туршлага мэдлэгийг ашиглах нь Онцгой байдлын албанд үр өгөөжтэй байх болов уу.



Хошууч генерал О.ҮРЖИН:

### ОФИЦЕР, АХЛАГЧ НАРЫНХАА ТӨЛӨӨ СЭТГЭЛ ТҮГШСЭН ӨДРҮҮД НАДАД БАЙСАН ЮМ

Би энэхүү дурсамжаа Улсын Иргэний Хамгаалалтын Байгууллагын буюу одоогийн Онцгой байдлын албаны 2001- 2003 оны эрх зүйн өөрчлөлтийн нарийн ээдрээтэй үйл явцыг бодит үнэнээр нь үлдээхэд чиглүүллээ. “Иргэний хамгаалалтын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулах мөчөөс эхлээд хамгийн их дэмжлэг үзүүлж ажилласан яам бол Гадаад хэргийн яам байлаа. Гадаад хэргийн яам гамшгаас хамгаалах талаар дэлхий нийтийн өмнө тулгарч буй асуудал, тавигдаж буй шаардлагыг хамгийн соргоогоор мэдэрч, улс орны эрх ашгийг эрхэмлэж байхад зарим удирдлага явцуу салбарын хүрээгээр сэтгэж байсанд учир байгаа юм. Хуулийн төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх үед Батлан хамгаалахын удирдлагын зүгээс өөр хуулийн төсөл зэрэгцүүлэн оруулж ирсэнтэй холбоотойгоор хоёрхон хоногийн дотор олон чухал заалтууд хасагдаж, хууль “Гамшгаас хамгаалах тухай” гэсэн шинэ хууль болж батлагдсан түүхтэй юм.

Аливаа шинэчлэлд түгээмэл тохиолддог бэрхшээл байдаг. Энэ нь салбарын удирдлагын зарим бүрэлдэхүүн асуудлын мөн чанарыг ойлгоогүйгээс улс орны эрх ашгаас салбарын явцуу эрх ашгийг дээгүүр тавьж шинэчлэлд тодорхой саад учруулдаг явдал юм. Иргэний хамгаалалтын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх явцад Батлан хамгаалах салбарын зарим удирдлагын зүгээс ийм үйлдлийг маш эрчимтэй явуулж байсныг хэлэх хэрэгтэй юм.

Эрх зүйн энэхүү шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагыг Үржин гэдэг хүний хувийн эрх ашиг мэтээр тайлбарлаж, улс орны батлан хамгаалах эрх ашигт хохирол учруулж байна гэсэн ухуулгыг хийж байлаа. Цөөнгүй хүмүүст ийм ойлгоц бий болгосон нь өнөөдөр ч гэсэн зарим хүмүүсийн үг, үйлдлээр илэрдэг л юм.

Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч хатагтай Менон, манай улсын гамшгаас хамгаалах тогтолцоог судлах олон улсын багийн ахлагч профессор Маршал Силвер нарыг Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяртай уулзуулсан юм. Энэ уулзалтан дээр өнөөгийн УИХ-ын гишүүн, тэр үед Ерөнхий сайдын зөвлөх байсан Хүрэлбаатар, Засгийн газрын референт Баяраа нар болон миний бие байлцсан юм. Уулзалтын үеэр хатагтай Менон, профессор Маршал Силвер нар гамшгаас хамгаалах тогтолцооны шинэчлэл зайлшгүй шаардлагатай болох талаар Ерөнхий сайдтай санал солилцож, Ерөнхий сайд тэдэнтэй санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн юм. Энэ уулзалтын төгсгөлд Гүррагчаа сайд Ерөнхий сайдад галын байгууллагыг иргэний хамгаалалттай нэгтгэх нь зүйтэй юм гэсэн санал хэлсэн.

Хуулийн төслийг хэлэлцэх үед зэрэгцүүлэн оруулж ирсэн хуулийн төслөөрөө дараах төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилго тавьсан байх магадлал өндөр юм. Үүнд: Иргэний хамгаалалт гэсэн нэрийг Батлан хамгаалах салбарт авч үлдэх. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэрийг “Гамшгаас хамгаалах тухай” болгон өөрчилж чадсанаараа энэхүү зорилгоо биелүүлж чадсан. Гэхдээ энэ нь хэрэгцээтэй үе тохиолдоход улс оронд ямархуу муу үр дагавар авчрах бол гэдэгт одоо хүртэл санаа зовдог юм. Гамшгийн аюулын өөдөөс амь өрсөн тэмцдэг ахлагч нар болон офицеруудыг цолгүй, ялгах тэмдэгтэй байхаар төсөл боловсруулсан байсан. Ийм алхам нь тухайн үед ажиллаж байсан офицер, ахлагч нарын сэтгэлийг нь үймүүлж, тэдний дунд шинэчлэлийн эсрэг уур амьсгал бий болгох талтай байсан.

Төрийн тусгай албан хаагч гүйцэтгэж буй албаныхаа онцлогоор цолтой байж, тушаалаар үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цол бол тэдний хувьд дээдэлж, хүндэлж явдаг нэр төрийн хэрэг байдаг. Гамшгийн өөдөөс тушаал аваад сөрөн зогсдог хүмүүсийг цолгүй болговол тэдэнд сэтгэл зүйн ямар хүнд цохилт болоод зогсохгүй, гамшгаас хамгаалах албаны тогтвортой байдал алдагдаж, улсад ихээхэн хохирол учрах нөхцөл бүрдэх байлаа.

Эрх зүйн шинэчлэл хийсэн энэ хугацаанд офицер, ахлагч нарын минь цолны асуудал намайг хамгийн их

сэтгэл түгшээж байсан. Тэднийхээ өмнө буруутан ч юм шиг санагддаг үе байсан шүү. Үүний зэрэгцээ хуулийн ерөнхий концепцээ л алдагдуулахгүй авч үлдэх, дараа нь нэмэлт өөрчлөлт оруулах замаар бусад алдааг засаж болох байх гэж бодогддог юм байна лээ.

Төгсгөлд нь өөрийн баримталдаг зарчим, чиг шугмын талаар хэдхэн үг хэлье. Би эцэг, эхээс өгсөн нэрийг сэвтээхгүй өндөрт өргөж явах, үнэнч шудрага байх, хариуцуулсан ажлыг хийсэн шиг хийх, улс орныхоо эрх ашгийг хувийн эрх ашгаас ямагт тэргүүн зэрэгт тавих зарчим баримталдаг. Батлан хамгаалах салбартаа би хайртай. Цэргийн бид “Монгол Улсын төлөө зүтгье” гэж эх орноо гэсэн сэтгэлээ илэрхийлдэг. Улсын иргэний хамгаалалтын газрын даргаар ажиллаж байхдаа иргэний хамгаалалтын үйл ажиллагааг улс орныхоо эрх ашигт



*ОБЕГ-ын анхны удирдлагууд 2005 он*

нийцүүлэн шинэчлэхийн төлөө ажилласан нь зарим хүмүүсийн хэлдэг шиг батлан хамгаалах салбарынхаа эсрэг хийсэн үйлдэл биш, харин өргөсөн тангарагтай үнэнч байж, улс эх орныхоо төлөө шудрагаар хөдөлмөрлөсний үр дүн юм.

Иргэний хамгаалалтын үйл ажиллагаанд шинэчлэл хийснийхээ төлөө би долоон жил ажилгүй явсан. Гэхдээ өнөөдөр гамшгаас хамгаалах албаны гадаад харилцаа өргөжсөн, олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжих боломж нээгдсэн, аврагч нарыг аврах техник хэрэгслээр хангахад ихээхэн хөрөнгө оруулалт хийгддэг болсон, боловсон хүчнийг гадны улс оронд бэлтгэх боломж бүрдсэн зэрэг олон улсын жишигт нийцсэн олон дэвшил гарсан байгааг хараад хийсэн үйл хэрэгтээ сэтгэл хангалуун байдаг юм.



Хошууч генерал О.ОТГОНЖАРГАЛ:

## ГАЛЫН АЛБА БОЛ ААВЫН МИНЬ ӨРГӨӨ ЦАГААН ГЭР

Хошууч генерал О.Отгонжаргал 1928 онд Төв аймгийн Эрдэнэ сумын Ташгайт хэмээх газар төрсөн. 1939-1943 онд Улаанбаатар хотын 3 дугаар сургууль, 1943-1947 онд жанжин Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургууль, 1956-1959 онд ЗХУ-ын Галын техникийн сургууль, 1964-1967 онд ЗХУ-ын Нийгмийн хэв журам хамгаалах яамны дээд сургуульд тус тус суралцаж төгсжээ. Тэрбээр 1955-1956 онд Цэргийн ба НАХХЭЯ-ны гал түймрийг эсэргүүцэх хэлтсийн орлогч дарга, 1959-1962 онд гал түймрээс сэргийлэн хамгаалах хэлтэст ахлах байцаагч, тасгийн дарга, Төв гал командын дарга, 1962-1964 онд Галын аюулаас сэргийлэн хамгаалах хэлтсийн дарга, 1980 оноос УЦСЕГ-ын Сэргийлэн хамгаалах хэлтсийн дарга, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн орлогч бөгөөд Түймэр эсэргүүцэх агаарын харуулын албаны даргаар ажиллаж байсан юм.

О.Отгонжаргалд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1979 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 226 дугаар тогтоолоор хошууч генерал цол хүртээжээ.

О.Отгонжаргал генерал ийн дурссан юм. “1955 оны 9 дүгээр сард Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайд, генерал Жанчив дуудаж, тус яамны Гал түймэртэй тэмцэх хэлтсийн орлогч даргаар томилж байгааг мэдэгдсэн. Жил хэртээ ажиллаад ЗХУ-ын Галын техникийн сургуульд суралцахаар явсан. Намайг Ленинградд очиход сонсогч Ж.Жанчив /Галын байгууллагад гал сөнөөгчөөс дарга болтол 40 гаруй жил, үүний 24 жилд нь даргаар ажилласан, ясны гал сөнөөгч мэргэжилтэн гэгдэх хурандаа/ тосч авсан. Энэ үеэс Ж.Жанчивтайгаа их сайхан нөхөрлөсөн. Миний хань Долгорсүрэн Жанчивын гэргий Жанамаа хоёр багын найзууд болохоор бидний андын холбоог улам бэхжүүлж гагнаж байсан юм. Сургуулиа төгсөж ирээд Гал, сэргийлэн хамгаалах хэмээх нэгдсэн хэлтсийн хоёр тасгийн нэгний даргаар /нөгөө хэлтсийн дарга нь Намсрайжав/томилогдсон. Галын хэлтсийг цагдан сэргийлэх байгууллагаас салгаж, тогтолцоог нь шинэчлэх явдал маш чухал байсан. Энэ ажлыг хийж хэрэгжүүлсэн. Хугацаанаас өмнө хошууч цолоор шагнагдаж, Галын аюулаас хамгаалах хэлтсийн даргаар томилогдсон. Ахлах дэслэгч Г.Лхамжав, ахлах дэслэгч Лувсанбалдан нартай хамтран гал унтраах дүрэм, “Онц гал сөнөөгч” тэмдгийн зураг төсөл, загварыг батлуулж байлаа. Мөн Галын туршин шалгах станцын анх удаа байгуулж байв. 1980-аад оны эхээр хариуцаж хоёр жил ажиллахдаа Сайд нарын зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга Д.Майдар, С.Лувсангомбо нартай ойр дотно харилцаатай байж, Агаарын харуулын албанд шүхэрчид ажиллуулах болгож, түймэр элбэгших магадлалтай хавар, намрын цагт шүхэрчдийн бэлэн байдлыг хангах, дадлага сургуулилтыг тогтмолжуулж, агаарын эргүүлийн урьдчилан сэргийлэх нислэгийг хэвшүүлсэн. Зөвлөлтийн мэргэжилтнүүд болон манай Чулуун, Нацагдорж гээд олон мундаг мэргэжилнүүдтэй хамтарч ажиллаж байсандаа бахархдаг.

НАХЯ-ны нэгдүгээр орлогч сайд, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын дарга Ж.Авхиа дуудаж, “Би амласандаа хүрсэн шүү” гэж хэлсэн нь үнэхээр магнай тэнийм баяртай мэдээ байлаа. Ингээд би ЗХУ-д Галын инженерийн сургуульд суралцахаар явсан юм. Галын алба бол намайг өсгөж, эрийн цээнд хүргэсэн, алсын морины дөрөө жийлгэж, жолоо атгуулсан нэгэн үгээр аавын минь өргөө цагаан гэр. Эндээс би сургуульд явж, хоёр дахин боловсрол мэргэжил эзэмшиж, түмнийхээ энх амгалан төлөө хүчин зүтгэх насан туршийн үйлээ эхэлж, амьдрал хэмээх олон шат, нугачаатай өгсүүр, урт замаар гишгүүр алдалгүй урагшилж, гарах оргилдоо хүрэх итгэлийг олж авсан. Бараг жарны тэртээ алтан босгоор нь алхаж орсон тэр цагийг эргэн санаад өнөөдрийг харахад боловсон хүчин, техник хэрэгсэл, хүч нөөцийн хувьд танигдашгүй болтол өсч, өөрчлөгдөн хөгжжээ.

Онцгой байдлын алба улам хүчирхэгжинэ мандана гэдэгт итгэл дүүрэн байна” хэмээн өгүүлсэн юм. Өдгөө 96 нас сүүдрийг зооглож байгаа ч гал, цагдаа, хилийн алба, Галтай Булнайгаараа бахархаж, үр ачаа тойруулан цовоо сэргэлэн байгаа өвгөн генералаар бахархахгүй байхын аргагүй. Ярилцаж суух хугацаанд өвгөн генерал

маань Онцгой байдлын ерөнхий газрын харьяа хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит Аврах тусгай ангийн хүндэт тэмдгийг их л дээдлэн хүндэлж, хүзүүндээ зүүж байсан. Ясны генерал гэж түүнийг л хэлэх байх даа.



*Түймэр эсэргүүцэх агаарын харуулын албаны удирдах бүрэлдэхүүн 1983 он*



### Бэлтгэл хурандаа Ж.ЖАНЧИВ

Хурандаа Ж.Жанчив Төв аймгийн Баянчандмань сумын нутагт 1930 онд төрсөн. Галын аюулаас хамгаалах хэлтэс, газрын даргаар 24 жил тогтвортой ажиллан Сүхбаатарын одонт, хүндэт чекист, хүндэт халамжлан хүмүүжүүлэгч, Галын байгууллагын зууны манлай удирдагч байж, офицер, улирагсдын дунд “Жа” дарга хэмээн авгайлагдаж ирсэн буурал хурандаа билээ.

Жа хурандаа цэргийн хүний ёсоор ажил албандаа үлгэр жишээчээр ажиллаж, ажил хэргийнхээ төлөө ар гэр амьдралаа ч умартан зүтгэж хамт ажиллагсдадаа үлгэр дуурайлал болдог байлаа. Дээрх зан чанарыг бидний үеийн офицер, улирагсад хүндэтгэн дагаж мөрддөг байсан, өнөө үед ч гэсэн энэ зан чанарыг залуу үе өвлөн авах зайлшгүй шаардлагатай гэдгийг ахмад ажилтны хувьд захиж хэлмээр байна. Энэ зан чанар ерөнхийдөө их дутагдаж байгаа нь ажиглагддаг. Жа даргын уйгагүй хөөцөлдөлгөө, ажил хэрэгч чанар, алсын хараа, оновчтой санал санаачлагын үр дүнд Галын аюулаас хамгаалах

хэлтэс маань газар болон өргөжсөний зэрэгцээ 18 аймгийн төвд шинээр гал унтраах анги байгуулагдсан.

Мөн гал түймрийн нөхцөл байдал, ажлын ачааллаас шалтгаалан Дархан, Сэлэнгэ, Дорнод аймгийг Галын тасагтай болгон тэдний материаллаг баазыг бэхжүүлэх, орон тоо, техник, багаж хэрэгслийн шинэчлэх, мэргэжлийн боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд онцгой анхаарч ОХУ-ын Галын инженер техникийн дээд сургуульд суралцагчдын тоог хоёр дахин нэмэгдүүлэх үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэснийг түүх мартаж өсгүй юм.

Улс оронд ихээхэн хэмжээний аюул, хор хөнөөл учруулж байсан ой хээрийн түймэртэй тэмцэх арга ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын буцалтгүй тусламжийн хүрээнд шинэ техник, технологээр хангахад анхаарч ажилласны үр дүнд Түймэр эсэргүүцэх агаарын харуулын алба Улсын онцгой комиссын дэмжлэгийг тухайн үед сайн авдаг, нэр хүндийн хувьд ч өссөн юм. Жа дарга маань нэг их уурлаж хашгираад байдаггүй үүрэг даалгавраа хариуцах эзэнтэй, тодорхой хугацаатай өгдөг, биелэлтийг нь өөрийн биеэр шалган танилцдаг өндөр шаардлагатай “чанга” хүн байсан. Гал түймрийн хяналтын улсын болон зураг проектын байцаагч нарт өндөр шаардлага тавьдаг байсан бөгөөд офицер ажилтны зөвлөгөөн дээр эмч хүн өвчтнөө эмчлэх боломжгүй болсон үед “рак” гэж оношилдог шиг та нөхөд галын шалтгаан нөхцөлийг тогтоох ажилд хүндрэл учрангуут цахилгаанаас болж гарчээ гэдэг дүгнэлт гаргадаг ажил давамгайлж байгааг анхааруулж ажлынхаа арга барилд өөрчлөлт хийх, урьдчилан сэргийлэх ажлыг чанаржуулж эрчимжүүлэх хэрэгтэй гэдэг хатуу зарчмыг баримталж ажилладаг байсан нь ажлын үр дүнд илүү түлхэц үзүүлсэн гэж үздэг. Ялангуяа зураг проектын байцаагч нарт зурагт шүүлт хийх, ажлын, улсын комисст ажиллахдаа хувийн бэлтгэлээ сайтар хангаж байх, хянасан, хүлээн авсан барилга байгууламж, объект чинь хэзээ хойно, та нөхдийн болон галын байгууллагын ажлын үр дүнг илтгэх ажил болно шүү гэдгийг онцгой анхаарахыг сургамжилж байсан нь тодоос тод санагдаж байна. Үүнийг ч гэсэн энэ чиглэлийн ажил хариуцдаг ажилтнууд санаж ажиллахад илүүдэхгүй байх. Жа дарга маань их нийтэч мэдлэг чадвартай, ажил хэрэгч хүмүүсийг магтан урамшуулдаг бусад мэргэжлийн байгууллагатай нягт хамтран ажиллахыг чухалчилдаг байсан. Энэ ч утгаараа хоёр яамны сайдын баталсан удирдамжаар 18 аймаг, нийслэл хотод хамтарсан шалгалт хийдэг болсноос хойш гал түймэр гаралтын тоо багасаж, учирдаг хохирлын хэмжээ буурсаны дээр гал түймрийн хяналтын улсын байцаагчид бие даан ажиллаж, ур чадварын хувьд ч сайжирсан юм.

Жа дарга маань нилээд хүнийг явуулдаг, шаггүй “шооч” хүн байсан. Тун даруухан, төлөв түвшин зантай, ажил хэрэгч чанараараа хамт олондоо ихээхэн хүндлэгдсэн, хэнийг ч ялгалгүй харьцдаг байсныг олон зуун гал сөнөөгчид шавь нар нь санан дурсдаг. Галын аюулаас хамгаалах байгууллагад 40 гаруй жил ажиллахдаа 24 жилийг нь удирдах ажил хийсэн буурал хурандаа маань тэтгэвэрт гарахдаа “Онц гал сөнөөгч” тэмдгээр шагнагдаж олныг алмайруулж байхав дээ, сонин юм шүү.

Гал түймэртэй тэмцэх газрын дэд дарга асан хурандаа О.Ганхуяг



## Онцгой байдлын бэлтгэл комиссар Д.ХИШИГБААТАР БИДЭНД ЗОРИГ ЗҮРХ ХЭРЭГТЭЙ БАЙНА

Миний бие 1975-1978 онд Улаанбаатар хотын Нефть хангамжийн баазад гэрээт гал командад гал сөнөөгчөөр орж ажиллан ажлын гараагаа эхлэсэн. 1978-1983 онд ЗХУ-ын ДЯЯ-ны Москва хотын Галын инженер техникийн дээд сургуульд сонсогч, 1983-1986 онд Галын аюулаас хамгаалах газрын сургалт, суртал ухуулга хариуцсан байцаагч, 1986-1990 онд Мөн газрын ХЗЭ-ийн нарийн бичгийн дарга, 1990-2000 онд Цагдаагийн ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, 2000-2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гал түймэртэй тэмцэх газрын дарга, 2004-2005 онд Засгийн газрын тохируулагч агентлаг Гамшгаас хамгаалах ерөнхий газрын дэд дарга, гал түймрийн улсын хяналтын ерөнхий байцаагч, 2005-2007 онд Онцгой байдлын албаны Сургууль байгуулах ашиглалтын өмнөх захиргааны дарга, 2005-2007 онд Онцгой байдлын албаны Сургууль байгуулах ашиглалтын өмнөх захиргааны дарга, 2007-2008 онд Онцгой үеийн шуурхай удирдлагын болон Гал түймэртэй тэмцэх газрын даргаар нийтдээ Гал түймэртэй тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагад 33 жил 7 сар ажиллаад 51 насандаа 2008 онд цэргийн байнгын тэтгэвэрт гарсан.

Гамшиг осол, гал түймэртэй тэмцэх асуудлаа эрчимжүүлэхийн тулд эрх зүйн орчноо боловсронгуй болгох хэрэгтэй. Одоогийн удирдлага энэ тал дээр онцгой анхаарч урьд баталсан хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэ хуулийн төсөл боловсруулан олон үе шаттай хэлэлцүүлэг хийж сайн хууль гаргахаар ажиллаж байгаад талархаж байна. Гэхдээ бусад хуулийг догматикаар хуулбарлах бус манай орны хөрсөн дээр буух, үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болох хууль нэн шаардлагатай. Гамшгаас хамгаалах, Галын аюулгүй байдлын болон Улсын нөөцийн тухай хуулийг нэг мөр ойлгож, жигд хэрэгжүүлэх шаардлагтай.

Тухайлбал Гамшгаас хамгаалах тухай хууль Улсын их хурлаар 2003 онд батлагдсан. Энэ хуулийн 22.1.1-д заахдаа Монгол улсын гамшгаас хамгаалах төрийн бодлого, хөтөлбөрийг Улсын их хурлаар, 23.1.2 д заахдаа гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал, амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраар тус тус батална гэж заасан. Гэтэл хуулийн 22.1.1 дэх заалтыг 8 жилийн дараа буюу 2011 онд хэрэгжүүлсэн, харин 23.1.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй 11 жил боллоо, энэ юуг хэлээд байна гэхээр ийм чадавхи чадамж манай байгууллагад байна уу, эсвэл хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэхэд тийм хүндрэлтэй байна уу гэсэн асуудал гарна. Мөн Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4.4.4, 7.3 дахь заалт 2004 оноос хойш хэрэгжихгүй байна. Үүнээс үүдэн эрдэнэт хүний амь нас хохирох, гал түймэр тавигсад ял завших явдал газар авч болзошгүй байгаа юм. Ер нь Улсын их хурлаар хууль тогтоомжоо батлуулаад санаа амраад хаячихдаг, батласан хуулиудынхаа хэрэгжилтийг хянадаг, хариуцлага тооцдог байгууллага, албан тушаалтан алга гээд хэлчихэд буруудахгүй.

Гамшиг осолтой тэмцдэг мэргэшсэн боловсон хүчинг бодлогоор бэлтгэх, мэргэжлийн албадыг тохиолдлын бус мэргэжсэн баг, хамт олон удирдаж улс орны хэмжээнд гарч болзошгүй гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж чадна гэдгийг төрийн удирдлагын түвшинд ойлгох цаг болсон. Монгол улсын Ерөнхийлөгчийн дэвшүүлээд байгаа “Том төрөөс ухаалаг төр лүү шилжих” уриаг манай алба хүлээн авч хэрэгжүүлбэ. Одоо аль ч шатандаа удирдлагын бүтэц данхайгаад ачааны хүндийг үүрдэг нэгж маань сульдаатай хүүхэд шиг хүн хүч хүрэлцэхгүй байгаа алдааг арилгах зориг зүрх хэрэгтэй байна.

Онцгой байдлын байгууллага маань өдөр ирэх тусам хөгжиж цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж байгааг хэн ч үгүйсгэхгүй. Энэ талаар олон арван хүмүүсийн ярилцлага, дурсамжаас ойлгож мэдэрсэн гэдэгт эргэлзэхгүй байна. Гэхдээ бид дардан бус замаар явж ирснээ, алтан боломжуудыг маш муу ашиглаж байснаа, дахин тийм алдаа аргахгүй байх зорилгоор алдаж, онож байснаа санан дурсахад ийм байна.



Онцгой байдлын бэлтгэл комиссар **Т.ГАНБОЛД**:

### АВРАГЧ ДАЙЧДАА ГҮН ХҮНДЭТГЭН ДУРСНАМ

Миний бие 1985 оны 3 дугаар сард БХЯ-наас дайчилгааны нөөцийн Тусгай хэлтэст томилогдон ирж ажиллах болсноор Улсын нөөц Онцгой байдлын ажил албатай амьдралаа холбосон. Миний хувьд Улсын нөөцийн газарт 1998 оны 7 сар хүртэл мэргэжилтнээр, 2000 оны 9 сар хүртэл ерөнхий менежер буюу орлогч даргаар, 2003 оны 3 сар хүртэл дэд даргаар, 2004 оны 1 сар хүртэл газрын даргын үүргийг давхар хариуцан ажиллаж байгаад одоогоос 10 гаруй жилийн өмнө 2004 оны

01 дүгээр сарын 07-ны өдөр Засгийн газрын 3 агентлагийг нэгтгэн, Онцгой байдлын албыг анхлан байгуулахад Гамшгаас хамгаалах ерөнхий газарт дэд дарга бөгөөд Улсын нөөцийн газрын даргаар томилогдон, 2005 оны 3 сарын дунд хүртэл ажилласан. Ийнхүү миний бие улсын хороо, яам, Засгийн газрын агентлагт улсын нөөцийн чиглэлээр 20-иад жил ажиллахдаа салбарын олон яам, газруудын харъяалалд салангид байсан улсын нөөцийг төрийн мэдэлд, нэг гарт төвлөрүүлж, нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, “Улсын нөөцийн тухай хууль”-ийг боловсруулж батлуулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоод тухайн цаг үед хамт ажиллаж байсан удирдлага, мэргэжилтнүүд, салбарын эрхлэгчид, нийт хамт олондоо чин сэтгэлээсээ гүн талархлаа илэрхийлж, сайн сайхныг хүсэн ерөөе.

Онцгой байдлын ерөнхий газрын анхны дарга, шинэ Үндсэн хууль батлалцсан АИХ-ын депутат асан П.Даш генералын хувьд юуны өмнө тухайн нэгдэж байгаа газруудын удирдлага генерал О.Үржин, хурандаа Д.Хишигбаатар болон Т.Ганболд миний биетэй уулзаж, шинэ тутам байгууллагын бүтцийг гаргаж, батлуулахаас ажлаа эхэлж байсан. Гэвч хэдийгээр төр, засгийн шийдвэртэй ч, өөр өөр яамдын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан, зэвсэгт хүчин, дотоодын цэргийн болон иргэний статустай байсан байгууллагуудыг нэг бүтцэд оруулах асуудал тийм ч амар хялбар байгаагүй. Улсын нөөцийн тухайд үйл ажиллагааны онцлогоос хамааран төв, орон нутагт иргэний хамгаалалт, галын анги, байгууллагатай шууд нэгтгэн нийлүүлэх боломжгүй гэдгийг эхнээсээ хаана хаанаа сайтар ойлголцсон. Харин иргэний хамгаалалт, галын асуудлыг гамшиг гэж хамтатган ойлгож, төв, орон нутагт нэг бүтцээр байлгах, эсэх асуудлаар санал зөрөлдөж, өөр өөр байр суурьтай байснаас нэгдсэн ойлголтод хүрэхэд хүндрэл гарч байлаа. Энэ бүхэнд асар их тэвчээр, хүлээцтэй, бас хүндэтгэлтэй хандаж байж одоогийн Онцгой байдлын ерөнхий газрыг байгуулж, улмаар үндсэн үйл ажиллагааг нь төлөвшүүлж, нэгдмэл хамт олныг бүрдүүлэх, анги, байгууллага, төв аппаратаасаа эхлээд ажиллах нөхцөл боломж сайтай, өөрийн гэсэн өнгө төрхтэй болгоход П.Даш тэргүүн комиссарын хичээл зүтгэл их байсан гэдэгтэй дийлэнх нь санал нийлэх байхаа.

2005 онд Онцгой байдлын ерөнхий газар болж өөрчлөгдөн, нэг дэд даргатай болоход миний бие уг албан тушаалд томилогдон 2006 оны 7 сар хүртэл ажиллаж, Онцгой байдлын албаны цол олгох журам, дүрэмт хувцасны загварыг батлах тухай Ерөнхийлөгчийн зарлиг боловсруулж батлуулах, хэрэгжүүлэхээс эхлээд шинэ тутам байгууллагын үйл ажиллагааг жигдрүүлэхтэй холбоотой олон ажлын хэсгийг ахалж, бүхий л үйл ажиллагаанд биечлэн оролцсон. Харин 2006 онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр Онцгой байдлын ерөнхий газар 2 дэд даргатай болоход гамшгийн асуудал хариуцсан дэд даргаар 2007 оны 7 сар хүртэл ажиллаж, олон улсын жишигт нийцсэн гамшгийн удирдлагын менежмент, гамшгаас хамгаалах хяналтын тогтолцоог бий болгоход анхаарч, Архангай, Завхан, Булган, Сүхбаатар аймгуудад Гамшгаас хамгаалах команд штабын, Өмнөговь аймагт Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг биечлэн удирдсан. Шинэ тутам байгууллагын түүхэнд хар толбо үлдээж, олон сайхан залуусын амь насыг авч одон, цөөн хэд нь амьд үлдсэн нисдэг тэрэгний аймшигт





осол 2007 оны 6 сарын 14-нд тохиолдож, надтай ойр дотно, хамтран ажиллаж байсан комиссар Батбаатар, дээд ахмад Цэрэнням 2 маань харамсалтайгаар эрсдэж, дахин бидэндээ эргэж ирээгүй... Энэ мөчид цаг бусаар хорвоог орхисон залуусаа эргэн дурсаж, гүн хүндэтгэл үзүүлж, мэхийн ёсолж байна. Ийм сэтгэл шимшрэм, гай зовлон дахин хэзээ ч давтагдах ёсгүй, хаана хаанаа өндөр хариуцлагатай байх учиртай. Хэдийгээр тухайн үед миний бие Ерөнхий сайдын шийдвэрээр орон нутагт ажиллаж байсан ч, асуудал хариуцсан дэд дарга гэдэг агуулгаар ажлаасаа халагдаж, хэдэн сар гэртээ сууж билээ. Тийм айхтар ослын дараа мэдээж хэн нэгэнтэй хариуцлага тооцох зайлшгүй шаардлага байсан биз ээ.

Харин би 2008 оны эхнээс 2009 оны 9 сард дипломат албанд томилогдох хүртлээ ерөнхий газрын сургалт хариуцсан дэд даргаар ажилласан. Энэ хугацаанд мэргэжлийн сургалтын төвийг байгуулж, усчин, эмнэлгийн анхан шатны туслах ажилтан, нурангийн эрэн хайх, химичин, тэсэлгээчин гэсэн төрөл мэргэжлийн аврагчдыг өөрсдийн хүчээр, харин ОХУ, БНСУ-ын олон улсын сургалтын төвүүдэд анх удаа 100 гаруй аврагчдыг тус тус сургаж, бэлтгэж эхэлснээс гадна ОХУ-ын Онцгой байдлын яамны зардлаар Иргэний хамгаалалтын академид 2, Галын академид 4 офицериийг жил бүр сургахаар болсон зэрэг арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэхэд биечлэн оролцсон нь Онцгой байдлын албаны сургалтын тогтолцооны төлөвийг тодорхойлох, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд түлхэц үзүүлсэн гэж боддог.

Улсын нөөцийн салбарын дарга, нягтлангуудыг эхний ээлжинд цолтой болгох асуудлыг удаа дараа хөндөж байсан боловч хууль эрх зүйн үндэс, санхүүгийн боломж талаасаа хүндрэл гарч удааширч байлаа. Харин 2005 оны эхээр эрхэлсэн сайд У.Хүрэлсүх агентлагийн удирдлагыг хүндэтгэлийн гэрт хүлээн авч уулзан, тулгамдсан асуудал, санал хүсэлтийг сонсож, илэн далангүй яриа өрнөх үед саналаа танилцуулж, улмаар яаж ийгээд шийдэх чиглэлийг сайдаас өгснөөр 60 гаруй хүн онцгой байдлын албаны офицерууд болж байлаа.

Харин байгууллагын нэр, албан хаагчдын цолны тухайд эрхэлсэн сайд У.Хүрэлсүх, болон зөвлөхөөр нь ажиллаж байсан УИХ-ын гишүүн, Хилийн цэргийн командлагч асан, генерал Д.Базарсад нар шургуу хөөцөлдөж байж, үүний өмнө мөрдөж байсан дотроо шадар, тэргүүн, дээд гэсэн шатлалтай ахлагч нь түрүүч, офицерууд нь дэслэгч, ахмад, комиссар гэсэн цолны ангилалтай болж хуульчлагдаж байсан. Харин албаны дүрэмт хувцасны загвар, цолны ялгах тэмдэг гээд бүгд л цэргийн адилаар батлагдаж, шадар ахмад нь хошуучтай, тэргүүн ахмад нь дэд хурандаатай, дээд ахмад нь хурандаатай гэх хэлбэрээр дүйцэж, цолны нэмэгдлийн хувь хэмжээ нь ижлээр тогтоогдож, олон улсын иргэний хамгаалалт, онцгой байдлын байгууллагын жаягаар цэнхэр өнгийн дүрэмт хувцастай болж байж билээ.

Үүнээс гадна бие бүрэлдэхүүний нийгмийн асуудал урьд байсан хэвээрээ буюу цэргийн байгууллагын нэгэн адил хуульчлагдаж, улмаар Онцгой байдлын албаны 10 хувийн нэмэгдлийг шинээр бий болгосон нь харин чиг илүү давуу талтай болж, энэ бүхэн нь бие бүрэлдэхүүний нийгмийг баталгааг өмнөхөөсөө дордуулахгүй байлгах, цэргийн байгууллагад ажилласан жил нь тасалдахгүй байх, улмаар шинэ тутам байгууллагадаа итгэл үнэмшилтэй, тогтвор суурьшилтай ажиллах томоохон баталгаа болсон гэж боддог.

Эрхэлсэн сайдаар С.Отгонбаяр ажиллаж байх үед машины осол болон ахуйн нөхцөлд хүмүүс бие, гар хөлөө хавчуулахаас эхлээд амьдрал дээр өдөр тутам гарч байдаг бага гэлтгүй гамшиг ослын үед иргэдэд яаралтай тусламж үзүүлэх үйлчилгээ буюу “105”-ыг өөрийнх нь санаачлагаар бий болгож, ОХУ-аас том оврын медведь багаж 2 ком-ыг онгоцоор, улмаар зориулалтын автомашиныг нь БНСУ-аас тус тус захиалан авчруулж ерөнхий газрын дэргэд анхлан байгуулсан нь одоо ч үр дүнгээ өгч байна гэж боддог.

Монгол улсын Шадар сайд М.Энхболд, ерөнхий газрын даргаар Ц.Амгаланбаяр тэргүүн комиссар ажиллаж байх үед Онцгой байдлын албаны цолны асуудал нааштайгаар шийдэгдсэнээс гадна ерөнхий газрын бүтцэд Гамшигтай тэмцэх газар ба Гал түймэртэй тэмцэх газрыг тус тусад салгаж байгуулан, харин доороо урьдын адил төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, тэдгээрийн харъяа аврах, гал унтраах анги болон аврах отрядын хүчээр ажиллах болсон нь үр дүнтэй зөв шийдэл болсон юм болов уу гэж боддог.

Энэ эрхэм хүндтэй, өндөр хариуцлагатай албанд ажиллаж байсан үе үеийн ахмадууд болон одоо байгаа удирдлага, нийт бие бүрэлдэхүүн та бүхэндээ Онцгой байдлын албаны 10 жилийн ойн баярын мэндийг хүргэж, ажлын амжилт, сайн сайхан, эрүүл энхийг хүсэн ерөөе.



Улсын нөөцийн агентлагийн анхны дарга Ц.ӨӨЛД:

## ШИНЭ АЙЛЫН ӨРХИЙГ ТАТАЛЦСАН

Цэвээнжавын Өөлд Улсын нөөцийн агентлаг анх байгуулагдахад даргаар нь томилогдон ажиллаж байсан. УИХ-ын гишүүнээр хоёр удаа сонгогдсон. ХАА-н ухааны доктор /Ph.D/.

Тэрбээр зах зээлийн шилжилтийн хүнд хэцүү цаг үед буюу 1992 оны 8 дугаар сард П.Жасрайн Засгийн газрын Хүнс, хөдөө аж ахуй хариуцсан сайдаар томилогдсон бөгөөд дэлгүүрийн лангуунд хатсан гоймон, бор давснаас өөр хүнсний бараа байхгүй, гурил, элсэн чихэр, цай, мах, будаа зэрэг хүнсний

барааг картаар олгож, тэр нь хүрэлцэхгүйгээс хүмүүс удаан хугацаагаар урт цуваа үүсгэн дугаарлан зогсож, хэрүүл маргаан бухимдлаар дүүрэн хүндхэн цаг үе байсан юм. Энэ байдлаас гарахын тулд П.Жасрайн Засгийн газар болон Ц.Өөлд сайд хамгийн түрүүнд гурилын хангамжийг сайжруулахаас ажлаа эхэлж, гурилын үйлдвэрүүдэд байгаа будааны нөөцийг судлан үйлдвэрүүдийг гурван ээлжээр ажиллуулахаар шийдвэрлэж, хяналт тавих Засгийн газрын төлөөлөгчийг ажиллуулан будаа гурил тээвэрлэх, үйлдвэрлэсэн гурилыг хэрэгцээт газар хүргэх ажлыг шуурхай гүйцэтгэж эхэлсэн юм. Гэвч бэрхшээл их байв. Хүнсний үйлдвэр, худалдаа бэлтгэлийн ангиуд үйлдвэрээс авсан гурилынхаа үнийг хугацаанд нь өгдөггүй, ургацын байдал боломжийн боловч ургац хураах бэлтгэл хангагдахгүй, ихэнхи аж ахуйнууд хувьчлагдаад олон жижиг аж ахуйн нэгж болчихсон, комбайн, трактор, үр цэвэрлэгээний машинуудын сэлбэг хэрэгсэл байхгүй хүндхэн байв. Сэлбэгээр хангах шуурхай хэмжээ авахын тулд салбарын хэмжээгээр дутагдаж байгаа гол нэр, төрлийн сэлбэгийн тоо, хэмжээг гаргаж ОХУ-ын Буриад улсын Эрхүү мужийнхантай холбоо тогтоон төлөөлөгчөө явуулж сэлбэг авчруулан тэр жилийн ургац хураалтыг амжилттай зохион байгуулж байв.

Эрүүл мэндийн сайд П.Нямдаваатай Итали улсад ажиллахдаа холбогдох албаны хүмүүстэй нь уулзаж, 20.0 мянган тонн хатаасан жимс тусламжаар авахаар тохиролцсон бөгөөд хөөцөлдөж байж нөгөөтөхөө гурил болгож, эх орон маш хүнд үед арваад мянган тонн гурил олж ирж байсныг нь П.Жасрай сайд “Тадаадад явсан сайд нар Ц.Өөлд, П.Нямдаваа нар шиг үр дүнтэй ажиллаад ирдэг бол их л сайн байна” хэмээн талархаж байжээ. Ц.Өөлд Улсын нөөц хэмээх шинэ айлын ажлыг аваад хамгийн түрүүнд олон яамдуудын харьяанд байсан нөөцүүдийг эмхлэн авч, дайн байлдааны чиглэлтэйгээр хуримтлуулсан бараа, техник хэрэгслийг чиглэлийн яаманд нь өгч, гамшиг, хүн малын халдварт өвчин, гал түймэр, үер, ган, зуд болоход засаг төрөөс авах арга хэмжээнд зориулан улсын нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх, сэлгэх дүрэм журмуудыг шинээр боловсруулан батлуулж, “Улсын нөөцийн газар” хэмээх шинэ айлыг эмхлэн байгуулсан юм.

Тэр үед улсын нөөц гэдэг үгийг сонссон хүн нөөцөд юу байдаг юм бол, авах бололцоо байдаг болов уу, бас ямар бараа өгч болох бол гэсэн сонирхол ихтэй. Цөөхөн орон тоотойгоор төв аппаратдаа жолоочтойгоо ердөө л найман хүнтэйгээр ажлаа явуулж, шийдвэрээ хамтаараа хэлэлцэн хамтын шийдвэр гаргаж ил тод ажилласан болохоор хардагдах, хууль хяналтын байгууллагад асуугдах явдал гараагүй байна. Миний дараа ажилласан зарим дарга нар хардагдаж, хууль хяналтын байгууллагад асуугдан хүнд байдалд орцгоосон. Хамт олныхоо дунд эрүүл саруул уур амьсгал бий болгож, ажлаа ил тод хийж, шийдвэрээ хуулийн дагуу, хамтаараа ярилцаж гаргасан байвал алдаа бага гардаг, ажиллагсдын тоо ч цөөддөггүй юм билээ.



Улсын нөөцийн дарга асан М.МОЁОР:

### УЛСЫН ЭРХ АШГИЙН ТӨЛӨӨ БИ ТУУШТАЙ ЗОГССОН

Би 1998-1999 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын нөөцийн газрын даргаар ажиллаж байлаа. Байгалийн гамшиг, ган, зуд, үер усны болон бусад гэнэтийн болзошгүй аюул, хүн, малын халдварт өвчин гарсан үед түүнээс хүн ам, мал сүргийг хамгаалах, хүнс тэжээлээр хангах ажлыг хариуцан зохион байгуулах үүрэгтэйгээр 1996 онд шинэчлэн зохион байгуулсан юм. Шинэ тутам байгуулагдсан энэ газар материаллаг баазгүй, өөрийн гэсэн агуулах савгүй, нөөцийн бараа материал нь бусад байгууллагын мэдэлд байдаг, өөрөө ямар ч мэдэлгүй цаасан дээр бичсэн зөвхөн хоосон тоо л байдаг байв. Энэ байдлыг өөрчлөн Улсын нөөцийн бараа материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, болзошгүй аюул учирахад хэрэглэх бараа материалын байнгын бэлэн нөөцтэй байх шаардлагад нийцүүлэн зохион байгуулахын тулд хийх

ажил, цаашид авах арга хэмжээг төлөвлөн Улсын Их Хурал, Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хурлаас тусгай ажлын хэсэг гаргуулан улсын нөөцийн бараа материалыг хадгалж, хариуцаж байдаг газруудад шалгалт хийлгүүлэхэд дараах ноцтой зөрчил илэрсэн юм. Жишээ нь: Хүнс трейд ХХК-ны хариуцан хадгалж байсан Улсын нөөцийн хүнсний бараанаас 2 тэрбум 200 сая төгрөгний үнэ бүхий барааг үрэгдүүлэн, хэсэг бүлэг хүмүүс хуйвалдан бүлэглэж хувьдаа ашиглан завшсан байв. Мөн Бөөний бараа баазын хадгалж байсан 65 сая төгрөгний бараа байхгүй болсон байлаа. Уг барааг хувьчлан хувьдаа авсан байв. Мах комбинадад хадгалж байсан нөөцийн 15 тонн мах огт байхгүй болсон зэрэг дутагдал илэрсэн юм.

Энэ дутагдлыг таслан зогсоох, нөөцийн бараа материалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, нөөцийн барааны тоо хэмжээг нэмэгдүүлэх талаар Улсын Их Хурлын хаалттай хуралдаанаар танилцуулж хэлэлцүүлэн, Их Хурлаас нөөцийн барааг үрэгдүүлсэн буруутай байгууллага хүмүүсийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, улсад учруулсан хохирлыг төлүүлэх арга хэмжээ авахыг Төрийн хянан шалгах хороонд үүрэг болгосон юм. Гэтэл тэр үед Төрийн хянан шалгах хорооны дарга байсан Жавзмаа нь Улсын Их Хурлын шийдвэрийг үл биелүүлж, Улсын нөөцийн барааг үрэгдүүлсэн хүмүүсийн талд орж буруутай хүмүүсийн үйл ажиллагааг шалгахгүй орхисон учир Улсын нөөцийн газар олон тэрбум төгрөгөөр хохирч, ашиглан завшсан хүмүүс хожоод, харин буруутай хүмүүсийн бурууг илрүүлээ гэж намайг буруутан болгож хэлэмэгдүүлсэн түүхтэй билээ. Би Улсын нөөцийн барааг ямар ч хяналтгүй хэсэг бүлэг хүмүүс хуваан авч, хувьдаа завшиж байдаг бусармаг явдлыг илрүүлж, таслан зогсоож чадсан юм. Улсын нөөцөд байх бараа материалын нэр төрлийг олшруулах, тоо хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авч жилд 10 мянган тонн өвс нөөцөлж авдаг байсныг 200 мянган тонн болгон нэмэгдүүлж, хадлангаа өөрөө бэлтгэдэг болох ажлыг эхлүүлсэн. Улсын нөөцөд жил бүр нөөцлөн хадгалж байх улаан буудай үрийн хэмжээг ихээхэн нэмэгдүүлж, үрийн сорт, чанарыг сайжруулах арга хэмжээг авсан. Нөөцийн барааг бусад байгууллагад хариуцуулж, ямарч хяналтгүй болгон үрэгдүүлж байсныг таслан зогсоож, өөрийн мэдэлд авч өөрөө гардан хариуцан хамгаалдаг болгосон.

Аймгуудын нөөцийн газруудыг эмхлэн байгуулж, бэхжүүлэх арга хэмжээг авч, зохих мэдлэг дадлагтай хүмүүсээр хангах арга хэмжээг эхлүүлсэн юм. Улсын нөөцийн байгууллагын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор гадаадын орнуудаас манай улсад суугаа Элчин сайдуудад хүсэлт тавьж тэднээр дамжуулан судлуулах арга хэмжээг авч, бусад улсуудын зохих материалтай танилцаж үзэхэд Манай улсын нөөцийн газрын бүтэц зохион байгуулалт шаардлага хангахгүй байсан юм. Орос, Хятад, Америк улсад гэхэд “Гамшгаас хамгаалах газар”, “Онцгой байдлын газар” “Аюулаас хамгаалах сан” гэх мэт нэртэй, цэргийн зохион байгуулалттай, олон салбараас бүрддэг бүтэцтэй байсаныг судлаж мэдсэн юм. Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ тухай дэлгэрэнгүй танилцуулга бичиж, Олон улсын жишгийн дагуу Улсын нөөцийн газрын одоогийн бүтцийг өргөтгөн өөрчилж, тусгай хуультай болгох саналыг анх санаачлаж асуудал болгон тавьж байлаа.

Төр засгаас анхаарч бүтцийн өөрчлөлтийг хийж, Улсын Иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газар, Улсын галын аюулаас хамгаалах газруудыг нэгтгэн 2004 онд Гамшгаас хамгаалах ерөнхий газар нэртэйгээр байгуулж нэг жилийн дараа буюу 2005 онд нэрийг нь Онцгой байдлын ерөнхий газар гэж өөрчилсөн билээ. Энэ зохион байгуулалт нь дэлхийн хөгжилтэй улс бүрт байдаг сайн жишиг болсон юм.



*Улсын нөөцийн хамт олон 1998 он*

Улсын нөөцийн талаар иргэд юу ч мэддэггүй, нууц байдалд ямар ч хяналтгүйгээр байдаг, түүнийг нь эрх мэдэлтнүүд хувьдаа ашиглан завшдаг байсныг анх илрүүлж, хяналт, хамгаалалттай болгох гэж шударга ёсыг баримтлан би тууштай тэмцсэн боловч хүчинд автагдан ялагдсан. Тэд хуйвалдан, хуваан завшсан хэргээ нуухын тулд улайран тэмцэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж хууль хяналтын байгууллагыг өөрийн талд татан оролцуулж, улсын хөрөнгийг үлэмж ихээр

ашиглан завшсан, бузар үйл ажиллагаагаа нууж чадсан юм. Улсын хөрөнгийг олон тэрбумаар нь хувьдаа авч, тэр хөрөнгөөр баяжсан зарим хүмүүс өнөөдөр Улсын их хурлын гишүүн болж, төрийн өндөр алба хашиж, ичих булчирхайгүй болсон амьтан явж байгааг хараад түүний өмнөөс би ичдэг юм. Улаан буудайн үрийг Улсын нөөцөд хадгалж, хавар тариа тарьдаг аж ахуйн нэгжүүдэд ХААЯ-ны хуваарь, шийдвэрээр зээлээр өгч, намар эргүүлэн авдаг байв. Гэтэл хавар зээлээр авсан үрийн буудайгаа намар эргүүлж өгдөггүй олон аж ахуйн нэгжүүд байснаас болоод улсын нөөцөд байх үрийн буудайг эрс багасч, дампуурч байсан юм. Манай мэргэжилтэн, ажилтан албан хаагчид өр нэхэх ажилд үлэмж цагаа зарцуулдаг гаж тогтолцоо буй болсон байдлыг арилгах арга хэмжээг авч, өртэй байгууллагад үрийн буудайг олгодоггүй болгож, хавар үрийн буудайг өгөхдөө үнийн дүнгийн 30 хувийн урьдчилгааг заавал авдаг журамтай болгосон билээ. Гэтэл энэ арга хэмжээг зарим аж ахуйн нэгжүүд эсэргүүцэн хэл ам, хэрүүл тэмцэл хийж, зарим сайд, дарга нар ч аж ахуйн нэгжүүдийн талд орж манайхаас авч байгаа арга хэмжээг эсэргүүцэж, ажил хүндрүүлж, буруутай байгууллага хүмүүсийн талд орж намайг буруутган ажлаас өөрчлөхийн төлөө хүч хавсаран тэмцэж байв. Би хувийн эрх ашгийг урьдал болгодоггүй, улсын эрх ашгийн төлөө тууштай зогсдог байснаасаа болж ажлаас халагдаж билээ. Энэ талаар шүүхэд гомдол гаргахад шүүх намайг үндэслэлгүй ажлаас халсан байна гэж тогтоосон юм. Би ажилдаа эргэж орох сонирхолгүй байна гээд орхисон болно.

Миний дараа нөөцийн газрын дарга болсон Бямбаноров, Онцгой байдлын ерөнхий газрын дарга болсон П.Даш нар мөн л шударга ёсыг баримтлан, улсын нөөцийн хөрөнгийг хуйвалдан хувааж завшдаг эрх мэдэлтний эсрэг шударгаар ажилласанаасаа болоод хилс хэрэгт буруутгагдан, хэл аманд орж, ажлаас өөрчлөгдөж, хэлмэгдсэн гашуун сургамж давтагдсан болно.



УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хөдөлмөрийн сайд  
Я.САНЖМЯТАВ:

## УЛСЫН НӨӨЦИЙН ХУУЛИЙГ БАТЛАЛЦСАНДАА СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙДАГ

Миний бие Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 20-ны 168 дүгээр тогтоолоор Улсын нөөцийн газрын даргаар томилогдон, ажлаа хүлээн авч байх үедээ “... бодох, зохион байгуулах олон ажил, асуудал байна. Юуны өмнө нөөцийн тухай хууль, газрын бүтцийг эргэн харах шаардлагатай юм байна. Ажлын хариуцлагыг улам өндөржүүлж эрчимтэй ажиллах, оршиж байгаа дутагдал зөрчлийг арилгахад гол анхаарлаа чиглүүлж өндөр хариуцлага тавьж ажиллах болно” гэж хэлж байснаа санаж байна. Тэгээд ч Засгийн газрын хэрэгжүүлэгч томоохон агентлагийг удирдах болсон залуу хүний хувьд ажилдаа ханцуй шамлан орж, юуны өмнө ажиллагсдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх тухай тушаал, албан даалгавар гарган, бусдад нь анхааруулга дохио өгөх үүднээс ажил албандаа тэнцэхгүй байгаа гэж үзсэн харъяа байгууллагын зарим нэгэн удирдах албан тушаалтныг чөлөөлөх хүртэл арга хэмжээ авч, ажлаа эрч хүчтэй эхэлж байлаа.

Газрын даргын төв, орон нутгийн улсын нөөцийн салбарын эрхлэгч нартай байгуулах үр дүнгийн гэрээнд талуудын хүлээх үүрэг хариуцлагыг тодорхой болгож, салбарын эрхлэгч нарын зүгээс мэргэжил, дадлагадаа тулгуурлан газар тариалан эрхлэх, хадлан тэжээл бэлтгэх, жижиг үйлдвэрлэл явуулах замаар үйл ажиллагааны зардлынхаа тодорхой хэсгийг олох, харин газрын даргын зүгээс материаллаг баазыг бэхжүүлэхэд анхаарч, үр тариа, өвс тэжээл, бараа материал бэлтгэх зардлыг улсын төсөвт суулгах замаар шийдвэрлэж өгч байх үүргийг хүлээх заалтыг тусгаж байсан. Үүнийгээ хэрэгжүүлэх үүднээс сайдтай байгуулах өөрийнхөө үр дүнгийн гэрээнд холбогдох заалтыг тусгаж, зарим салбарыг улсын нөөцөд ондуулан жил хадгалагдаж байсан, ОХУ-д үйлдвэрлэгдсэн ачааны шинэ автомашинтай, үр тарианы салбаруудыг орчин үеийн чийг хэмжигч багажтай болгож байж билээ.

Улсын нөөцийг төрийн мэдэлд нэг гарт төвлөрүүлэх ажлын хүрээнд “Хүнс трейд” УУГ-ын хувьчлалтай холбогдуулан эрчимтэй хөөцөлдсөний үр дүнд Төрийн өмчийн хорооны тогтоолоор зориулалтын 4 том агуулах, талбай, төмөр замын салааг балансаас балансад улсын нөөцийн бараатай нь шилжүүлэн авснаас гадна Ховд аймагт шүүхийн шийдвэрээр хүнсний агуулах, талбайг авч улсын нөөцийн хадгалалт, хамгаалалтын асуудлыг сайжруулж байлаа. Үүнээс гадна уул уурхайн үйлдвэрлэлийн чухал материалын нэг тэсэрч дэлбэрэх бодисын нөөцийн үлдэгдэлгүй байсанд анхаарч, юуны өмнө байршлыг нь өөрчлөх асуудлыг дээд шатны байгууллага, удирдлагад танилцуулж шийдвэрлүүлсэн. Энэ хүрээнд хадгалах зориулалтын агуулах, байртай, мэргэжлийн байгууллага гэдэг үүднээс Багануурын уурхайг сонгож, тодорхой хэмжээний нөөцийг бий болгосон нь тухайн үед Засгийн газрын шийдвэрээр Шарын гол зэрэг томоохон уурхайнуудад нийлүүлэгдэж, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг нь хангахад дэмжлэг үзүүлж байсан.

Улс орныхоо талх, гурилын хэрэгцээг хангах, зах зээлийн эдийн засгийн шилжилтийн он жилүүдэд уналтад орсон газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, ган зудаас болж ургац алдсан тариаланчиддаа дэмжлэг үзүүлэх үүднээс улсын нөөцөөс үрийн буудайг олон жил зээлээр олгож ирсэн байдаг. Намайг ажил авч байх үед тариаланчдын бэлэнчлэх сэтгэлгээ хэт хавтгайрч, улмаар үнэгүй юманд нухасгүй гэдэг шиг хэн дуртай нь хаа хүссэн газраа тариа тарих хандлага ажиглагдаж, тэр хэмжээгээр нөөцийн өр авлага нэмэгдэж байсан. Иймээс үрийн буудайг зээлээр олгохыг зогсоох асуудлыг хөндөж, эхний удаад 30 хувийг урьдчилгаа төлбөр авч байж олгох журмыг гаргуулж байсан нь нэг талаас эдийн засгийн хувьд тодорхой хэмжээний хөшүүрэгтэй болгосон, нөгөө талаас нөөцийн бэлэн байдлыг дээшлүүлж, цаашид нөхөн бүрдүүлэх боломжийг төдий хэмжээгээр нэмэгдүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон нь дараа намрын ургац хураалтын үеэр улсын нөөцийг нөхөн бүрдүүлэхэд шууд мэдрэгдэж байж билээ.

Мөн гаднаас сайн чанарын үрийн буудай импортлох нөхцөл боломж ч гарч ирж байлаа.



Тухайн үед улсын нөөцөөс аж ахуйн нэгж, иргэд их бага хэмжээгээр зээл авч, нэг хэсэг нь төрийн дэмжлэгийг ойлгон өр авлагаа цаг хугацаанд нь эргүүлэн төлдөг байсан хэдий ч улсаас авсан өр зээлээ төлөхөөс зайлсхийдаг, зугтдаг, хэн зальтай нь завшиж, тэр хэмжээгээр улсын сан хөмрөг дундрах, өр авлагын хэмжээ жилээс жилд нэмэгдэх байдал газар авах хандлага байсан тул хэдийгээр эрсдэлтэй байсан ч олон олон аж ахуй, иргэдийг шүүхэд өгч, өр авлагыг тодорхой хэмжээгээр барагдуулж, энэ чиглэлд ахиц гаргаж байлаа. Тэрчлэн ажил авах үед улсын нөөцийн хууль эрх зүйн орчинг сайжруулах зайлшгүй шаардлага харагдаж байсан, тиймээс бусад орны туршлага, өөрийн орны онцлогт тулгуурлан өмнө нь төслөөр боловсрогдсон байсан хуулийн төсөл дээр дахин ажиллаж, Засгийн газрын хуралдаанд оруулж, улмаар УИХ-ын байнгын хороонд хүргүүлсэн боловч хараахан шийдвэрлүүлж амжилгүй УИХ-ын бүрэн эрхийн хугацаа нь дууссан. Харин сүүлд намайг Завхан аймагт бие даан нэр дэвшиж, сонгогдон УИХ-ын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар ажиллаж байх үед уг хуулийн төсөл УИХ-д өргөн баригдахад энэ салбарыг удирдаж явсан хүний хувьд санал бодлоо тусган, гар бие оролцон батлалцаж, олон жилийн өмнө хийхээр бодсон ажлаа нэг мөр болгон гүйцэлдүүлэх нөхцөл боломж гарч байж билээ.

Эцэст нь Улсын нөөцийн газрынхан маань төв аппаратаасаа эхлээд харъяа салбарын удирдлага, ажилтнуудын хувьд дийлэнх нь уг албандаа харьцангуй олон жил ажилласан, ажилдаа хулгайн нүд, хоноцын сэтгэлээр ханддаггүй, хат суусан төрийн албан хаагчид, туршлагатай хамт олон байсныг зориуд тэмдэглэн хэлэхийг хүсч байна. Ийм хүмүүстээ, тэдний үр хүүхдүүдэд төр талархах учиртай гэж боддоггоо ч нуух юун. Ингээд Онцгой байдлын байгууллагын 10 жилийн ойг тохиолдуулан тус албанд хүчин зүтгэж явсан үе үеийн ахмадууд, одоо ажиллаж байгаа нийт хамт олонд болон тухайн үед надтай гар сэтгэл нийлэн хамтран ажиллаж байсан бүх хүмүүс, тэдгээрийн үр хүүхдэд баярын мэнд хүргэж, сайн сайхныг хүсэн ерөөж байна.



улсын нөөцийн дарга асан Ж.БЯМБАНОРОВ:

## ӨР БАРАГДУУЛАХ АЛБЫГ БАЙГУУЛСАН

Ж.Бямбаноров нь Улсын нөөцийн газрын даргаар томилогдохоос өмнө Төв аймагт Үнэ чанарын хэлтсийн дарга, МАХН-ын төв хороонд зааварлагч, Сэлэнгэ аймгийн Засаг даргаар болон хувийн хэвшилд ажиллаж байсан ажил амьдралын арвин их туршлагатай, багаар ажиллах арга барилыг эзэмшсэн, хамтран ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдынхаа амьдрал ахуйг ямагт анхаарч, тус дэм өгдөг төдийгүй тус байгууллагыг материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөцийг чадваржуулах талаар их ажлыг зохион байгуулсан хүний нэг билээ.

2001 онд Улсын нөөцийн газрын даргаар Ж.Бямбаноров, дэд даргаар Т.Ганболд, Тамгын хэлтсийн дарга, хуулийн зөвлөхөөр П.Баянмөнх, Нөөцийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэнгээр П.Батаахүү, Санхүү бүртгэл, хяналтын хэлтсийн даргаар Л.Даваа, бичиг хэрэг, архивчаар Оюунгэрэл, Номинчулуун, бичээч, мөнгөн кассын нярав Д.Сосор, тооцооны нягтлан бодогчоор Д.Тунгалаг, Л.Өлзийбаяр, улсын нөөцийн бараа, материал хариуцсан мэргэжилтнээр Ж.Амарсанаа, Д.Жаргалсайхан, ЖЦ.Бямбарагчаа, О.Ганбаатар, Д.Отгондорж, Д.Болдбат, Тамгын хэлтсийн мэргэжилтнээр Б.Жаргал, Ч.Отгончулуун, жолоочоор А.Ганбаатар, Мөнхбат, Ган-Очир, Буянтогтох нар томилогдон ажилласан бөгөөд мөн тушаалаар орон тооны бус өр барагдуулах албаны бүрэлдэхүүнийг томилж, даргаар нь П.Баянмөнх, гэрээт шийдвэр гүйцэтгэгч Н.Батмөнх нар ажиллаж байв.

Улсын нөөцөд хуримтлуулан хадгалах бараа, материалын гэрээг тухайн үйлдвэрлэгч байгууллагатай нь шууд гэрээ байгуулан худалдан авдаг байсан олон талын ач холбогдолтой байсан юм.

Түүнчлэн улс оронд жил дараалан ган, зудын аюул нүүрлэсэн цаг байсан бөгөөд гадаад орнуудын /Япон, БНХАУ, Вьетнам/ буцалтгүй тусламжаар бараа, материалыг 18 аймгийн 300 гаруй сумдад биечлэн хүргэх хариуцлагатай бөгөөд амаргүй ажлыг тухайн үеийн Улсын нөөцийн газрын бие бүрэлдэхүүн амжилттай сайн хэрэгжүүлсэн нь холбогдох улсуудын Элчин сайдын яам болон Монгол Улсын Засгийн газраас өндөр үнэлэлт авч байсан билээ.

Улсын нөөцийн газрын даргаар ажиллах хугацаандаа улсын нөөцийн бараа, материалыг тээвэрлэн байршуулах Автотээврийн хэсгийг байгуулж, даргаар нь Батмөнхийг томилон ажиллуулсан нь оновчтой бөгөөд улсын төсвийн зардлыг хэмнэхэд онцгой үүрэг гүйцэтгэж байв.

Төв аппаратынхаа ажилтан албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд шат дараатай олон арга хэмжээг авч байсан бөгөөд ХАА-н ухааны доктор зэргийг Тамгын хэлтсийн дарга П.Баянмөнх хамгаалж, удирдахуйн ухааны магистрийн цол зэргийг бүх мэргэжилтнүүд суралцан хамгаалсан билээ.



Улсын нөөцийн хамт олон 2001 он



*Удирдах ажилтны цугларалт 2012 он*



Онцгой байдлын асуудал эрхэлсэн анхны сайд томилогдов.

Онцгой байдлын албаны туг далбааг баталлаа.



Улсын их хурлын шийдвэрээр Онцгой байдлын ерөнхий газрыг байгуулав.



Гадаад харилцаа өргөжин тэлэв.

Албан үүргээ нэр төртэй гүйцэтгэж яваад амь эрсэдсэн аврагч дайчиддаа зориулан гэрэлт хөшөө босгов.

2004 он


2005 он

2007 он

2008 он

2009 он

Засгийн газрын хуралдааны нэгдүгээр тогтоолоор тус Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг байгуулав.



Гамшиг судлалын хүрээлэн байгуулагдав.



Т.Отгон, Г.Нэргүй нар Монгол Улсын Үйлчилгээний Гавьяат ажилтан цолоор шагнагдлаа.



аврагчид орон сууцтай болов.

Онцгой байдлын албаны ёслолын болон хээрийн хувцасны загварыг батлав.



Тусгай мэргэжилийн сургалтын төв байгуулагдав.



Монголын аврагчид энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхлэв.

Марш тактикийн гэмцээнд 2 дугаар байр эзэллээ.



“Нарны жим” олон ангит уран сайхны кино дэлгэцнээ.



2010 он

2011 он

2012 он

2013 он

2014 он



Монголын аврагчид анх удаа олон улсын аврах ажиллагаанд оролцлоо.

Япон улсын тусламжаар парк шинэчлэл хийгдэв.



Спортын ордонтой болов.



Онцгой байдлын сургуультай болов.



Урлагийн их наадам зохион байгуулав.